



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ



JAPAN GOV  
THE GOVERNMENT OF JAPAN



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Save the Children

# БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



ЭНТРЕПЕНЕРШИД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР  
ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТ

ХАРИЛЦАН СУРЬЯ  
ХАМТДАА БҮТЭЭ

2025



ЭНТРЕПРЕНЕРШИД СУУРМЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТ



# БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

ХАРИЛЦАН СУРЬЯ  ХАМТДАА БҮТЭЭ



Дижитал хувилбарт шилжлээ.

## ТӨСЛИЙН ТАЛААР ТОВЧ

Хүүхдийг Ивээх Сангаас Дэлхийн банк болон Япон улсын “Нийгмийн хөгжлийн сан”-гийн дэмжлэгтэйгээр хөдөө орон нутгийн хүүхэд, залуусын бүтээлч, энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төслийг Монгол улсын баруун, зүүн, төвийн болон хангайн бүсийн төлөөлөл болох Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн 25 суманд хэрэгжүүлэв.

ISBN:



9 789919 920920

©Хүүхдийг Ивээх Сан 2025

Энэхүү сургалтын гарын авлага нь Хүүхдийн Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн өмч бөгөөд худалдаалах болон албан ёсны зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.  
*Нэмж засварласан гурав дахь хэвлэл.*

Номын дизайн: **Номун Ерөөл ХХК**

# Талархал

Төслийг санаачлан хэрэгжүүлэгч Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс энэхүү “Энтрепренершипд Суурилсан Хувь Хүний Ур Чадварыг Хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийг боловсруулсан төслийн зөвлөхүүддээ гүн талархал илэрхийлье.

Хатагтай **Барбара Фриймэн**

*Хувь Хүний Ур Чадвар, Энтрепренершипийн Олон Улсын Зөвлөх*

Ноён **Эрдэнэбатын Бат-Орших**

*Энтрепренершипийн Үндэсний Зөвлөх*

Хатагтай **Пүрэвдоржийн Оюунаа**

*Боловсролын Үндэсний Зөвлөх, Боловсролын Үндэсний Зөвлөх Багийн Ахлагч*

Хатагтай **Сэдийн Санжаабадам**

*Боловсролын Сэтгэл Судлалын Үндэсний Зөвлөх*

Хатагтай **Амгалангийн Энхтогтох**

*Сургалтын Агуулгын Үндэсний Зөвлөх*

Хатагтай **Базарханы Харашаш**

*Сургалтын Агуулгын Үндэсний Зөвлөх*

ESEL хөтөлбөрийн сургалтад өөрсдийн боловсруулсан видео контентийг үнэ төлбөргүй ашиглах зөвшөөрөл олгож үнэтэй хувь нэмэр оруулсан дараах өгөөмөр сэтгэлтэй байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

**WEMAKE** - [www.wemake.no](http://www.wemake.no)

**Lessons for SEL** - [www.lessonsforSEL.com](http://www.lessonsforSEL.com)

**BBC Brainsmart** - <http://www.bbc.co.uk/scotland/brainsmart>

**Швейцарын Хамтын Ажиллагааны Газар - Залуучуудын Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Төсөл** - <https://www.eda.admin.ch/countries/mongolia/en/home/representations/cooperation-office.html>

**Хорват улсын CEDRA төрийн бус байгууллага** - [www.cedra.hr](http://www.cedra.hr)

**Лантуун Дохио ТББ** - <http://lantuu.mn/lantuuuu/>

**SPROUTS LEARNING Компани** - [www.sproutsslchools.com](http://www.sproutsslchools.com)

**Ноён Evelio Pereira** - [www.epicster.com](http://www.epicster.com)

**Strategyzer AG Компани** - [www.strategyzer.com](http://www.strategyzer.com)

**Pinellas захиргааны байгууллага** - <http://www.pinellascounty.org/>

**Орхон аймгийн Баян-Өндөр сум** - [www.bayan-undur.mn](http://www.bayan-undur.mn)

**Жаргалант сумын ЗДТГ** <http://www.erdenet.mn/lavlah/organ.php?id=130800005>

**Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сан** - [www.smefund.gov.mn](http://www.smefund.gov.mn)

**Мандал Даатгал ХХК** - [www.mandal.mn](http://www.mandal.mn)

# АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	8
Багшид зориулсан тэмдэглэл	10
Сургалтын хөтөлбөрийн тухай	13
Хөтөлбөрийн зорилго, зорилт	13
Хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс	13
Сургалтын арга зүй	17
Сургалтын нэмэлт стратеги	20
Хөтөлбөрийн агуулга ба суралцагчийн мэдлэг, чадвар сэтгэлгээний уялдаа	23
Суралцагчийн үнэлгээ	26
Сургалтын зохион байгуулалт	48
Сургалтын цагийн хуваарь	53
<b>СЭДЭВ 1: МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР</b>	57
1.1 Хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэл	61
1.2 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних	62
1.3 Цагийн менежмент	68
СЭДЭВ 1-ИЙН ҮНЭЛГЭЭ	72
<b>СЭДЭВ 2: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА</b>	73
2.1 Энтрепренершип гэж юу вэ?	74
2.2 Энтрепренершипийн арга замууд	78
2.3 Энтрепренершипийн оролцогч талууд	82
СЭДЭВ 2-ЫН ҮНЭЛГЭЭ	85
<b>СЭДЭВ 3: ЭНТРЕПРЕНЕРШИП ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД</b>	86
3.1 Тухайн орон нутаг, бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тодорхойлох	87
3.2 Ялгаатай хэрэгцээг таних	91
3.3 Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх, өөрсдийн санааг хөгжүүлэх	95
СЭДЭВ 3-ЫН ҮНЭЛГЭЭ	99

<b>СЭДЭВ 4: ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ</b>	100
4.1 Энтерпренершип санаа хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломж, саад бэрхшээл	101
4.2 Санхүүгийн нөөц	106
4.3 Бизнес төлөвлөлт	109
4.4 Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэл, түүнийг бууруулах арга зам	113
СЭДЭВ 4-ИЙН ҮНЭЛГЭЭ	116
<b>СЭДЭВ 5: ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ</b>	117
5.1 Энтерпрайз төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт	118
5.2 Энтерпрайз төслийн явц, үр дүнгийн тандалт	122
5.3 Төслийг үнэлж дүгнэх	125
СЭДЭВ 5-ЫН ҮНЭЛГЭЭ	129
<b>СЭДЭВ 6: ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ</b>	130
6.1 Төслийг сайжруулах	131
<b>СЭДЭВ 7: ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ</b>	133
7.1 Төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх	134
7.2 Санхүүжилт авах шаардлагын дагуу төсөл боловсруулах, төслийн сонгон шалгаруулалтад оролцох	137
7.3 Төслийн санааг хөгжүүлэх боломжийг тодорхойлох, тасралтгүй хөгжүүлэх	140
<b>ХАВСРАЛТ 1. Өөрийгөө таньж мэдэх тухай</b>	143
<b>ХАВСРАЛТ 2. Цаг төлөвлөлт яагаад чухал вэ?</b>	144
<b>ХАВСРАЛТ 3. Энтерпренершип ойлголт, хамрах хүрээ</b>	145
<b>ХАВСРАЛТ 4. Энтерпренершип төрлүүд</b>	148
<b>ХАВСРАЛТ 5. Энтерпрайз санаануудын жагсаалт</b>	153
<b>ХАВСРАЛТ 6. Төслийн зарим шалгуур үзүүлэлтийн жишээ</b>	154

# НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР



## ENTERPRISE

Ихэвчлэн мөнгө олох зорилготой бизнесийн болон бусад хэлбэрийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага (<https://dictionary.cambridge.org/dictionary/english/enterprise>)



## BUSINESS ENTERPRISE

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон борлуулалттай холбоотой үйл ажиллагаа эрхлэн ашиг олдог этгээдийг хэлнэ. (<https://bizfluent.com/about-6721330-business-enterprise-.html>)



## SOCIAL ENTERPRISE

Зөвхөн ашиг олох зорилгоор бус, нийгмийн сайн сайхны төлөө явуулж буй нийгэм, хүмүүнлэг болон экологийн чиглэлийн үйл ажиллагаа. (Гарааны бизнес, түүнтэй холбогдох нэр томьёоны тайлбар толь, 2016)



## ENTREPRENEUR

Ажил олгогч,  
Бизнес эрхлэгч

Шинэ аж ахуй, бизнес, нийгмийн тустай үйл ажиллагаа эхлүүлэх болон зохион байгуулах санхүүгийн эрсдэлийг үүрч буй хүнийг хэлнэ. (Cambridge International AS and A Level Business Coursebook Third Edition. Peter Stimpson and Alastair Farquharson. Page 11)



## ENTREPRENEURSHIP

Бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, ашиг олох зорилгоор бизнес эрхлэх үйл ажиллагаа. (Гарааны бизнес, түүнтэй холбогдох нэр томьёоны тайлбар толь, 2016)



## MONEY

Мөнгө

Үнэ цэнээ хадгалдаг, төлбөрийн хэрэгсэл болон өртгийн хэмжүүрийн үүрэг гүйцэтгэдэг хэрэгсэл юм. (<https://www.merriam-webster.com/dictionary/money>)







## INCOME

Орлого

Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчдад зарж борлуулснаас олох мөнгө. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## EXPENSE

Зардал

Ямар нэгэн зүйлийг олж авах, худалдан авахад төлж буй дүн. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## RISK

Эрсдэл

Мөнгөө алдах, алдагдал хүлээх магадлал, мөн тодорхой бус байдлыг хэлнэ. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## SAVING

Хадгаламж

Санхүүгийн дансанд хуримтлуулахаар байршуулсан мөнгөн хөрөнгө. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## INSURANCE


Даатгал

Даатгалын компаниас эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд хохирол учирвал нөхөн төлбөр олгох баталгаа. Даатгалд хамрагдахын тулд зохих хураамжийг төлснөөр энэхүү баталгааг худалдан авна. (Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, Монголбанк, 2015)

## MIND MAPPING

Оюуны зураглал

Энэ нь ямар нэг бүтэц эсвэл дарааллын тухай бодолгүйгээр өөрийн оюун бодлоо зохион байгуулах хялбар арга бөгөөд ямар нэг асуудалд дүн шинжилгээ хийх, сэргээн санахын тулд бодлоо зураглах боломжийг олгодог. Оюуны зураглалаар дамжуулан гол асуудалтай холбоотой санаа, ухагдахуун болон үзэл санааг шугаман бус график ашиглан илэрхийлж чаддаг.



## БАГШИД ЗОРИУЛСАН ТЭМДЭГЛЭЛ



Энэхүү гарын авлага нь энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын багшид сургалтыг удирдан зохион байгуулах, суралцагчдын танхимын болон танхимын бус үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх, дэмжлэг үзүүлэх зорилготой болно.

Гарын авлагын эхний хэсэгт сургалтын хөтөлбөрийн талаарх тайлбар, суралцахуйн онолын үзэл баримтлал, сургалтын арга зүйн онцлогийн талаар тусгасан. Мөн ЕБС болон насан туршийн суралцахуйн төвийн суралцагчдын түвшинд сургалтын зохион байгуулалтыг хэрхэн хангах, үнэлгээг хэрхэн хийх талаарх агуулгыг тусгасан болно.

Гарын авлагын дараагийн хэсгүүд нь сургалтын хөтөлбөр дэх **7 сэдэв**, түүний **21 дэд сэдвийн** дагуу бичигдсэн бөгөөд дэд сэдэв бүрээр сургалтын зорилго, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүн, бэлтгэл, үйл ажиллагааг багш хэрхэн удирдан чиглүүлэх, ямар асуулт асуух, даалгавар гүйцэтгүүлэх, дараагийн сургалтын бэлтгэлийг хэрхэн хангах, сорил, даалгавар, төслийг танхимын бус сургалтаар ямар хугацаанд гүйцэтгэх талаар тайлбарласан. Тодруулбал, дэд сэдэв бүрээр дараах байдлаар багшид дэмжлэг үзүүлэхээр бичигдсэн. Үүнд:

1. Дэд сэдэв бүрийн зорилго буюу суралцагчдад ямар мэдлэг, чадвар эзэмшүүлэх, сэтгэлгээ төлөвшүүлэх
2. Тухайн сургалтад ашиглагдах нөөц хэрэглэгдэхүүн, материалын жагсаалт
3. Тухайн сургалтад багшийн анхаарах асуудлуудыг мөн тусгасан. Багш ажиглалтын рубрик хуудас ашиглан суралцагчдын хувь хүний ур чадварын илрэлийг ажиглах, түүний дагуу тухайн суралцагчийг чиглүүлэх нэмэлт арга зүйг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.
4. Тухайн сургалт танхимд болон танхимын бусаар үргэлжлэх хугацааг тодорхойлсон бөгөөд ямар үйл ажиллагаа, сорил, даалгавар, төсөл гүйцэтгэхийг тайлбарласан болно.
5. Үүний дараа үйл ажиллагаа тус бүрд холбоотой нэмэлт тайлбар, багшийн асуух асуултын санаа,



сорил, даалгавар, төслийг чиглүүлэх удирдамж, суралцагчийн гарын авлага дахь ажлын хуудас, хүснэгт, төслийн бүрэлдэхүүн зэргийг үзүүлээ.

6. Тухайн дэд сэдвийн хүрээнд суралцагчийн ямар мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрхэн үнэлэх тухай саналаа тусгасан.
7. Дараагийн сургалтын бэлтгэлийг хэрхэн хангах
8. Багийн менежерүүдтэй хэрхэн ажиллах

Түүнчлэн зарим дэд сэдвүүдэд шинээр орох ухагдахуунтай холбоотой нэмэлт мэдээллийг оруулсан.

Сэдэв бүрийн төгсгөлд суралцагчдын эзэмшсэн **мэдлэг, чадвар, сэтгэлгээг үнэлэх сорилыг** оруулсан бөгөөд үүнийг суралцагч болон багш хэрхэн гүйцэтгэх талаарх агуулгыг үзэж болно.

Гарын авлагын **хавсралт** хэсэгт сургалтын явцад багшид зайлшгүй ашиглах бичвэр, слайд, зарим санаануудыг тусгасан.

Энэхүү гарын авлага нэмэлт хэрэглэгдэхүүнтэй. Эдгээр нь сургалтын явцад ашиглах **видеоууд, илтгэлийн слайдууд** бөгөөд эдгээрийг хэрхэн, хэзээ ашиглахыг гарын авлагад тодорхой тусгасан болно.

Багшийн гарын авлагыг суралцагчийн гарын авлагын хамт хэрэглэнэ.

Багш сургалтыг зохион байгуулахдаа энэхүү гарын авлагад баригдах шаардлагагүй бөгөөд **өөрийн санаа, арга зүйгээр баяжуулах** боломжтой.

**Энтрепренер сэтгэлгээ болон чадвар** нь энтрепренершипийн бодит үйл ажиллагаа, төслийг суралцагч өөрөө хийж гүйцэтгэж байж сайн сурна<sup>1</sup>. Тиймээс энэхүү сургалтын үйл ажиллагаа суралцагчдын идэвхтэй оролцоо, багийн ажиллагаа, суралцагч-суралцагч болон суралцагч-багш хоорондын харилцаанд түшиглэн тухайн орон нутгийн нийгмийн болон бизнесийн орчны бодит хэрэгцээ, тулгамдаж буй асуудлын шийдлийг олон хувилбараар хамтран эрэлхийлэх үйл ажиллагаанд тулгуурлана гэдгийг анхаараарай. Энтрепренершипийн үйл ажиллагаа нь багшийн болон суралцагчийн гарын авлагад алхам алхмаар тусгагдсан учраас багш та сургалтын явцад суралцагчийн хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд голлон анхаарах шаардлагатай.

Сургалтын явцад суралцагчдад мэддэг, чаддаг зүйлээ ашиглах боломжийг олгох хэрэгтэй. Хичээл эхлэхээс өмнө тэдний өмнөх мэдлэг, чадвар, туршлагыг тандаж, мэдэхгүй, чадахгүй асуудалтай тулгарсан ч түүнийг шийдэх явцад ямар нэг зүйл сурч байдаг гэдгийг сануулаарай. Суралцагч асуудал шийдвэрлэгч болж хөгжих ёстой. Суралцагчийн үйлдэл, тайлбар, асуултын хариултыг шууд зөв, буруу гэж шүүлгүйгээр **“яагаад”** гэж байнга асууж байгаарай. Тэдний аливаа асуудлыг харах өнцөг таныхтай ижил байх албагүй гэдгийг санаарай. Сургалтын бүхий л үйл ажиллагаа тэднийг “хайрцагнаас” гадуур боддог, үйлддэг, сэтгэдэг болгоход чиглэх хэрэгтэй. Тэгж байж тэд өөртөө итгэлтэй, асуудлыг олон талаас харж дүгнэдэг, бусдыг ойлгодог, өөрийн үйлдлийн зөв бурууд дүгнэлт хийдэг, бусдыг сонсдог болж хөгжинө. Эдгээр нь хувь хүний маш чухал ур чадвар юм шүү.

Бэрхшээлтэй тулгарч буй суралцагчид шууд туслах гэж бүү оролд. Түүний оронд өөрөө алдаагаа олж харах, юунаас болоод бэрхшээлтэй байгаагаа таньж мэдэхэд туслах, сэдэлжүүлэх асуулт асуух, шийдлээ олох алхмуудыг нь чиглүүлэх замаар өөрөө амжилтад хүрэхэд нь туслаарай.

Сургалтын явцад багшийн үүрэг бол суралцагчийг ямар нэг агуулгыг мэддэг, гарын авлага дахь даалгаврыг гүйцэтгэж чаддаг, багшийн зааснаар бодож сэтгэдэг болгох биш ямар ч асуудал байсан түүний учир шалтгаан, шийдлийг өөрөө **“боддог”, “эргэцүүлдэг”, “дүгнэдэг”, “өөрийн үйлдлийн үр дагаврыг хянадаг, удирддаг”, “бусадтай хамтардаг”** болоход тусалж дэмжих нь чухал юм.

Төгсгөлд нь хэлэхэд энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт таны мэргэшсэн судлагдахуун биш учраас та орон нутгийн бизнес эрхлэгчид, туршлагатай хүмүүс, зөвлөх, менторууд, хамт ажилладаг багш нартай зөвлөлдөж, хувь хүний ур чадварыг хөгжүүлэх стратегийн талаар мэдээллийн төрөл бүрийн нээлттэй эх сурвалж ашиглан өөрийгөө тасралтгүй хөгжүүлэхийг хичээгээрэй. Нэг талаар энэ нь танд энэ сургалтыг удирдан чиглүүлэхэд хэрэгтэй ч гэсэн нөгөө талаар таны хөгжилд үнэлж баршгүй их ач холбогдолтой байх болно.

**Танд амжилт хүсье.**



Танхимын сургалтын үйл ажиллагаа



Танхимын бус сургалтын үйл ажиллагаа

# СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

## Хөтөлбөрийн зорилго, зорилт

Сургалтын хөтөлбөр нь **14-25 насны хүүхэд залуучуудад** бие дааж ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой. Энэхүү сургалт нь **энтрепренершип** болон хувь хүний ур чадвар буюу англиар **“Socio-Emotional Skill”** гэсэн 2 томоохон үзэл баримтлалтай юм. Нэг талаас суралцагчдад бие дааж ажил хөдөлмөр эрхлэх, энтрепренершипийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, сэтгэлгээ нөгөө талаас түүнд шаардагдах хувь хүний ур чадварыг хөгжүүлнэ. Энэ нь математик, түүх гэх мэт суралцахуйн зорилт нь тухайн судлагдахуунтай холбоотой мэдлэг, чадвар байдаг хичээлээс нэлээд ялгаатай гэдэг нь та бүхэнд илэрхий байгаа гэдэгт итгэлтэй байна. Ийм учраас уг хичээлийн арга зүй нь уламжлалт сургалтын суралцахуйн онолоос ялгаатай байх шаардлагатай.

Энтрепренершип гэдэг нь нийгмийн, соёлын, бизнесийн ямар нэг үнэт зүйлийг бий болгох чиглэлээр шинэ, инновацлаг санаа дэвшүүлэх боломжийг эрэлхийлэх процесс юм. Энтрепренершипийн сургалт нь товчоор хэлбэл суралцагчдад шинэ, инновацын мэдлэг, үнэт зүйл, зан үйл бүтээх, түүнийг хэрхэн бүтээх арга зам, ур чадварт суралцахад чиглүүлэх, дэмжих үйл явц юм.

## Хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс

Энтрепренершипд математик, хими, физик, нийгэм судлал, бизнес судлал зэрэг судлагдахууныг дан дангаар нь авч үзэх боломжгүй. Энэ нь суралцагчдаас нийлмэл ур чадвар шаарддаг, агуулгын хувьд интеграцчилагдсан, суралцагчдын хамтын ажиллагаа, зөвшилцөл, шийдвэр гаргалтыг нэлээд их шаарддаг, төсөлт хэлбэрийн даалгавартай, сурах үйлийн явцыг чухалчилдаг (Lackeus, 2015). Энтрепренершип нь ямар нэг үйлийн системийн үндсэн ухагдахууныг дахин тодорхойлох, тухайн үйлийн өмнөх хэлбэрээс илүү өргөн хүрээний боломжийг багтаах, үйлийн сэдэл бий болгох замаар хамтаараа хувирган өөрчлөх эсвэл өргөтгөх үйл явц юм (Engeström 2003, pp. 30-31). Энэ нь илүү шинэлэг, инновацлаг, хүмүүсийн олон янзын туршлага, дадлаар тодорхойлогддог ба суралцагчдад хараахан “бий болоогүй”, урьдчилан мэдэх боломжгүй тэр нөхцөл байдалд ажиллаж, амьдрах ур чадварыг хөгжүүлдэг. Ийм учраас энтрепренершипд **Экспансив** суралцахуйн онол хамгийн тохиромжтой байдаг (Illeris, K. 2007). Энэ нь нийгмийн тодорхой хэсгийн





соёл, итгэл үнэмшлийг шинэ соёл, үнэт зүйл болгон өөрчлөх эсвэл цоо шинээр бүтээх, тэднийг бусадтай олон янзын байдлаар хамтран суралцах боломжийг олгодог, илүү шинэлэг, инновацлаг, хүмүүсийн янз бүрийн туршлага, дадлаар тодорхойлогддог онол юм. Суралцахуйн энэ онол суралцагчдад хараахан “бий болоогүй”, урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдалд ажиллах, сурах боломжийг олгодог. Энэ утгаараа суралцагчдад эргэлзэх, асуулт асуух, нэгэнт тогтсон жишиг, нормд шүүмжлэлтэй хандах, үр дүнтэй байдлаар өөрчлөх гэж оролдох, асуудлыг олон талаас харах, учир шалтгаан, үр дагаврыг эргэцүүлэх, шинэ загвар санааг санал болгох, практикт турших гэх мэт суралцахуйн “хэвшмэл бус” үйл, сэтгэлгээг дэмжиж өгдөг тодорхой цикл бүхий сурах үйл ажиллагаатай үзэл баримтлал юм.

### Экспансив суралцахуйн онол нь 3 онцлогтой. Үүнд:

1.

**Суралцахуй гэдэг нь** утга учиртайгаар ямар нэг зүйлийг бүтээдэг, ингэхдээ танин мэдэхүйн арга хэрэгслийн хэрэглээг бүтээдэг үйл явц

2.

**Суралцахуй гэдэг нь** суралцагчийн харилцан яриа, оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд явагддаг үйл явц

3.

**Суралцахуй гэдэг нь** одоо байгаа практикт эргэлзэх, асуулт асуух, шүүмжлэлт байр сууринаас хандах замаар шинэ санаа, эд зүйл, зан үйлийг бүтээдэг үйл явц

Энэ онолоор суралцахуй нь дараах 7 үйл ажиллагаагаар (Зураг 1) явагдах бөгөөд эдгээр нь суралцагчдад дан ганц энтрепренершиппийг бий болгохоос илүү түүнд шаардагдах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг олгодог байна.

Эдгээр үйл ажиллагаа нь: ➔



Зураг 1

1. Эхлээд одоо байгаа практик эсвэл үзэл санааны талаар асуулт асуух, шүүмжлэлтэй хандах, магадгүй хүлээн зөвшөөрөхгүй байх замаар шинэ мэдлэг, чадвар, зан үйл бүтээх суралцахуйн хэрэгцээг тодорхойлох

---

2. Нөхцөл байдлын талаар “яагаад” гэж асуух, тайлбарлах замаар учир шалтгааны дүн шинжилгээ хийх. Энэ нь хоёр талтай үйл ажиллагаа юм. Нэгдүгээрт тухайн нөхцөл байдал өдий хүртэл яаж бий болсон буюу түүхэн хөгжил талаас нь харах, хоёрдугаарт тухайн нөхцөл байдлын өдөр тутмын практик болон түүнийг хэрэгжүүлэгч хүмүүсийн зохицуулалтад илэрч байгаа зөрчлийн талаарх эмпирик нотолгоо шинжилгээ хийх

---

3. Тухайн нөхцөл байдал дахь практик үйлийн учир шалтгааныг илрүүлснээр шинэ загвар, санаа боловсруулан дэвшүүлэх буюу нээлт хийх

---

4. Шинэ загвар, санаагаа практикт туршиж сорих, түүнийхээ хязгаарлагдмал байдал, боломж, үр өгөөжийг үнэлж дүгнэх замаар сайжруулах

---

5. Шинэ загвар, санаагаа практикт хэрэгжүүлж, илүү сайжруулах

---

6. Шинэ загвар, санаа, түүнийг бий болгож, хэрэгжүүлсэн үйл явц, үүнээс юу сурсан талаараа эргэцүүлж, цаашид юу сурах шаардлагатайгаа тодорхойлох


---

7. Үйл явцаа нэгтгэн дүгнэж, эцэслэн боловсруулсан загвар, санаагаа практикт тууштай хэрэглэх, бусдад санал болгох, түгээн дэлгэрүүлэх

Дээрх 7 циклт үйл ажиллагаа нь суралцагчдад энтрепренершипийн суурь ойлголт, аливаад шүүмжлэлтэй хандах, багаар ажиллах, бусадтай харилцах, төлөвлөх, алдаанаасаа суралцах, бүтээлч шинэлэг байх, тасралтгүй оролдох, боломжийг эрэлхийлэх, түүний хязгаарлагдмал байдлыг таньж мэдэх, эрсдэлийг урьдчилан харах, асуудалд судалгаа шинжилгээтэй хандах сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Хамгийн гол нь багш эдгээр 7 үйл ажиллагааг алгасах, орхигдуулахгүй байх нь чухал.

Үйл ажиллагааны цикл бүр дэх ажилбар, даалгавар, сорилуудыг сайжруулах, нэмэх боломжтой.

Энтрепренершип сургалтад багшийн үүрэг хамгийн чухал байдаг учраас багш өөрөө шинийг санаачлагч, бүтээгч, энтрепренер сэтгэлгээтэй, асуудлыг шийдэх, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, оновчтой ашигладаг энтрепренерүүд байх нь сургалт амжилттай байх үндэс юм шүү (European Commission, 2014; Heinonen & Poikkijoki, 2006; Peltonen, 2015).



## 7 Үйл ажиллагаа



# СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Экспансив суралцахуйд суралцагчид практикийн асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж, түүнийг сайжруулах, хөгжүүлэх шинэ санаа боловсруулах, түүнийгээ турших, боломжийг тодорхойлоход хамтаараа хүчин чармайлт гаргадаг учраас энэ суралцахуйг удирдан чиглүүлэх, хөтлөхөд төсөлд суурилсан арга зүй хамгийн тохиромжтой.

Төсөлд суурилсан арга зүй нь динамик шинж чанартай, уян хатан байдаг. Бие даасан ажил, багийн үйл ажиллагаанд багагүй хугацааг зарцуулах бөгөөд үүний үр дүнд тодорхой бүтээгдэхүүн, илтгэл, үзүүлэн, гүйцэтгэл гарч байдгаараа бусад сургалтаас давуу талтай. Сургалтын үйл ажиллагааны явцад тодорхой хугацаанд төслийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад үнэлгээ тогтмол хийж ахиц дэвшлийг харах, ажиглах, түгээх боломжтой байдаг. Төсөлд суурилсан сургалтын бас нэг онцлог нь бодит амьдрал, орчны асуудлыг шийдэх боломжит шийдлүүдийг хайдагт орших бөгөөд энэ нь суралцагчдын сонирхол, сэдэл тэмүүллийг төрүүлж чаддаг.

Төсөлд суурилсан сургалтын хамгийн чухал шинж чанар бол суралцах үйл ажиллагааны цар хүрээ нэлээд гүнзгий, тэдний идэвхтэй оролцоог шаарддаг, хамтын шийдэлд үндэслэн ажлыг илүү чанартай хийх, сурах боломжийг олгодог явдал юм. Эдгээр элементүүд нь:

- ✓ Бэрхшээлтэй асуудал, асуултуудыг тодорхойлох
- ✓ Асуудлын шийдэл, асуултын хариултыг тасралтгүй эрэлхийлэх
- ✓ Бодит орчин, бодит амьдралд суурилах
- ✓ Сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэх
- ✓ Судлагдахууны интеграцийг хангах
- ✓ Суралцагчдын дуу хоолой, сонголтууд нээлттэй байх
- ✓ Орон нутгийн бодит иргэдэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгохыг зорих
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар шүүмж сонсож, эргэцүүлэх, улмаар түүнийг сайжруулах явцын болон төгсгөлийн үнэлгээ юм.

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалтыг удирдан чиглүүлэхэд ямар төсөл сонгох вэ гэдэг чухал асуудал байдаг. Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрт төслийн удирдамжийг урьдчилан боловсруулсан тул төдийлөн бэрхшээл гарахгүй юм.

Төсөлд суурилсан сургалтад багийн гишүүдийн тоо их чухал. Ихэнх төслийн хувьд нэг баг 4 суралцагчаас бүрдэх нь чиг үүргээ шударга, тэнцвэртэй хуваарилах, өөрийн хувь хүний ур чадвараа бусдаас хамааралгүйгээр хөгжүүлэх боломжийг олгодог.



Суралцагчдын хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга нь тэднийг бие биетэйгээ идэвхтэй харилцах, өөрийн санаа, хийсэн зүйлээ танилцуулах, илтгэх, үйл ажиллагаагаа зохион байгуулах, асуудлын учир шалтгааныг эрэлхийлэх, шинжлэн судлах, эргэцүүлэх, бодит амьдралын асуудлыг шийдэхэд татан оролцуулах явдал юм.

Эдгээр ур чадварыг төсөлд суурилсан сургалтаар хөгжүүлэх боломжтойг олон судалгааны үр дүн харуулдаг. Жишээлбэл төсөлд суурилсан сургалт нь суралцагчид бодит орчны асуудалд тулгуурласан нийлмэл даалгаврыг гүйцэтгэх замаар асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах, шинжлэн судлах чадвараа хөгжүүлэх боломжтой бөгөөд төсөл гүйцэтгэснээр ямар нэгэн үр дүнд хүрч түүнээсээ сэтгэл ханамжийг мэдэрч, сурах үйлдээ илүү урам зоригтой ханддаг гэж АНУ-ын эрдэмтэн Томас дүгнэсэн байдаг.

Төсөлд суурилсан сургалт дараах давуу талтай байдаг (Railsback, 2002). Үүнд:

**а) Хүүхэд, залуучуудыг ажлын байранд бэлтгэдэг**

Төсөлд суурилсан сургалтын явцад суралцагчид ажлын байранд зайлшгүй шаардлагатай хамтран ажиллах, төлөвлөлт хийх, шийдвэр гаргах, цагийн менежменттэй байх гэсэн ур чадварыг эзэмшдэг.

**б) Сурах хүсэл, тэмүүллийг бий болгодог**

Төсөлд суурилсан сургалтыг явуулснаар суралцагчдын хичээлд хамрагдалт, оролцоо, гэрийн даалгавраа гүйцэтгэх урам зориг нэмэгддэг.

**в) Сургуулийг бодит амьдралд илүү ойртуулж, холбодог**

Суралцагчид төсөл гүйцэтгэх явцдаа өмнө сурсан мэдлэг, чадвараа сэргээн санаж, өөр нөхцөл байдалд ашиглах, илүү дээд түвшинд сэтгэх ур чадвар хөгждөг.

**г) Хамтран ажиллуулах замаар мэдлэг бүтээх боломж олгодог**

Суралцагчдыг хамтаар ажиллуулах нь тэдэнд нэг нэгнийхээ шинэ санааг хөгжүүлэх, өөрийн санал, бодлоо илэрхийлэх, зөвшилцөх замаар шийдэлд хүрэх гэх мэт ажлын байранд шаардлагатай ур чадварыг эзэмшдэг.

**д) Нийгмийн болон харилцааны ур чадварыг нэмэгдүүлдэг**

Суралцагчид багийн гишүүдтэй харилцахад сурдаг. Энэ нь тэдний нийгмийн болон харилцааны ур чадварыг аажмаар хөгжүүлж, өөр өөр бодол санаа, үзэл бодолтой хүмүүстэй харилцах арга барилд сургадаг.

### **е) Асуудал шийдвэрлэх ур чадварыг нэмэгдүүлдэг**

Баг дотроо заримдаа үл ойлголцол гарч болно. Үүнийг багаар ажиллах явцдаа шийдэхээс өөр аргагүй нөхцөл байдалд хүрдэг учраас тэдний тулгарсан асуудлыг шийдэх ур чадвар нэмэгддэг.

### **ё) Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх**

Суралцагчид өөрийн үйл ажиллагаагаа ямар нэг зүйлд хүрснээрээ өөрөөрөө бахархах сэтгэл төрдөг.

### **ж) Суралцагчид өөрийн давуу талд тулгуурлан аливаа зүйлийг олон талт байдлаар гүйцэтгэх, практикт нийцтэй шийдэл гаргах, дижитал технологийг ашиглах боломж олгодог**

Төсөлд суурилсан арга зүйгээр сургалтыг удирдан чиглүүлэхэд ямар төсөл сонгох вэ? гэдэг чухал асуудал байдаг. Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрт төслийн удирдамжийг урьдчилан боловсруулсан учир удирдамжийн дагуу суралцагчдаар гүйцэтгүүлэх, шаардлагатай бол нэмэлт дэмжлэг үзүүлэх замаар тэдний хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд анхаарна.

Төсөлд суурилсан сургалтын явцад суралцахуйн дараах элементүүдийг заавал хэрэгжүүлэх бөгөөд суралцагчдын үйл ажиллагаанд эдгээр элементийг тусгах нь чухал. Үүнд:

- 1** Тухайн орон нутгийн нийгмийн болон иргэдийн хэрэгцээ, жижиг дунд бизнес эрхлэгчид тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох
- 2** Хэрэгцээг хангах эсвэл асуудлыг шийдэх шийдлийг тасралтгүй эрэлхийлэх, олон хувилбараар шийдлийг боловсруулахыг оролдох
- 3** Дээрх шийдлүүд нь бодитой байх
- 4** Сургалтын явцад өөрийн сурч мэдсэнээ ашиглах
- 5** Асуудлын шийдлийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутаг дахь нөөц, боломжийн хүрэлцээтэй эсэхийг тодорхойлох
- 6** Суралцагч өөрийн дуу хоолойгоо илэрхийлэх, сонголтоо ухаалгаар, нөөц боломжид түшиглэн оновчтой хийх
- 7** Тухайн орон нутгийн хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг оролцуулах замаар суралцагчдын оролцоотой сүлжээ бий болгох

Сургалтын явцад **14-18** насны хүүхдүүдэд бизнес эрхлэх, ашиг олох төслүүдээс илүүтэй сургуулийн орчинд суралцагчдын сонин гаргах, дотуур байрны суралцагчдад давтлага өгөх, суралцагчдад чиглэсэн хөгжүүлэх үйл ажиллагааг санаачлах, шинжлэх ухааны төсөл хэрэгжүүлэх гэх мэт санаачилгуудыг дэмжихэд анхаарах хэрэгтэй. Харин **19-25** насны залуучуудад ашиг олох, орлоготой байх чиглэлийн бизнесийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.



## Сургалтын нэмэлт стратеги

Энэхүү сургалт нь энтрепренершип болон хувь хүний ур чадвар гэсэн 2 үзэл баримтлалтай гэдгийг өмнө дурдсан. Тийм учраас сургалтын явцад багш суралцагчдын өөрийн талаарх ойлголт, итгэл үнэмшил, өөртөө итгэлтэй байх, өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж мэдэх, түүнийг удирдах, бусдыг хүндэтгэх, бусад суралцагчдын нийгэм, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, өөрийгөө илэрхийлэх, бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх замаар бусдыг ойлгох, бусдыг анхааралтай сонсох, шаргуу байх, алдаанаасаа суралцах, ёс зүйтэй байх гэсэн хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн стратегийг тогтмол ашигладаг байх хэрэгтэй. Сургалтын үйл ажиллагааг багшийн болон суралцагчийн гарын авлагад алхам алхмаар тусгасан байгаа учраас багш нарт сургалтыг удирдан чиглүүлэхэд төдийлөн бэрхшээл тулгарахгүй гэж найдаж байна. Харин сургалтын явцад багш дээрх хувь хүний ур чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхэд голлон анхаарч шаардлагатай тохиолдолд дараах стратегийг хэрэглэдэг байх хэрэгтэй.



### ➤ 1. Өөрийн сэтгэл хөдлөлөө мэдэрч, түүнийгээ удирдах

Багаар ажиллахад суралцагчдад янз бүрийн сэтгэл хөдлөл илэрнэ. Багш суралцагчдыг ажиглаж сэтгэл хөдлөл хүчтэй илэрч, тэр нь багийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлж байгаа тохиолдолд тухайн суралцагч, суралцагчдаас ямар сэтгэл хөдлөл мэдэрсэн, сэтгэл хөдлөлийн шалтгаанаа таньж мэдэх, энэ нь бусдад ямар нөлөө үзүүлсэн, хэрэв өөрөө энтрепренер байгаад хамт ажилладаг хүн нь ийм сэтгэл хөдлөл гаргавал яаж тайвшруулах, ойлголцох чиглэлээр асуулт асуух, дүрд тоглуулах гэх мэт стратегийг ашиглана. Шаардлагатай бол амьсгалын дасгал хийлгэх гэх мэт техникийг ашиглаж болно.

### ➤ 2. Бусад суралцагчдын нийгэм, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах

Нийгмийн байдал, соёлын ялгаанаас шалтгаалан 14-25 насны хүүхэд залуучуудын дунд бие биедээ хүндэтгэлгүй хандах асуудал байдаг. Ялангуяа багаар ажиллаж байхад нийгмийн байдлаас шалтгаалан үл ойшоох, сонсохгүй байх, чамд ийм зүйл байхгүй, эсвэл чи мэддэггүй гэх мэт хандлага гардаг. Үүнээс зайлсхийхийн тулд багш багуудыг ажиглан, хэн ямар үйл ажиллагааг түлхүү гүйцэтгэж байна, яагаад зарим суралцагчид оролцож чадахгүй байна, даалгасан ажлыг гүйцэтгэхэд багийн гишүүдэд хэнээс ямар тусламж хэрэгтэй байгааг баг дотроо илэн далангүй ярилцдаг байхад чиглүүлэх шаардлагатай. Зарим тохиолдолд багийн суралцагчийн менежерийн<sup>2</sup> үүргийг солих гэх мэтээр бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх, улмаар түүний нөхцөл байдлыг ойлгоход чиглэсэн стратегийг хэрэглээрэй. Бие биенийхээ байр сууринд өөрийгөө тавьж үзэх замаар бусдыг ойлгох нь суралцагчдын хооронд эерэг, сайн нөхөрлөл, харилцаа үүсэх үндсэн хүчин зүйл болно.

### ➤ 3. Бусдыг сонсох, ярих

Суралцагчид юу хийсэн, юу мэдэрч байгаа, юу хэлж байгаад нь хэн нэгэн анхаарал хандуулж буйг мэдрэх нь сургалтын үйл ажиллагаанд сэтгэл зүрхээрээ оролцох, илүү сонирхолтой байх нөхцөлийг бүрдүүлнэ. Суралцагчдыг бие биеэ таньж мэдэх, юу мэдэрч байгааг ойлгох, зөвлөхөд чиглүүлсэн стратегийг тогтмол хэрэглэх шаардлагатай. Суралцагчдыг багаараа ажиллаж байх үед дараах харилцааны арга техникийг ашиглахыг үргэлж санал болгох, шаардлагатай бол багийн дүрэмд заавал тусгах хэрэгтэй.

#### Тухайлбал:

1. Бусад суралцагч ярьж байхад **нүд рүү нь харж, бүрэн анхаарал хандуулах**



2. Зөвхөн хэлж байгаа үг бус **ямар сэтгэл хөдлөлтэй байгааг ажиглах**
3. Тухайн суралцагч ярьж дууссаны дараа өөрийн ойлголтоо **“чиний ярьснаас би ... гэж ойлголоо”** гэж баталгаажуулж байх
4. Тодруулах **асуулт асуух**
5. Ярьж байгаа зүйл, **сэтгэл хөдлөлөө хянаж** хариу үйлдэл үзүүлэх
6. Яриаг сонсож дууссаны дараа өөрийн саналаа хэлэх, **бусдын яриаг таслахгүй байх**

Сургалт бүрийн эхэнд **5 минут** орчим бие биеэсээ юу хийсэн, тэр нь ямар санагдсан гэх мэт асуулт асууж, ярилцдаг байх нь чухал бөгөөд энэ нь суралцагчдад ялангуяа ичимхий, бүрэг, өөртөө итгэх итгэл сул байдаг хүүхэд залуучуудад хэрэгтэй дасгал байдаг.

#### ➤ 4. Өөрийгөө илэрхийлэх, илтгэл танилцуулах

Суралцагчдад өөрийгөө илэрхийлэхээс ичих, буруу хэлчих вий, бусад хүмүүс намайг дооглох вий гэсэн айдас түгээмэл байдаг. Суралцагчдын өөрийгөө илэрхийлэх, илтгэл танилцуулах ур чадварыг хөгжүүлэхийн тулд илтгэлээ танилцуулахын өмнө доорх хоёр асуултад хариулах байдлаар дасгал хийлгэх.

Үүнд:

1. Илэрхийлэх гэж буй гол санаанууд юу болох? 2. Яагаад тэдгээр санааг чухал гэж үзсэн? Энэхүү дасгалыг бие даасан болон багаар гэсэн хоёр хэлбэрээр хийж илтгэл болгон танилцуулах боломжтой. Мөн суралцагчийн хэлсэн санаа, үзэл бодолд шууд буруу, зөв хэмээн дүгнэхээс зайлсхийх, яагаад тэгж бодсон гэх мэт илүү нээлттэй асуулт асуухыг эрмэлзэх хэрэгтэй.

Өөрийгөө илэрхийлэхээс зайлсхийдэг бүрэг хүүхэд, залуучуудын сонирхдог зүйлийг олж мэдэхийг хичээгээрэй. Тэдний сонирхолд нийцсэн, хийх дуртай, хамгийн сайн чаддаг зүйлийг сургалтын үйл ажиллагаанд ашиглахыг оролдоорой. Хамгийн сайн чаддаг зүйлээрээ бусад суралцагчдад туслах боломжийг олгох. Мөн тэднийг хамгийн яриасаг, нийтэч хүүхдүүдтэй нэг баг болгоорой. Тэдний үйл ажиллагаанд өдөр тутам анхаарал хандуулж, самбар арчих, тараах материал түгээх гэх мэт анги танхимд хөдөлгөөнтэй байдаг ажилд оролцуулаарай.

Багш суралцагчдыг үргэлж бие биеэсээ **ЧАМД ДААЛГАВРАА ГҮЙЦЭТГЭХЭД ЯМАР БЭРХШЭЭЛ БАЙНА? БИ, БИД ЯАЖ ТУСЛАХ ВЭ? ДААЛГАВРЫГ ГҮЙЦЭТГЭХ ӨӨР АРГА ЗАМ ЮУ БАЙЖ БОЛОХ ВЭ?** гэж үргэлж асуудаг **“зуршилтай”** болгоход анхаарах хэрэгтэй. Багийн суралцагчид ямар нэг даалгаврыг амжилттай гүйцэтгэж эсвэл асуудлыг шийдэж хүссэн үр дүндээ хүрэхэд бие биедээ туслах нь маш чухал гэдгийг сайн ойлгуулах хэрэгтэй.

# ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА БА СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР СЭТГЭЛГЭЭНИЙ УЯЛДАА

Сургалтын сэдвүүд нь дараах дэд сэдвүүдтэй байх ба энэ сэдвээр дамжуулан ямар мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхийг дараах хүснэгтэд үзүүлээ.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	СУРАЛЦАГЧДЫН ЭЗЭМШИХ		
		А.СЭТГЭЛГЭЭ	Б.ЧАДВАР	В.МЭДЛЭГ
1	<b>1.1 Хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэл</b>	Сэтгэлгээнийхээ онцлог, хэв шинжийг таньж мэдэх	Өөрийн хүчинд итгэх, өөрийгөө таних, сэтгэл хөдлөлөө тодорхойлох, хариу үйлдлээ мэдэх	Нийгмийн сэтгэл зүйн мэдлэг
	<b>1.2 Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних</b>	Санаачилгатай байх	Өөрийнхөө талаарх ойлголтоо бодитойгоор тодорхойлох, баг бүрдүүлэх, багаар ажиллах, багийн үүргээ тодорхойлох, харилцах	
	<b>1.3 Цагийн менежмент</b>		Цагийн менежмент болон стрессээ удирдах	
2	<b>2.1 Энтрепренершип гэж юу вэ?</b>	Энтрепренершип сэтгэлгээ, нээлттэй хамтран ажиллах	Энтрепренершипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, бүтээлч байдал, инновацын ур чадвар, багаар ажиллах, харилцах	Энтрепренершипийн суурь мэдлэг
	<b>2.2 Энтрепренершипийн арга замууд</b>			
	<b>2.3 Энтрепренершипийн оролцогч талууд</b>			
3	<b>3.1 Тухайн орон нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлийн хэрэгцээг тодорхойлох</b>	Сониуч, санаачилгатай байх, энтрепренер сэтгэлгээ, нийтэч байх	Хэрэгцээг тодорхойлох, багаар ажиллах, тунгаан бодох, мэдээлэл солилцох, судалгаа шинжилгээ хийх, үр дүнг танилцуулах, харьцуулалт хийх, бүтээлч байдал, инновацын ур чадвар, харилцах	Дижитал мэдлэг, энтрепренершипийн суурь мэдлэг
	<b>3.2 Ялгаатай хэрэгцээг таних</b>			
	<b>3.3 Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх, өөрсдийн санааг хөгжүүлэх</b>			



СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	СУРАЛЦАГЧДЫН ЭЗЭМШИХ		
		А.СЭТГЭЛГЭЭ	Б.ЧАДВАР	В.МЭДЛЭГ
4	<b>4.1</b> Энтерпренершипийн санааг хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломж, саад бэрхшээл			Энтерпренершипийн суурь мэдлэг
	<b>4.2 Санхүүгийн нөөц</b>	Сониуч байх, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдалд хүчин чармайлт гаргах, шаргуу, хичээнгүй байдал	Энтерпренершипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийг тооцох, бүтээлч байх, тунгаан бодох, багаар ажиллах	Санхүүгийн мэдлэг
	<b>4.3 Бизнес төлөвлөлт</b>			Нөөцийг зохистой хуваарилах, боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг
	<b>4.4 Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэл, түүнийг бууруулах арга зам</b>			Эрсдэлийг урьдчилан харах, түүнийг бууруулах талаарх мэдлэг
5	<b>5.1 Энтерпрайз төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт</b>	Сониуч, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэл, алдаанаас суралцах, хүчин чармайлт, шаргуу байдал	Энтерпренершипийн нийгэм, соёлын орчлыг танин мэдэх, инновац, тунгаан бодох, багаар ажиллах, харилцах	Нөөцийг зохистой хуваарилах, боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, энтерпренершипийн суурь мэдлэг, санхүүгийн мэдлэг, дижитал мэдлэг бизнес төлөвлөлт
	<b>5.2 Энтерпрайз төслийн явц, үр дүнгийн тандалт</b>			
	<b>5.3 Төслийг үнэлж дүгнэх</b>			
6	<b>6.1 Төслийг сайжруулах</b>	Сониуч, санаачилгатай байх, тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэл, алдаанаас суралцах, хүчин чармайлт, шаргуу байдал	Бүтээлч байдал, инноваци, тунгаан бодох, багаар ажиллах, харилцах	Нөөцийн зохистой хуваарилалт, ашиглалт болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай мэдлэг, бизнес төлөвлөлт, санхүүгийн мэдлэг, дижитал мэдлэг



# 7

**7.1 Төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх**

**7.2 Санхүүжилт авах шаардлагын дагуу төсөл боловсруулах, төслийн сонгон шалгаруулалтад оролцох**

**7.3 Төслийн санааг хөгжүүлэх боломжийг тодорхойлох, тасралтгүй хөгжүүлэх**

Дээрх мэдлэг, чадвар, сэтгэлгээг хэрэглэн багаараа болон бие дааж шинэ төсөл боловсруулах

Сургалтын явцад хийж гүйцэтгэх төслүүд нь өөрийгөө таних ⇨ багаа таних ⇨ үүргээ ухамсарлах ⇨ Сургалтын явцад хийж гүйцэтгэх төслүүд нь өөрийгөө таних ⇨ багийн бусад гишүүдээ таних ⇨ үүргээ ухамсарлах ⇨ хэрэгцээг тандах, ⇨ хэрэгцээг хангаж буй практикийн алдаа, амжилтын шалтгааныг тодорхойлох ⇨ хэрэгцээнд хариу арга хэмжээ авах, тогтсон шийдлийг олох ⇨ түүний дагуу бизнес төсөл боловсруулах ⇨ түүнийгээ танилцуулж санал авах ⇨ турших ⇨ сайжруулах ⇨ хэрэгжүүлэх гэсэн дэс дараалалтай явагдаж байгааг анхаарах хэрэгтэй.

Энэхүү сургалтад хамрагдсанаар суралцагч дараах үйл ажиллагаанд оролцох болно. Үүнд:

- ✓ Бие даан ажиллах
- ✓ Хос хосоороо ажиллах
- ✓ Багаар ажиллах
- ✓ Кейс цуглуулах, дүн шинжилгээ хийх
- ✓ Танхимаас гадуур суралцах
- ✓ Орон нутгийн аж ахуй, иргэдийн төлөөллийг сургалтад урилгаар оролцуулах
- ✓ Энтерпрайзын үйл ажиллагааг зохион байгуулах
- ✓ Илтгэл, танилцуулга хийх
- ✓ Мэдээлэлийн технологи ашиглах





## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

---

Суралцагчийн зорилтот мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхэд үнэлгээ маш чухал үүрэгтэй.

Үнэлгээ нь суралцагчийн өөрийн үнэлгээ, найз нөхдийн үнэлгээ, багшийн үнэлгээнээс бүрдэнэ. Суралцагчийн өөрийн болон найз нөхдийн үнэлгээний хуудсыг гарын авлагын дэд сэдэв бүрийн дараа оруулсан байгаа бөгөөд хэрхэн яаж үнэлэхийг мөн тайлбарласан болно.

**А. Өөрийн үнэлгээ** гэдэг нь Сэдэв 1, 3, 5 -ын төгсгөлд өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу суралцагчид өөрийгөө үнэлж буйг хэлнэ. Өөрийн үнэлгээний дунджийг гаргахдаа үнэлгээ тус бүрийн хувийг тооцож тэдгээрийн нийлбэрийн дунджаар гаргана.

---

**Б. Найз нөхдийн үнэлгээ** гэдэг нь Сэдэв 2 ба 4-ийн төгсгөлд өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу багийн аль нэг гишүүнээр хийлгэж буй үнэлгээг хэлнэ. Найз нөхдийн үнэлгээний дунджийг гаргахдаа үнэлгээ тус бүрийн хувийг тооцож тэдгээрийн нийлбэрийн дунджаар гаргана.

**Багшийн үнэлгээ нь тест ба төслийн үнэлгээнээс бүрдэнэ.**

**В. Тестийн үнэлгээ** гэдэг нь сургалтын төгсгөлд суралцагчдаар ажиллуулсан тестийн дүн байна. Тестийн даалгаврууд тус бүр ялгаатай үнэлгээтэй бөгөөд нийт 25 оноотой.

---

**Г. Төслийн үнэлгээ** нь 10 шалгууртай. Шалгуур бүрийг багш 1-10 оноогоор үнэлж тэдгээрийн нийлбэрээр үр дүнг тооцно.

## А. Өөрийн үнэлгээг тооцох арга

Сэдэв 1	Сэдэв 3	Сэдэв 5	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ
Авах ёстой оноо <b>72-100%</b>	Авах ёстой оноо <b>42-100%</b>	Авах ёстой оноо <b>66-100%</b>	$(1.4 * X + 2.4 * X + 1.52 * X) : 3 = \dots\%$
<b><math>1.4 * X =</math></b> Гүйцэтгэлийн хувь	<b><math>2.4 * X =</math></b> Гүйцэтгэлийн хувь	<b><math>1.52 * X =</math></b> Гүйцэтгэлийн хувь	

## Б. Найз нөхдийн үнэлгээг тооцох арга

Сэдэв 2	Сэдэв 4	ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ
Авах ёстой оноо <b>30-100%</b>	Авах ёстой оноо <b>54-100%</b>	$(3.34 * X + 1.85 * X) : 2 = \dots\%$
<b><math>3.34 * X =</math></b> Гүйцэтгэлийн хувь	<b><math>1.85 * X =</math></b> Гүйцэтгэлийн хувь	

## Багшийн үнэлгээг тооцох арга

В. Тестийн дүн	Г. Төслийн үнэлгээний дүн
Нийт авах ёстой оноо <b>25-100%</b>	Нийт авах ёстой оноо <b>100-100%</b>
$4 * X = \dots\%$	$1 * X = \dots\%$

## В. Тест

Сургалтын төгсгөлд суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг ур чадварын тест болон төслийн гүйцэтгэлээр үнэлнэ.

Дараах ур чадварын тестийг ашиглана. (улаан өнгөөр зөв хариултыг тэмдэглэв)



**1. Зурагт үзүүлсэн унадаг дугуй ирээдүйд ямар болох тухай төсөөлөөд ямар 3 сайжруулалт хийгдэнэ гэж бодож байна вэ? Гурван сайжруулалтыг жагсаан бичнэ үү. (3 оноо) Зөв харцулт тус бүр 1 оноо**



Сайжруулалт 1:

Сайжруулалт 2:

Сайжруулалт 3:

**2. Ирээдүйн унадаг дугуй цахилгаанаар цэнэглэгдэж явдаг болно гэж үзвэл дөрөөгүй болох байх. Тэгвэл энэ дөрөөг өөр ямар байдлаар ашиглаж болох тухай санаагаа бичээрэй. (1 оноо)**



**3. Дараах алхмуудын аль нь асуудал шийдвэрлэхтэй холбоогүй вэ? (1 оноо)**

- A. Асуудлаа тодорхойлох
- B. Мэдээлэл цуглуулах
- B. Шийдлийг олох
- Г. Асуудлыг тоохгүй өнгөрөх**

**4. Та ямар төрлийн бизнес эрхлэхийг хүсэж байна вэ? Энэ бизнесийн байршил нь хаана байх вэ? Таны бизнесийн зорилго юу байх вэ? (3 оноо) Зөв харцулт тус бүр 1 оноо**

Хариулт .....

.....

.....

.....

.....

**5. Хэн нэгний төлөө ажилладаг хүн бол... (1 оноо)**

- A. Ажил олгогч
- B. Ажилтан
- B. Энтрепренер**
- Г. Энтрепренершип

**6. Тодорхой нэг бизнесийг өмчилдөг, үйл ажиллагаа явуулдаг, түүндээ эрсдэл хүлээдэг хүнийг ... (1 оноо)**

- A. Ажил олгогч
- B. Ажилтан
- B. Энтрепренер**
- Г. Энтрепренершип

**7. Бизнесийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг зөв дараалалд оруулж дугаарлаарай. (2 оноо)** 4 ба түүнээс багыг зөв эрэмбэлсэн бол 1 оноо, 5 болон түүнээс олныг зөв эрэмбэлсэн бол 2 оноо

- Ерөнхий мэдээлэл- төслийн нэр, сургууль, багийн нэр, багшийн нэр **1**
- Үйл ажиллагааны хураангуй **2**
- Эрхэм зорилго **3**
- Зорилго, зорилт **4**
- Зорилтот хэрэглэгчид **7**
- Үйлдвэрлэл/үйлчилгээ **5**
- Ажиллах хүчин ба түүхий эд, санхүүгийн нөөц **6**
- Маркетинг **8**

**8. Бизнес шууд нөлөөлөх макро орчны хүчин зүйлсэд аль нь хамаарахгүй вэ? (1 оноо)**

- А.** Өрсөлдөгч ба хамтран ажиллагч түншүүд
- Б.** Бэлтгэн нийлүүлэгч ба хэрэглэгч
- В. Эдийн засаг ба санхүү**

**9. Бизнесийн үйл ажиллагааны зарим зардал өдөр, 7 хоног, сар тутам ижил хэмжээтэй гарч байдаг. Үүнийг..... зардал гэнэ. Харин хэрэглээнээс хамаарч өдөр, 7 хоног, сар тутам өөр өөр хэмжээгээр гарч байгаа зардлыг..... зардал гэнэ. (1 оноо)**

- А. Тогтмол, хувьсах**
- Б.** Байнгын, байнгын бус
- В.** Хувьсах, тогтмол

**10. Сургуулийн байранд утаа илрүүлэгч төхөөрөмж байрлуулсан байна. Энэ нь эрсдэлийг удирдах ямар арга вэ? (1 оноо)**

- А.** Эрсдэлийг шилжүүлэх
- Б.** Эрсдэлийг бууруулах
- В. Эрсдэлээс зайлсхийх**

**11. Та ямар нэг ажил үүрэг эсвэл даалгавар гүйцэтгэхдээ бүтэлгүйтсэн тохиолдолд энэ намайг сорьж байна гэж бодоод амжилт гаргахын төлөө үргэлжлүүлэн хичээнгүйлж ажилладаг уу? (1 оноо)**

- Тийм**
- Заримдаа
- Үгүй

**12. Та хүнд бэрх асуудлын эсвэл даалгаврын шийдлийг олтлоо дахин дахин оролдсоор байдаг уу? (1 оноо)**

- Тийм**
- Заримдаа
- Үгүй

**13. Хийх ажлаа илүү сайн зохион байгуулахын тулд:**

**(2 оноо)** Бүгдийг зөв эрэмбэлсэн бол 2 оноо. 1 эсвэл 2-ийг зөв эрэмбэлсэн бол 1 оноо

- А.** Бусад хүмүүсийн ярьж байгаа зүйл дээр анхаарлаа төвлөрүүлж, бусдын хүсэл зорилго, онцлог байдлыг харгалзан үзэх дуртай **3**
- Б.** Аливаа зүйлийг өөрийнхөөрөө хийх дуртай. **1**
- В.** Бусадтай хамтран хурдан хийх дуртай **2**





**14. Хийх ажлаа илүү сайн зохион байгуулахын тулд:**

**(2 оноо)** Бүгдийг зөв эрэмбэлсэн бол 2 оноо. 1 эсвэл 2-ийг зөв эрэмбэлсэн бол 1 оноо

- А.** Туршиж үзсэн аргуудыг дагахыг илүүд үздэг. **1**
- Б.** Тухайн арга барил тохирохгүй бол өөр аргаар хурдан шийднэ. **2**
- В.** Тухайн ажлыг хэрхэн хийснээ, дараагийн удаа хэрхэн яаж илүү сайн хийх вэ? гэдгийг эргэцүүлэн бодно. **3**

**15. Эрсдэлийг урьдчилан харж, түүнийг бууруулах арга замыг эрэлхийлэхийн тулд нэн түрүүнд ямар шийдвэр гаргах вэ?**

**(2 оноо)** Бүгдийг зөв эрэмбэлсэн бол 2 оноо. 1 эсвэл 2-ийг зөв эрэмбэлсэн бол 1 оноо

- А.** Гэнэтийн үйл явдлуудад хурдан, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх нь чухал **2**
- Б.** Нарийн төвөгтэй ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийг урьдчилан төлөвлөх нь чухал **3**
- В.** Хариуцлага хүлээх удирдагчийг томилох нь чухал **1**

**16. Тулгарсан бэрхшээлийг шийдэх арга замын аль нь хамгийн тохиромжтой вэ?**

**(2 оноо)** Бүгдийг зөв эрэмбэлсэн бол 2 оноо. 1 эсвэл 2-ийг зөв эрэмбэлсэн бол 1 оноо

- А.** Жижиг нарийн зүйлээс илүү том дүр зургийг харах **2**
- Б.** Хамтаараа боловсруулсан төлөвлөгөөгөө дагаж мөрдөх **1**
- В.** Өөрөө бүтээлч шийдвэр гаргах **3**



Сургалтын төгсгөлд суралцагчдаар ажиллуулах тест

### Г. Төслийн үнэлгээ

Суралцагчдын гүйцэтгэсэн төслийг дараах шалгуураар үнэлэх ба тухайн төслийн үнэлгээний үр дүн багийн бүх сурагчдад ижилхэн тооцогдоно.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ		1	2	3	4	5	6	7	8	9	10
1.	Төслийн зорилгоо орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн, бодитой дэвшүүлсэн байх										
2.	Төслийн зорилт нь зорилготой уялдсан байх										
3.	Төслийн үйл ажиллагаа зорилтын дагуу тодорхойлогдсон байх										
4.	Төслийн санхүүгийн нөөцийн тооцоо бодитой байх										
5.	Төслийн зардлууд зөв тооцоологдсон байх										
6.	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө оновчтой эсэх										
7.	Төслийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний мэдээлэл тодорхой эсэх										
8.	Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам орон нутгийн нөөцтэй нийцтэй эсэх										
9.	Төсөлд хамтран ажиллах байгууллагууд тэдний оролцоо тодорхой эсэх										
10.	Төслийг боловсруулахад гаргасан алдаагаа давтахгүй байх										

### Сургалтын эцсийн үнэлгээ

Сургалтын эцсийн үнэлгээг сургалтын явцад хийсэн суралцагчийн өөрийн болон найз нөхдийн үнэлгээнүүдийн дундаж, сургалтын төгсгөлд хийх тестийн дүн, төсөлт ажилд багшийн өгсөн үнэлгээний дүнгийн нэгтгэлээр тооцно.



### Сургалтын эцсийн үнэлгээг тооцох арга

<b>A</b> Өөрийн үнэлгээ дундаж	<b>B</b> Найз нөхдийн үнэлгээ дундаж	<b>C</b> Тестийн дүн	<b>D</b> Төслийн дүн	Сургалтын эцсийн дүн
25%	25%	15%	35%	100%
<b><math>0.25 * X = \dots\%</math></b> Өөрийн үнэлгээний дунджийн 25%-д ноогдох хувь	<b><math>0.25 * X = \dots\%</math></b> Найз нөхдийн үнэлгээний дунджийн 25%-д ноогдох хувь	<b><math>0.15 * X = \dots\%</math></b> Тестийн 15%-д ноогдох хувь	<b><math>0.35 * X = \dots\%</math></b> Төсөлт ажлын 35%-д ноогдох хувь	$A * 0.25 + B * 0.25 +$ $C * 0.15 +$ $D * 0.35 =$ $\dots\%$
Сэдэв 1,3,5-ын төгсгөлд	Сэдэв 2,4-ийн төгсгөлд	Сэдэв 7-ын төгсгөлд	Сэдэв 6-гийн төгсгөлд	

### Сорил

Сургалтын эхэнд болон төгсгөлд суралцагчид өөрийгөө үнэлэх сорил ажиллана. Энэ нь суралцагч өөрийнхөө хувь хүний ур чадварыг үнэлж байгаа сорил учир ямар нэгэн үнэлгээ тавигдахгүй. Үүнийг суралцагчийн гарын авлагын эхэнд (Сорил 1) болон сэдэв 7-д (Сорил 9) гэж тусгасан болно.



## Ажиглалтын рубрик үнэлгээ

### Рубрик гэж юу вэ?

Рубрик гэдэг нь тодорхой ур чадварыг үнэлэхэд ашигладаг үнэлгээний хэрэгсэл юм. Рубрикийг ихэвчлэн боловсролын салбарт сурагчдын гүйцэтгэлийг үнэлэхэд өргөн хэрэглэдэг. Хувь хүний ур чадварыг ойлгох ойлголт болон үнэлгээ өгөх хэмжүүр нь хүн бүрийн хувьд ялгаатай байдаг тул үнэлгээ хийхэд бэрхшээлтэй байдаг. Харин рубрик нь ур чадварыг нарийн задалж, үйлдэл дээр тулгуурлан ажиглагдаж болох жишээгээр тайлбарлан бичсэн байдаг тул хэн ч ижил хэмжүүрээр үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлдэг.

ESEL сургалтын хүрээнд сурагчдад олгохыг зорьж буй 6 ур чадвар болон 2 сэтгэлгээг дэд ур чадваруудад задлан, ур чадвар бүрийг 4 түвшин (хязгаарлагдмал, хөгжиж буй, чадварлаг, гоц сайн)-д ангилан уг рубрикийг боловсруулсан. Рубрикийг үнэлгээний хэрэгсэл болгон ашиглахаас гадна багш сурагчдын хамт ажиглалтын рубрикийг ашиглан бодитоор хувь хүний ур чадварыг сурагч ямар хэмжээнд эзэмшсэн болон түвшин ахиулахын тулд юун дээр анхаарах ёстой вэ гэдгээ эргэцүүлэн бодох боломжийг олгодог давуу талтай.

### Рубрикээр үнэлгээ хийх үед юуг анхаарах ёстой вэ?

- Үнэлгээ өгч буй хүний хувийн туршлага, хүйсийн хэвшмэл ойлголт буюу эрэгтэй хүн болон эмэгтэй хүнд тавих шаардлага, хүлээлт зэрэг нь ялгаатай байдаг тул үнэлгээний үр дүнд нөлөөлөл үзүүлдэг. Иймээс рубрикийн тухайн ур чадварыг илэрхийлэх түвшин бүрийн жишээтэй сайтар танилцаж, зөвхөн тухайн ур чадварын хүрээнд өгөгдсөн жишээ, үйлдэл дээр тулгуурлан үнэлгээ өгөх нь чухал.
- Сурагчдын өмнөх гүйцэтгэл, зан авир гэх мэт гадны хүчин зүйлсэд автахгүй байж, ур чадварын хүрээнд бүх оролцогчдод ижил шалгуурын дагуу дүгнэх.
- Үнэлгээг удаахгүй, тухайн ажлын явц эсвэл үр дүнг ойрхон үед нь хийх нь чухал ба хугацаа хэтэрсэн тохиолдолд бодит бус үнэлгээ хийж болзошгүй юм.

### Ажиглалтын рубрик үнэлгээг хийх заавар:

Үнэлгээ хийхийн өмнө рубрикийн агуулгатай сайтар танилцаж, ESEL хувь хүний ур чадварын талаарх нэгдсэн ойлголттой болсон байх нь чухал. Үүний дараагаар сурагчдыг дараах байдлаар үнэлэх боломжтой.

Жишээлбэл, Багш та тухайн сурагчийн "Өөрийн чадварт итгэх итгэл"-гэсэн дэд ур чадварыг:

**"Хязгаарлагдмал"** гэж үнэлж буй бол **1** оноо

**"Хөгжиж буй"** гэж үнэлж буй бол **2** оноо

**"Чадварлаг"** гэж үнэлж буй бол **3** оноо

**"Гоц сайн"** гэж үнэлж буй бол **4** оноогоор үнэлнэ.

## Рубрик үнэлгээг хэзээ хийх вэ?

Багш та сургалтын явцад дараах байдлаар ажиглалтын рубрик хуудсыг ашиглан суралцагчдын сэтгэлгээ, ур чадварын ахицыг үнэлэх боломжтой. Энэхүү ажиглалт нь суралцагчдын сэтгэлгээ, ур чадварыг үнэлэхээс илүүтэй суралцагчийн тухайн сэтгэлгээ, ур чадварын хөгжил нь үйл ажиллагаагаар нь хэрхэн илэрч буйг тэмдэглэх, цаашид ямар сэтгэлгээ, ур чадварыг нь хөгжүүлэх шаардлагатай, түүнд багшийн зүгээс хэрэгтэй чиглүүлэг, дэмжлэгийг тодорхойлоход чухал үүрэгтэй. Ажиглалтын рубрик нь сургалтын чухал процесс бөгөөд ажиглалтыг ямар байдлаар, хэзээ хийхээ багш өөрөө сонгоно. Дараах хоёр арга замыг санал болгож байна.

### I. Багш та сургалтын агуулгатай уялдуулан:

- Сэдэв 1-ийн дараагаар рубрикийн **“Өөрийгөө ойлгох, танин мэдэх”** болон **“Нийгэм, соёлыг танин мэдэх”** ур чадвар;
- Сэдэв 3-ын дараагаар **“Бүтээлч байдал ба инноваци”**, **“Харилцааны ур чадвар”** болон **“Багаар ажиллах”** ур чадвар;
- Сэдэв 5-ын дараагаар **“Тунгаан бодох”**, **“Энтрепренершип сэтгэлгээ”** болон **“Өсөн дэвших сэтгэлгээ”** зэрэг ур чадварын үнэлгээг хийх боломжтой.

---

### II. Сургалт эхлэхийн өмнө буюу сурагчдын суурь түвшинг тодорхойлох зорилгоор ашиглаж болно. Энэ үед багш ажиглалтын рубрикийг сурагчдад танилцуулах боломжтой ба ингэснээр сурагчид хувь хүний ур чадварын талаарх илүү бодит ойлголттой болж, ур чадварын хүрээнд багшаас ямар хүлээлттэй байгаа болон өөрийн хөгжих, сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлоход тусална. Үүний дараа сургалтын төгсгөлд дахин нийт ур чадварын хүрээнд үнэлгээ хийж, нийлбэр оноог сургалтын эхэнд хийсэн суурь үнэлгээтэй харьцуулалт хийх боломжтой. Ингэснээр, багшид сургалтын дараах ахиц дэвшлийг үнэлэх боломж бүрдэх юм.

## ESEL СУРГАЛТЫН АЖИГЛАЛТЫН РУБРИК

	ЧАДВАР	ХЯЗГААРЛАГДМАЛ 1	ХӨГЖИЖ БУЙ 2	ЧАДВАРЛАГ 3	ГАРАМГАЙ 4	ҮНЭЛГЭЭ
<b>ӨӨРИЙГӨӨ ОЙЛГОХ, ТАНИН МЭДЭХ</b>						
<b>1.</b>	<b>Өөрийн чадварт итгэх итгэл</b>	Тухайн сурагч ихэвчлэн урам зориг бага байдаг ба бэрхшээлтэй тулгарах үед хурдан бууж өгдөг. Өөртөө итгэх итгэлээ хөгжүүлэхийн тулд тэдэнд ихээхэн урам зориг, дэмжлэг хэрэгтэй байдаг.	Тухайн сурагчийн бие даасан байдал нь нөхцөл байдлаас хамааралтай байдаг. Урам зоригийн түвшин нь хэлбэлзэж, аливаад хандах тэсвэр тэвчээр нь тогтвортой биш байдаг. Өөртөө итгэх итгэлийг бий болгохын тулд тэдэнд тодорхой дэмжлэг шаардлагатай.	Тухайн сурагч ерөнхийдөө өөрсдийн чадварт итгэдэг ба зорилгодоо хүрэх урам зоригтой, бэрхшээлийг даван туулах чадвартаа итгэлтэй байдаг. Сурагч нь ихэвчлэн өөртөө зорилго тавьж, түүндээ хүрч, бэрхшээлтэй тулгарсан ч тууштай урагшилдаг.	Тухайн сурагч саад бэрхшээлтэй тулгарсан ч гэсэн биелэхэд хэцүү зорилгынхоо төлөө тууштай тэмүүлж, түүндээ хүрдэг. Сурагчийн өөртөө итгэх итгэл нь суралцахуйн амжилт болон, бэрхшээлийг даван туулах чадварт нь эергээр нөлөөлдөг.	
<b>2.</b>	<b>Сэтгэл хөдлөлөө таних</b>	Тухайн сурагч баяр хөөр, уур хилэн зэрэг хамгийн нийтлэг сэтгэл хөдлөлийг таньж мэдэхэд хүртэл бэрхшээлтэй байдаг. Жишээлбэл, тэд хэн нэгний догдолсон байгааг ууртай байна гэж эндүүрэх нь бий	Тухайн сурагч нь баяр хөөр, уур хилэн зэрэг нийтлэг сэтгэл хөдлөлийг ил тод байгаа үед таньж чаддаг ч үл анзаарагдам нүүрний хувирлыг таньж мэдэхдээ хэцүү байдаг.	Тухайн сурагч баяр хөөр, уйтгар гуниг, уур хилэн, айдас зэрэг өөрт болон бусад хүмүүсийн нийтлэг сэтгэл хөдлөлийг зөв таньж чаддаг. Жишээлбэл, тэд даалгавраа амжилттай гүйцэтгэсний дараа ангийн найз нь баяр хөөртэй байгааг эсвэл найз нь асуудлаас болж бухимдаж байгааг анзаарч чаддаг.	Тухайн сурагч бусдын нүүрний хувирал, биеийн хэлэмж, дуу хоолойны өнгө зэргээс нь бухимдсан эсвэл урам хугарсан гэх мэт сэтгэл хөдлөлийн нарийн ялгааг хүртэл сайтар ялгаж таньж чаддаг.	



3.	<b>Сэтгэл хөдлөлөө удирдах</b>	Тухайн сурагч ихэнхдээ бодолгүйгээр үйлдэл хийдэг ба сэтгэл хөдлөлөө удирдахдаа бэрхшээлтэй байдаг. Жишээлбэл, тэд өөрийн ээлжийг хүлээхгүй ярих зэргээр хичээлийг үймүүлэх эсвэл үйл ажиллагаанд ээлж дараагаа хүлээхээс төвөгшөөдөг.	Тухайн сурагч зарим тодорхой нөхцөл байдалд өөрийн сэтгэл хөдлөлөө удирдаж, зарим үед чаддаггүй. Жишээлбэл, тэд гараа өргөхгүйгээр хичээл дээр ярьдаг.	Тухайн сурагч харилцан ярианы үеэр бусдын яриаг таслахгүйгээр тэвчиж эсвэл багийн үйл ажиллагааны үеэр өөрийн ээлжээ хүлээж, тэвчээртэй байж чаддаг.	Тухайн сурагч ямар ч нөхцөл байдалтай тулгарсан сахилга баттай байж, биеэ барих чадвартай байдаг. Жишээлбэл, тэд хэцүү, сорьсон асуулт эсвэл нөхцөл байдалд бодолгүй хариу үйлдэл үзүүлэхгүйгээр тайван, анхааралтай байж чаддаг.
4.	<b>Цагийн хуваарилалт</b>	Тухайн сурагчид даалгавраа эрэмбэлэх, цагийг үр дүнтэй хуваарилах нь хүндрэлтэй байдаг ба аливаа ажлыг хугацааг нь тулгаж хийдэг эсвэл хугацаанд нь хийхгүй үлдээдэг.	Тухайн сурагч цагаа төлөвлөж чаддаг ч тууштай биелүүлж чаддаггүй. Аливаа ажил, гэрийн даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэхийн тулд хичээж байгаа.	Тухайн сурагч ажлаа эрэмбэлж, цагаа үр дүнтэй төлөвлөж, ихэвчлэн ажлуудаа заасан хугацаанд нь хийж гүйцэтгэдэг.	"Тухайн сурагч өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд цагаа чадварлагаар төлөвлөж чаддаг ба аливаа ажлыг хугацаанаас нь өмнө тогтмол биелүүлж, үе тэнгийнхэндээ цагаа зөв зохицуулах үлгэр дуурайлал нь болдог."
5.	<b>Стрессээ удирдах</b>	Тухайн сурагч ихэвчлэн стресст сөрөг хариу үйлдэл үзүүлдэг ба стрессээ бууруулах үр дүнтэй аргыг мэддэггүй. Жишээлбэл, тэд стресстэй үедээ хэт их сандарч, сэтгэл хөдлөлдөө автдаг.	Тухайн сурагч бага зэрэг стресстэй нөхцөл байдалд өөрийгөө удирдаж чаддаг ч төвөгтэй эсвэл маш их стресстэй нөхцөл байдалд сэтгэл хөдлөлдөө автдаг. Жишээлбэл, тэд стрессээ бууруулах арга техникийг мэддэг ч байнга хэрэглэдэггүй ба бусдын заавар чиглүүлэг хэрэгтэй байдаг.	Тухайн сурагч стрессээ үр дүнтэй удирдахын тулд биеийн тамирын дасгал хийх, тайвшруулах дасгал хийх, бусдаас дэмжлэг авах гэх зэргээр стрессээ бууруулах аргыг ашигладаг. Тэд хааяа стресстдэг ч хурдан тайвширдаг.	Тухайн сурагч стрессээ даван туулахын тулд гүнзгий амьсгалах, өөртэйгөө эерэг яриа өрнүүлэх зэрэг олон төрлийн аргыг ашигладаг. Тэд хүнд хэцүү үед ч тайван байдлаа хадгалж, шаардлагатай үед бусдын тусламжийг авч чаддаг.

6.	<b>Өөрийн талаарх бодит үнэлгээ</b>	Тухайн сурагч ихэвчлэн өөрийнхөө сул талыг анзаардаггүй ба өөрийн талаарх бодит бус ойлголттой байдаг. Жишээлбэл, тэд заримдаа өөрсдийн чадвараа хэтрүүлэн үнэлж, эсвэл өөрсдийн сул талаа дутуу үнэлдэг.	Тухайн сурагч өөрийн давуу болон сул талын талаарх тодорхой ойлголттой байдаг ч өөрийнхөө талаарх уг ойлголт нь тийм ч өргөн хүрээтэй биш байдаг ба өөр өөр нөхцөл байдалд ялгаатайгаар өөрийгөө дүгнэдэг.	Тухайн сурагч өөрийн давуу тал болон сул талуудынхаа талаар сайн ойлголттой байдаг. Тэд бусдын санал хүсэлтэд нээлттэй ханддаг бөгөөд хөгжүүлэх хэрэгцээ байгаа талаа хүлээн зөвшөөрч чаддаг.	Тухайн сурагч өөрсдийн чадвар болон сул талаа үнэн зөв, бодитоор үнэлж дүгнэдэг бөгөөд бусдын санал зөвлөмжид үргэлж нээлттэй байдаг.
<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>					
<b>Тайлбар:</b>					

## НИЙГЭМ, СОЁЛЫГ ТАНИН МЭДЭХ

1.	<b>Бусдын байр сууринд өөрийгөө тавих</b>	Тухайн сурагч эргэн тойрныхоо хүмүүсийн сэтгэл хөдлөлийг үл тоомсорлож, тэднийг буруу ойлгож, бусдад зохих дэмжлэг, тайтгарлыг өгөх чадвар дутмаг.	Тухайн сурагч энгийн нөхцөл байдалд бусдын оронд өөрийгөө тавьж чаддаг ч нарийн төвөгтэй нөхцөл байдалд уг чадвар нь хязгаарлагдмал байдаг. Жишээлбэл, тэд найз нөхөддөө дэмжлэг үзүүлдэг ч танихгүй хүмүүсийн сэтгэл хөдлөлийг ойлгох нь тэдэнд хэцүү байдаг.	Тухайн сурагч ихэвчлэн бусдыг анхааралтай сонсож, тохиромжтой үед тайтгарал, туслалцаа үзүүлэх замаар бусдын оронд өөрийгөө тавьж чаддаг. Тэдэнд үе үе сануулга хэрэгтэй байж болох ч ихэвчлэн бусдын оронд өөрийгөө тавьдаг.	Тухайн сурагч найзуудынхаа үгийг идэвхтэй сонсож, чин сэтгэлээсээ санаа тавьж, шаардлагатай үед дэмжлэг үзүүлдэг. Тэд эргэн тойрныхоо хүмүүсийн сэтгэл хөдлөлийг амархан таньж, зохистой хариу үйлдэл үзүүлж чаддаг.
2.	<b>Ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах</b>	Тухайн сурагч ялгаатай соёл, үндэс угсаатай хүмүүсийн талаар суралцах эсвэл тэдэнтэй харилцах сонирхол хязгаарлагдмал ба тэдэнд хувь хүн болон соёлын ялгааг хүндэтгэх, ойлгоход бэрхшээлтэй байдаг.	Тухайн сурагч энгийн нөхцөл байдалд бусдын соёл, үндэс угсааны ялгаатай байдлыг ойлгож чадах хэдий ч танил бус нөхцөл байдалд ялгаатай байдлыг ойлгодоггүй.	Тухайн сурагч соёл болон үндэс угсаа ялгаатай хүмүүстэй идэвхтэй харилцаж, янз бүрийн соёл, гарал үүслийн талаар суралцахад нээлттэй байдаг.	Тухайн сурагч хүмүүсийн соёл, үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, гарал үүслийн ялгааг ойлгож, хүлээн авахыг идэвхтэй эрэлхийлдэг. Жишээ нь, тэд өөр өөр гарал үүсэлтэй үе тэнгийнхэнтэйгээ хүндэтгэлтэй яриа өрнүүлж чаддаг.



3.	<b>Бусдыг хүндлэх</b>	Тухайн сурагч ихэнхдээ бусдын оруулсан хувь нэмрийг үл тоомсорлож эсвэл бусдад зохистой санал зөвлөмжийг өгдөггүй.	Тухайн сурагч хааяа эерэг санал зөвлөмж гаргадаг ч бусадтай идэвхтэй хамтран ажиллаж, анхааралтай сонсдоггүй.	Тухайн сурагч багийн ажилд идэвхтэй оролцож, санал зөвлөмжөө бүтээлчээр илэрхийлж, хувь хүн бүрийн багт үзүүлж буй үнэ цэнийг ойлгодог.	Тухайн сурагч бусдыг идэвхтэй сонсож, эерэг санал зөвлөмж гаргаж, багийн ажилд үр дүнтэй хамтран ажиллаж, гишүүн бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлдэг.
4.	<b>Аливааг олон талын өнцгөөс харах</b>	Тухайн сурагч ихэвчлэн бусдын ялгаатай санал бодлыг үгүйсгэж, зөвхөн өөрийн үзэл бодолтой таарсан хүмүүстэй харилцахыг хүсдэг.	Тухайн сурагч хааяа ялгаатай үзэл бодолтой хүмүүстэй санал солилцдог ч аливааг олон талаас харах үзэл бодлыг идэвхитэйгээр эрэлхийлдэггүй.	Тухайн сурагч бусдын санаа бодлыг идэвхтэй сонсож, ялгаатай үзэл бодлыг агуулсан ярианд оролцож, хүндэтгэлтэй ханддаг.	Тухайн сурагч ээдрээтэй асуудлын талаар нухацтай ярилцаж, олон талын санал бодлыг харгалзан үзэж, эсрэг тэсрэг үзэл бодолтой хүмүүсийг ч ойлгож, хүндэтгэлтэй харилцдаг.
5.	<b>Ёс зүйтэй үйлдэл гаргах</b>	Тухайн сурагч хууран мэхлэх, хуулах, бусдын оюуны өмчийг хүндэтгэхгүй байх зэрэг ёс зүйгүй үйлдэл хийх нь элбэг.	Тухайн сурагч бусдын гэрийн даалгаврыг хааяа хуулдаг ч ерөнхийдөө шалгалтын үеэр хуулахаас зайлсхийдэг.	Тухайн сурагч даалгавраа хэн нэгний санааг хуулахгүйгээр гүйцэтгэж, бусдын санааг хүндэтгэж, зохих үед ёс зүйгүй үйлдлийн эсрэг дуугардаг.	Тухайн сурагч бусдыг хууран мэхлэхээс татгалзаж, бусдын өмч хөрөнгө, санаа бодлыг үргэлж хүндэтгэж, ёс зүйгүй үйлдэлтэй тулгарах үед эсэргүүцлээ илэрхийлдэг.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				

## БҮТЭЭЛЧ БАЙДАЛ БА ИННОВАЦИ

<b>1.</b>	<b>Боломжийг таних</b>	Тухайн сурагч нүдний өмнө байгаа өсөлт, өөрчлөлт авчрах боломжийг ч ихэвчлэн анзаардаггүй.	Тухайн сурагч өсөн дэвжих том боломжийг эрэлхийлдэг боловч, боломжийг ашиглах гэж хичээдэггүй.	Тухайн сурагч багийн хэлэлцүүлгийн үеэр тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх шинэ арга зам, боломжийг тодорхойлж чаддаг.	Тухайн сурагч багийн ажлын үр дүнг сайжруулах шинэ санааг идэвхтэй тодорхойлж, зах зээл дэх хэрэгцээг олж илрүүлэх, түүнийг шийдвэрлэх бүтээлч бизнесийн санааг санал болгодог.
<b>2.</b>	<b>Шинэ санааг эрэлхийлэх</b>	Тухайн сурагч багийн ажлын үр дүнд саад учруулж болзошгүй хязгаарлагдмал эсвэл давтагдсан санааг байнга санал болгодог.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа бусдаар шаардуулсан үед шинэ санаа дэвшүүлдэг ч багийн ажил нарийн төвөгтэй болоход шинэлэг эсвэл олон талын санааг тууштай дэвшүүлдэггүй.	Багаараа санал солилцох үеэр тэд багийн ажлын төлөвлөгөө болон асуудлын шийдлийг олох үнэ цэнтэй санаануудыг санал болгож, бүтээлч сэтгэлгээг чадварлагаар харуулдаг.	Багаараа санал солилцох үеэр тэд шинэлэг, олон янзын санаануудыг гаргаж ирдэг ба ихэнхдээ өөрсдийн бүтээлч чадвараараа бусдыг урамшуулж, багийн ажлын амжилтад ихээхэн хувь нэмэр оруулдаг.
<b>3.</b>	<b>Боломжийг эрэлхийлэх, төсөөлөх</b>	Тухайн сурагч ихэвчлэн асуудлыг шийдвэрлэх өөр хувилбаруудыг бодож сэтгэхэд идэвхтэй оролцдоггүй ба бүтээлч боломжуудыг судлахад чухал хувь нэмэр оруулдаггүй.	Тухайн сурагч бусад хүмүүс асуувал асуудлыг шийдвэрлэх өөр аргуудыг санал болгодог ч олон талын арга замуудыг байнга идэвхтэйгээр бодож сэтгэдэггүй.	Тухайн сурагч багийн ажлын үр дүнг сайжруулах бүтээлч шийдлүүдийг санал болгодог ба багийн хэлэлцүүлгийг идэвхжүүлэх шинэлэг аргуудыг ашигладаг. Тэд боломжуудыг эрэлхийлэхэд идэвхтэй хувь нэмрээ оруулж, бусдыг ч мөн адил сэдэлжүүлж, чиглүүлдэг.	Бэрхшээлтэй тулгарвал тэд ердийн сэтгэлгээнээс давсан шинэлэг, уран сэтгэмжтэй шийдлүүдийг дэвшүүлж чаддаг. Тэд өөр арга замыг байнга бодож, алсын харааг төсөөлөн харж, бусдад урам зориг өгдөг.



4.	<b>Алсын хараа тодорхойлох</b>	Тухайн сурагч аливаа ажилд ихэнхидээ тодорхой алсын хараатайгаар ханддаггүй ба алсыг хэрхэн төсөөлж буйгаа багийн гишүүддээ үр дүнтэйгээр ойлгуулж чаддаггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа бусад хүмүүс асуусан эсвэл багийн ажлын зорилго нь ойлгомжтой үед алсын харааг тодорхойлж чадна. Гэсэн хэдий ч тэд нарийн төвөгтэй асуудлын хүрээнд тодорхой алсын харааг тодорхойлж чаддаггүй.	Тухайн сурагч багийн ажлын зорилго болон зорилгыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх алсын харааг оновчтой тодорхойлж чаддаг.	Тухайн сурагч багийн гишүүдийг идэвхжүүлж, шинэлэг, үр дүнтэй аргаар хамтын зорилгод хүрэх алсын харааг тодорхойлж чаддаг.
5.	<b>Гаргасан санаагаа турших</b>	Тухайн сурагч шинэлэг шийдлүүдийг турших ажилд ихэнхидээ идэвхгүй байдаг ба бүтээлч санааг дэвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа бусад хүн шаардсан эсвэл туршилт хийхийг нь дэмжсэн үед бүтээлч санааг дэвшүүлдэг боловч шинэ үзэл баримтлал, хандлагыг байнга идэвхтэй судалж чаддаггүй.	Тухайн сурагч багийн ажлын үр дүнг сайжруулах шийдлүүдийг санал болгодог ба санаагаа турших ажилд идэвхтэй оролцож, бусдыг ч мөн адил хийхийг урамшуулдаг.	Тухайн сурагч багийн хэлэлцүүлгийн үеэр уран сэтгэмжтэй, шинэлэг шийдлүүдийг байнга санал болгож, туршилтад идэвхтэй оролцож, шинэлэг сэтгэлгээгээр бусдад урам зориг өгдөг.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				

### ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР

1	<b>Идэвхтэй сонсох</b>	Тухайн сурагчид анхаарлаа хандуулах, бусадтай харцаараа харилцаа тогтоох эсвэл бусдын санааг ойлгож, тохирсон хариулт өгөх чадвар дутмаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа тэдний сонирхлыг ихэд татсан үед бусдыг идэвхтэй сонсдог ч сонирхол татаагүй яриаг анхааралтай сонсдоггүй.	Тухайн сурагч бусадтай харцаараа сайн харилцаж, толгой дохиж, илүү сайн ойлголттой болохын тулд холбогдох асуултуудыг асууж чаддаг. Тэд бусдын илэрхийлсэн гол санааг ойлгож, хэлэлцүүлэгт утга учиртай хувь нэмэр оруулах чадвартай.	Хэлэлцүүлгийн үеэр тэд тодруулах асуулт асууж, бусдын хэлснийг ойлгосон гэдгээ бататгаж, анхааралтай сонсож байгааг илтгэх хариултуудыг өгдөг.
---	------------------------	---	---	---	--



2	<b>Асуулт асуух</b>	Тухайн сурагч ихэвчлэн асуулт асуухаас зайлсхийж, эсвэл хамааралгүй эсвэл ач холбогдол багатай асуултуудыг асуудаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа тодруулга авах шаардлагатай үед асуулт асуудаг. Гэсэн хэдий ч тэд бүх нөхцөл байдалд асуулт асуухад идэвхтэй оролцдоггүй.	Тухайн сурагч тодруулга авах, шүүмжлэлтэй сэтгэх, сэдвийг илүү сайн ойлгохын тулд асуултуудыг тавьдаг. Тэд утга учиртай асуулт асууж хэлэлцүүлэгт идэвхтэй оролцдог.	Тухайн сурагч ердийн сэтгэлгээг сорьсон асуултуудыг тавьж, утга учиртай яриа өрнүүлж, сэдвийн талаар гүн гүнзгий сониуч зангаа харуулсан асуулт асуудаг.
3	<b>Хариултыг ойлгох</b>	Тухайн сурагч ихэвчлэн бусдын өгсөн тайлбарт төөрөлдсөн мэт харагддаг ба ялангуяа илүү нарийн төвөгтэй нөхцөлд тайлбарыг дагаж мөрддөггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд бусдын хариултыг ойлгодог боловч нарийн төвөгтэй хариултуудыг ойлгоход бэрхшээлтэй байдаг ба шаардлагатай үед ч гэсэн тодруулах асуулт асуудаггүй.	Тухайн сурагч шаардлагатай үед тодруулах асуулт асууж, танилцуулсан мэдээлэлд идэвхтэй оролцож, өгсөн агуулгыг сайн ойлгодог.	Хэлэлцүүлэгт оролцох эсвэл санал хүсэлт хүлээн авахдаа тэд зөвхөн хариултыг ойлгохоос гадна мэдээллийг задлан шинжилж, агуулгын гүн гүнзгий ойлголтыг ойлгохыг хичээдэг.
4	<b>Өөрийн санааг тайлбарлах</b>	Тухайн сурагч ихэвчлэн өөрийн санааг тайлбарлахдаа тодорхой бус, уялдаа холбоогүй зүйл ярьдаг тул бусдад тэдний үзэл бодлыг ойлгоход хэцүү байдаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа сэдэв нь танил эсвэл ойлгомжтой үед ойлгоход хялбар тайлбар өгдөг ч нарийн төвөгтэй санааг бусдад дамжуулахад бэрхшээлтэй байдаг.	Тухайн сурагч өөрсдийн үзэл бодлыг хэлэлцүүлгийн үеэр эсвэл бичгээр өгөхдөө логик тайлбар, холбогдох жишээнүүдийг ашиглаж өөрийн санаагаа ойлгомжтой илэрхийлж чаддаг.	Илтгэл эсвэл хэлэлцүүлгийн үеэр тэд бүрэн тайлбар өгч, анхаарал татахуйц жишээ, зүйрлэлийг ашиглаж, эмх цэгцтэй яриагаар сонсогчийн анхаарлыг татаж чаддаг.
5	<b>Аман болон аман бусаар өөрийн санааг илэрхийлэх</b>	Тухайн сурагчийн яриа бусдад ихэвчлэн ойлгомжгүй байдаг ба дохио зангааг тохиромжтой ашигладаггүй тул бусдад тэдний бодол санаа, зорилгыг ойлгоход хэцүү байдаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд өөрийн санаагаа тодорхой илэрхийлж чаддаг ч дохио зангааг байнга үр дүнтэй ашиглаж чаддаггүй.	Хэлэлцүүлгийн үеэр тэд харцаараа бусадтай сайн харилцаж, гол санааг онцлон тэмдэглэхийн тулд зохих дохио зангааг ашиглаж, бодлоо үр дүнтэй бусдад дамжуулдаг.	Тухайн сурагч харцаараа бусадтай харилцаж, аман болон дохио зангааг чадварлагаар ашиглаж, сонсогчийг анхаарлыг сайтар татдаг.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				



**БАГААР АЖИЛЛАХ**

1	<b>Хамтын зорилго</b>	Тухайн сурагч ихэвчлэн чин сэтгэлээсээ бусдад ханддаггүй ба багийн хамтын зорилгыг сонирхохгүй байгаа мэт мэт харагддаг, эсвэл хамтын зорилгынхоо төлөө бусадтай хамтран ажилладаггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд хамтын хүчин чармайлт гаргахад оролцдог хэдий ч нөхцөл байдлаас хамаарч багийн зорилгын төлөө идэвхтэй хувь нэмэр оруулдаггүй.	Тухайн сурагч санал бодлоо хуваалцаж, хэлэлцүүлгийн үеэр хамтын зорилгод анхаарлаа төвлөрүүлж, багийн гишүүдэд түүндээ хүрэхэд нь идэвхтэй дэмжлэг үзүүлдэг.	Тухайн сурагч багийн гишүүдээ нэгтгэх, тодорхой зорилго тавьж, түүндээ хүрэхийн төлөө хүн бүрийг тууштай байлгахад манлайлах үүрэг гүйцэтгэдэг. Тэд багаа урамшуулж, үлгэр дуурайлал үзүүлдэг.
2	<b>Төлөвлөх болон хэрэгжүүлэх</b>	Тухайн сурагчийн төлөвлөлт ихэвчлэн тодорхой бус байдаг ба төлөвлөлтөд үр дүнтэй цаг хугацааг хуваарилж чаддаггүй. Аливааг үр дүнтэй зохион байгуулахад тэдэнд хүндрэлтэй байдаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа даалгавар нь энгийн эсвэл өөрсдөө маш их урам зоригтой байх үед зохион байгуулалттай төлөвлөгөө гаргаж чаддаг. Гэсэн хэдий ч нарийвчилсан төлөвлөгөөг тууштай боловсруулж чаддаггүй ба нөөцийг үр дүнтэй хуваарилдаггүй.	Тухайн сурагч тодорхой зорилго, цаг хугацааг тогтоож, гол үе шатуудыг тодорхойлж, нөөцийг үр ашигтай хуваарилж, багийн ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.	Нарийн төвөгтэй даалгавар гүйцэтгэх үед тэд цогц төлөвлөгөө боловсруулж, цаг хугацаа, нөөцийг үр ашигтай хуваарилдаг ба ажлыг хугацаанд нь өндөр чанартай гүйцэтгэдэг.
3	<b>Нөөцөө хуваалцах</b>	Тухайн сурагч өөрт байгаа нөөцөө хуваалцахаас байнга татгалздаг ба нөөцийг хуваалцах боломжуудад идэвхтэй оролцдоггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа бусдаар шаардуулсан эсвэл тодорхой хэрэгцээ гарсан үед нөөцөө хуваалцдаг.	Тухайн сурагч багийн ажлын үеэр бусдад тусалж, хичээлийн тэмдэглэлээ хуваалцаж, хэрэгцээт материалуудыг олж авах боломжийг бусдад олгодог.	Тухайн сурагч уншсан судалгааны үр дүнгээ хуваалцаж, хамтдаа суралцах болон бусдыг сайжруулах тал дээр өөрийн цаг заваа идэвхтэй зарцуулдаг.

4	<b>Санал зөвлөмж өгөх ба бусдын санал зөвлөмжийг хүлээн авах</b>	Тухайн сурагч ихэвчлэн санал хүсэлт өгөхөөс зайлсхийх эсвэл бусдын саналыг хүлээн авахдаа тааламжгүй байдаг ба энэ нь тэдний өөрийн болон бусдын өсөлт хөгжилд саад болдог.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд санал хүсэлтээ өгөх ч энэ нь ихэвчлэн асуусан үед эсвэл зайлшгүй өгөх шаардлагатай үед тохиодог. Гэсэн хэдий ч санал хүсэлт өгөх эсвэл бусдаас санал хүсэлтийг нь хүлээн авах боломжийг байнга эрэлхийлдэггүй ба тэдний өгөх санал хүсэлт нь тодорхой бус байдаг.	Тухайн сурагч бусдын ажлыг сайжруулахад туслах оновчтой санал зөвлөмжийг өгдөг ба тэдэнд өгсөн санал хүсэлтийг мөн идэвхтэй сонсож, өөрийн гүйцэтгэлийг сайжруулахад ашигладаг.	Тухайн сурагч бусдын санал зөвлөмжийг идэвхтэй сонсож, хувь хүний өсөлтөд бусдын өгөх санал зөвлөмжийн үнэ цэнэтэй болохыг хүлээн зөвшөөрдөг. Тэд бусдад тодорхой, үр дүнтэй, бүтээлч санал зөвлөмжийг өгдөг.
5	<b>Зөрчлийг бүтээлчээр шийдвэрлэх</b>	Тухайн сурагч ихэвчлэн зөрчилдөөнийг хурцатгах эсвэл үндсэн асуудлыг шийдвэрлэхээс зайлсхийж, асуудлыг хурцадмал байдалд хүргэдэг.	Тухайн сурагч зарим зөрчилдөөнийг шийдвэрлэхэд үр бүтээлтэйгээр оролцдог хэдий ч бүх зөрчилдөөнийг бүтээлч байдлаар шийдвэрлэх гэж хичээдэггүй.	Тухайн сурагч зөрчилдөөнтэй үзэл бодлыг сонсож, санаа зовж буй асуудлаа тодорхой илэрхийлж, үндсэн асуудлыг шийдвэрлэх шийдлийг хайж, эерэг үр дүнд хүрэхийн төлөө ажилладаг.	Тухайн сурагч бүх талуудыг анхааралтай сонсож, нийтлэг үндэслэлийг олж, хүн бүрийн хэрэгцээг хангахуйц эерэг, хамтын ажиллагааны уур амьсгалыг бий болгох замаар зөрчилдөөнийг зохицуулдаг.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				
<b>ТУНГААН БОДОХ</b>					
1	<b>Мэдээлэл цуглуулах</b>	Тухайн сурагч ихэвчлэн хязгаарлагдмал эсвэл баталгаагүй эх сурвалжид найдаж, төслийн амжилтад төдийлөн нэмэр болохгүй мэдээллийг цуглуулдаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд үр дүнтэй судалгааны арга, эх сурвалжийг ашигладаг хэдий ч мэдээлэл цуглуулах найдвартай аргыг тууштай хэрэгжүүлэхийн төлөө ажилладаггүй.	Тухайн сурагч төслийн зорилго, зорилтыг дэмжих мэдээлэл цуглуулахын тулд шинэ мэдээлэл хайж, эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж, холбогдох	Төслийн хүрээнд тэд эрдэм шинжилгээний сэтгүүл, номноос мэдээлэл авч, судалгаа явуулж, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж,



				оролцогч талуудтай ярилцлага хийж, зах зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг.	төслийн амжилтад шаардлагатай үнэн зөв, олон талт мэдээллийг цуглуулахын тулд хичээдэг.
2	<b>Учир шалтгаанд дүн шинжилгээ хийх</b>	Тухайн сурагч ихэвчлэн ач холбогдолтой учир шалтгааныг үл тоомсорлож, төслийн зорилтод нөлөөлж буй хүчин зүйлийн талаар ойлгохыг хичээдэггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд асуудлын учир шалтгаанд дүн шинжилгээ хийдэг хэдий ч нарийвчилсан, гүн гүнзгий шалтгааныг олж тогтоохын төлөө хичээдэггүй.	Тухайн сурагч логик үндэслэл ашиглан асуудлын үндсэн шалтгааныг тодорхойлж, төсөлтэй холбоотой асуудлыг оновчтой шийдвэрлэх шийдлүүдийг санал болгодог.	Төслийн сорилт, асуудлыг шийдвэрлэхдээ тэд нарийн төвөгтэй шалтгааныг тодорхойлж, цогц шийдлийг боловсруулахын тулд нарийн дүн шинжилгээ хийдэг.
3	<b>Дасан зохицох</b>	Тухайн сурагч өөрчлөлтийг байнга эсэргүүцэж, уян хатан байдаггүй ба шинэ мэдээлэл, шаардлагыг биелүүлэхэд бэрхшээлтэй байдаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд өөрчлөлт, сорилтод дасан зохицдог хэдий ч мэдэгдэхүйц өөрчлөлтүүдийг хүлээн авахын тулд тэдэнд хугацаа хэрэгтэй байдаг. Эсвэл шинэ нөхцөл байдалтай тулгарах үед дасан зохицохыг эсэргүүцдэг.	Төслийн ахиц дэвшлийг хадгалах, зорилгодоо үр дүнтэй хүрэхийн тулд тэд гэнэтийн асуудалтай тулгарах, цаг хугацааны хуваарийг өөрчлөх, өөр шийдлүүдийг эрэлхийлэх үед уян хатан байж чаддаг.	Урьдчилан таамаглаагүй саад бэрхшээлтэй тулгарах үед тэд төслийн төлөвлөгөөг идэвхтэй өөрчилж, нөөцийг өөрөөр хуваарилж, нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа хэдий ч төслийн амжилтыг баталгаажуулахын тулд багийн гишүүдтэй үр дүнтэй хамтран ажилладаг.
4	<b>Ёс зүйтэй шийдвэр гаргах</b>	Тухайн сурагч ихэвчлэн ёс зүйн зарчмуудыг үл тоомсорлож, эргэлзээтэй үйлдэл хийх эсвэл ёс зүйн хүндрэлийг үр дүнтэй шийдвэрлэхгүй орхидог.	Тухайн сурагч зарим нөхцөлд ёс зүйн зарчмуудыг тууштай хэрэгжүүлэхийн төлөө тэмцдэг ч илүү төвөгтэй нөхцөл байдалд ёс суртахууны асуудлыг тэр бүр чухалчилдаггүй.	Тухайн сурагч ёс зүйн асуудалд нухацтай хандаж, шаардлагатай үед багийн гишүүдтэй зөвлөлдөж, ёс зүйн зарчимд нийцсэн шийдвэр гаргаж, үйл ажиллагаа нь үнэнч шударга, хүндэтгэлтэй байхад анхаардаг.	Ёс зүйн асуудалтай нүүр тулгарсан үед тэд ёс зүйн зарчмыг дагахыг идэвхтэй эрэлхийлж, оролцогч талуудтай ил тод харилцаж, ихээхэн золиос шаардсан ч шударга байдлыг эрхэмлэх шийдвэр гаргадаг.

5	<b>Эргэцүүлэн тунгаах</b>	Тухайн сурагч ихэвчлэн төсөл дээр ажиллахдаа аливааг үр дүнтэй эргэцүүлэн бодохоос зайлсхийдэг ба ихэвчлэн эргэцүүлэн бодох боломжийг үл тоомсорлодог. Энэ байдал нь тэдний төслийн туршлагаасаа суралцах чадварт нь саад болдог.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд асуудлыг эргэцүүлэн бодох ч төслийн бүх үе шатанд аливааг нарийн оновчтой тодорхойлж, эргэцүүлэн бодох гэж хичээдэггүй.	Тухайн сурагч гүйцэтгэлээ үнэлэх, сурсан зүйлсээ тодорхойлох, шаардлагатай бол төслийн чухал үе шатанд ч гэсэн түр завсарлага авч чаддаг. Тэдний эргэцүүлэл нь төслийн үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.	Тухайн сурагч төслийн нарийвчилсан тэмдэглэл хөтөлж, ахиц дэвшилд тогтмол дүн шинжилгээ хийж, сайжруулах шаардлагатай зүйлсийг тодорхойлдог. Тэдний эргэцүүлэл нь төслийн ажилд утга учиртай ойлголт, бодит сайжруулалтыг бий болгодог.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				

## ӨСӨН ДЭВШИХ СЭТГЭЛГЭЭ

1.	<b>Хичээл зүтгэл гаргах болон дадлагажих</b>	Тухайн сурагч өсөн дэвших сэтгэлгээг ойлгож, нэмэлт хүчин чармайлт гаргах эсвэл бодитоор туршсанаар хийснээр өөрийгөө сайжруулж болно гэдэгт итгэдэггүй.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд, ялангуяа ур чадвараа хөгжүүлэх, хэрэгцээтэй үедээ чадвараа сайжруулахын тулд хичээл зүтгэл гаргадаг ч энэ байдал нь тогтвортой бус ба нөхцөл байдлаас шалтгаалан ялгаатай байдаг.	Тухайн сурагч байнгын хүчин чармайлтаар өөрийн ур чадвараа сайжруулахыг хичээдэг ба төслийн гүйцэтгэлийг сайжруулах нэмэлт бодитоор турших боломжийг эрэлхийлдэг.	Тухайн сурагч ур чадварыг шаргуу хөдөлмөр, байнгын туршлагаар хөгжүүлж болно гэдэгт бүрэн итгэдэг ба ур чадвараа сайжруулахын тулд төслийн шаардлагаас давсан боломжийг тууштай эрэлхийлдэг.
2.	<b>Алдаанаас суралцах</b>	Тухайн сурагч гаргасан алдаагаа эргэцүүлэх нь ховор ба алдаагаа хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийдэг.	Тухайн сурагч тодорхой нөхцөл байдалд алдаагаа хүлээн зөвшөөрдөг хэдий ч олж авсан сургамжаа тууштай хэрэгжүүлдэггүй.	Тухайн сурагч алдаа гаргах нь суралцах үйл явцын нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэд төслийн явцад алдаа эсвэл сорилттой тулгарахдаа тэдгээрийг	Төслийн явцад бүтэлгүйтэл, бэрхшээлтэй тулгарах үед тэд үүнийг өсөн дэвших боломж гэж үздэг. Тэд алдаагаа тунгаан бодож,



				<p>эргэцүүлэн бодож, хэрхэн сайжруулах талаар бусдаас санал зөвлөмж авдаг. Тэд сурсан сургамжаа төслийн ажилдаа тусгаж чаддаг.</p>	<p>бүтээлч санал хүсэлтийг эрэлхийлж, олж авсан сургамжаа идэвхтэй ашигладаг. Жишээлбэл, тэд алдаа гарсны дараа хурдан дасан зохицож, төслийн туршид мэдэгдэхүйц өсөлт, тэсвэр тэвчээрийг харуулдаг.</p>
3.	<b>Тууштай байдал</b>	<p>Тухайн сурагч ихэвчлэн урам хугарах, бэрхшээлийг даван туулахаас зайлсхийж, төслийн зорилгодоо өөрийгөө бүрэн дайчилдаггүй.</p>	<p>Тухайн сурагч зарим нөхцөл байдалд тууштай байж чаддаг ч тогтвортой ажиллаж чаддаггүй. Төсөлтэй холбоотой илүү төвөгтэй бэрхшээлтэй тулгарах үед өөрсдийгөө сорихыг хичээдэггүй.</p>	<p>Төсөлд саад бэрхшээл, хүндрэл тулгарах үед тэд бэрхшээлийг даван туулж, төслийн зорилгодоо тууштай байх замаар тэсвэр тэвчээрээ харуулдаг. Тэдний шийдэмгий байдал нь төслийн үр дүнд эергээр нөлөөлдөг.</p>	<p>Төслийн явцад хүндрэл бэрхшээлтэй тулгарах үед тэд тууштай шийдэмгий байдаг. Тэд бэрхшээлийг даван туулж, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицож, зорилгодоо анхаарлаа төвлөрүүлдэг.</p>
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				
<b>ЭНТРЕПЕНЕР СЭТГЭЛГЭЭ</b>					
1.	<b>Сониуч байдал</b>	<p>Тухайн сурагч шинэ боломжуудыг идэвхтэй хайдаггүй ба төслийн хүрээнд уламжлалт арга барилдаа найддаг тул шинэлэг санаа гаргах нь ховор байдаг.</p>	<p>Тухайн сурагч зарим нөхцөл байдалд сониуч зан гаргадаг хэдий ч нарийн төвөгтэй нөхцөлд шинэ зүйлийг судалж, турших нь ховор байдаг.</p>	<p>Тухайн сурагч төслийн ажилд нь мэдээлэл өгөх мэдээлэл, ойлголтыг идэвхтэй эрэлхийлдэг. Тэд чухал асуулт асууж, шинээр гарч ирж буй чиг хандлагыг судалж, асуудлыг</p>	<p>Тухайн сурагч одоо байгаа стандарт, хэм хэмжээ зэргийг идэвхтэй эргэлзэж, төслийн сорилтод шинэлэг хандлагыг эрэлхийлдэг. Тэд судалгааг эхлүүлж, зах зээлийн шинжилгээг хийж,</p>

				шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, төслийн шинэлэг шийдэлд хувь нэмрээ оруулдаг.	янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл хайдаг ба үүнийхээ үр дүнд төслийн үр дүнг сайжруулж чаддаг.
2.	<b>Санаачлага гаргах</b>	Тухайн сурагч боломжуудыг идэвхтэй хайх эсвэл манлайллыг үүрэг гүйцэтгэхээс зайлсхийдэг. Тэд төслийн хүрээнд ихэвчлэн бусдад найддаг ба энэ байдал нь төслийн ахиц дэвшлийг хязгаарладаг.	Тухайн сурагч зарим нөхцөл байдалд санаачлагатай байдаг ч тууштай арга хэмжээ авах эсвэл манлайллын үүрэг гүйцэтгэхээс зайлсхийдэг.	Тухайн сурагч манлайллын үүрэг гүйцэтгэж, төслийн үр дүнг дээшлүүлдэг. Төслийн сайжруулалтад идэвхтэй санал оруулж, хамтын ажиллагааг эхлүүлж, төслийн үр дүнд ихээхэн хувь нэмэр гүйцэтгэж, төслийн амжилтыг баталгаажуулах нөөцийг эрэлхийлдэг.	Тухайн сурагч төслийг санаачлах, удирдан чиглүүлэх хүчтэй хүсэл эрмэлзэлтэй болохоо харуулдаг. Зах зээлийн хэрэгцээг тодорхойлж, багийн нөөцийг хуваарилж, төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлдэг ба үүний үр дүнд шинэлэг, амжилттай төслүүд бий болгодог.
3.	<b>Тодорхой бус нөхцөл байдалд ажиллах</b>	Тухайн сурагч тодорхой бус нөхцөл байдал болон тооцоолоогүй эрсдлээс зайлсхийдэг. Тэд тодорхой бус нөхцөлд шинийг санаачлах нь ховор ба тодорхой болсон эсвэл урьдчилан таамаглах боломжтой ажлыг илүүд үздэг.	Тухайн сурагч тодорхой бус байдлыг зарим тохиолдолд даван туулж чаддаг ч эрсдлийг тууштай тооцоолох эсвэл нарийн төвөгтэй, тодорхойгүй нөхцөл байдалд үр дүнтэй дасан зохицох чадвар сул.	Тухайн сурагч тодорхой бус байдлыг эерэгээр хүлээн авдаг ба сорилтыг шийдвэрлэхийн тулд туршилт, эрсдэл тооцоолоход идэвхтэй оролцдог. Тэд бусдын санал хүсэлт дээр үндэслэн төслийн төлөвлөгөөг өөрчилж, гэнэтийн боломжуудыг ашиглаж, эрсдлийг үр дүнтэй удирдаж чаддаг.	Тухайн сурагч тодорхой бус, төвөгтэй нөхцөл байдалд амжилттай шинэлэг шийдлүүдийг дэвшүүлж чаддаг. Тэд төсөл санаачилж, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хурдан дасан зохицож, тодорхой бус байдлыг бүтээлч байдлаар шийдвэрлэж чаддаг.
	<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ:</b>				
	<b>Тайлбар:</b>				



## СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтад орон нутгийн 14-25 насны хүүхэд, залуучууд оролцох учраас нас, сонирхол, танин мэдэхүйн онцлог, сургалтын хэрэгцээнээс шалтгаалан **3** бүлэгт ангилна. Үүнд:

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ЕБС-ИЙН 8-12 ДУГААР АНГИЙН СУРАГЧИД**

**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН СУРГУУЛИАС ГАДУУРХ 14-18 НАСНЫ ХҮҮХДҮҮД**

**БҮЛЭГ 3. 19-25 НАСНЫ ЗАЛУУЧУУД**

Сургалтын суралцагчдын зорилтот мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхэд арга зүй, үнэлгээ хангалтгүй бөгөөд сургалтын зохион байгуулалтаар дамжуулан тэдний харилцааны, сэтгэл хөдлөлийн, цагийн менежментийн болон ажлын байрны талаарх ойлголт мэдлэг чадвар, өсөн дэвших сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой юм.

Энэхүү сургалт нь ЕБС болон насан туршийн суралцахуйн төвийг түшиглэх тул аль ч бүлгийн хувьд дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

### 1. Сургууль/Насан туршийн суралцахуйн төвийн түвшинд:

Сургуулийн эсвэл төвийн удирдлага, менежерүүд энтерпренершипд суурилсан сургалтыг зохион байгуулахдаа:

- (1) Сургалтын орчноор хангах, тодруулбал анги танхим болон суралцагчдын баг танхимын сургалтаас гадуур хамтран ажиллах анги танхим, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах
- (2) Багшийн цагийг зохицуулах
- (3) Танхимын бус үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагатай харилцах, зөвшилцөх,
- (4) Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

### 2. Сургалтын бүлэг/Ангийн түвшинд:

Сургалтыг багш нар удирдан зохион байгуулах ба дараах тодорхой чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулах, суралцагчдын танхимын бус үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх, туслах
- Суралцагчдын төсөлт ажлын гүйцэтгэл, мэдлэг, чадвар, сэтгэлгээний ахицыг үнэлэх, дүгнэх, түүний дагуу суралцагчдыг чиглүүлэх
- Суралцагчдын төсөлт ажлын бүтээлийн сан үүсгэх, түүнийг сургуулийн болон төвийн түвшинд танилцуулга хийх, үзэсгэлэн гаргах



- Суралцагчдын багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, багийн ажил, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөн туслах, 7 хоног бүрийн тайланд үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөмж хүргүүлэх
- Сургалтын бусад оролцогч талуудтай хамтран сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад хамтран ажиллах, зөвлөлдөх, суралцагчдыг хамтран чиглүүлэх, хөгжүүлэх

Сургалт **тэгш** тооны суралцагчтай байх ба нэг багт 4 суралцагч байхаар багаар зохион байгуулна. Багууд **МИНИ-ЭНТЕРПРАЙЗ** компани хэлбэрийн менежменттэй байх ба багийн суралцагчдад дараах **“албан тушаал”**-ыг хариуцуулна. Үүнд:

- БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖЕР
- БАГИЙН ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР
- БАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР
- БАГИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

Багийн **“албан тушаалтан”**-ууд тус бүрдээ дараах ажил үүрэгтэй байх ба эдгээр нь ямар **МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭГ** хөгжүүлэхийг дараах хүснэгтэд үзүүлээ. Үүнд:

АЛБАН ТУШААЛ	АЖИЛ ҮҮРЭГ	МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ
<b>БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖЕР</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны менежерийн 14 хоногийн ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> <li>• Сургалтын явцад өгсөн даалгаврыг багийн гишүүдэд хуваарилах, багийн ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих</li> <li>• Багийн үйл ажиллагааг 14 хоног бүрээр багийн гишүүдтэй хамтран төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлийн хоцрогдол гарч байгаа эсэхийг хянаж байх</li> <li>• Багийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр багтайгаа хамтран тайлан бичих</li> <li>• Тайланд өгсөн багшийн үнэлгээ дүгнэлтийг багийн гишүүддээ танилцуулж дараагийн 14 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>	<p>Өөрийн хүчинд итгэх</p> <p>Цагийн менежмент</p> <p>Идэвхтэй сонсох, асуулт асуух, санаагаа тайлбарлах, бусдын санааг ойлгох</p>





АЛБАН ТУШААЛ	АЖИЛ ҮҮРЭГ	МЭДЛЭГ, ЧАДВАР, СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ
<b>БАГИЙН ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцааны менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах</li> <li>• Багийн гишүүдтэй холбоотой бүх уулзалтын албан бичгийг төлөвлөх, холбогдох хүмүүст хүргэх</li> <li>• Багийн гишүүдийн өмнөөс холбогдох хүмүүстэй (бизнес эрхлэгчид, ажил олгогчид гэх мэт) хийх уулзалтын өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг үйл ажиллагааны менежерт мэдэгдэх</li> <li>• Бусад багуудтай хийх уулзалтын өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг үйл ажиллагааны менежерт мэдэгдэх</li> <li>• Төсөлт ажлыг гүйцэтгэх явцад орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хийх уулзалтын албан бичгийг хүргэж, уулзалт хийх өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг үйл ажиллагааны менежерт мэдэгдэх</li> <li>• Бусад багийн харилцааны менежертэй хамтран ажиллах</li> <li>• Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>	<p>Үгээр болон бичгээр санал бодлоо илэрхийлэх</p> <p>Нэгдсэн зорилгоо хамтдаа хүлээх</p>
<b>БАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах</li> <li>• Багийн гишүүдийн ирцийг бүртгэх, сургалтад оролцуулах</li> <li>• Багийн гишүүдийн мэдээллийн сан үүсгэх, тогтмол холбоо барьдаг байх</li> <li>• Багийн гишүүд төсөлт ажлыг гүйцэтгэх явцад уулзах шаардлагатай хүмүүсийн жагсаалт гаргаж харилцааны менежерт өгөх</li> <li>• Багийн гишүүн бүрийн сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, туслах</li> <li>• Бусад багийн хүний нөөцийн менежертэй хамтран ажиллах</li> <li>• Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>	<p>Төлөвлөх болон зохион байгуулах</p> <p>Алдаанаасаа суралцах</p>



**БАГИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР**

- Материаллаг нөөцийн менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах
- Шаардлагатай санхүүгийн болон ном, гарын авлага, цаас бусад хэрэгслийг бэлэн болгох
- Багаараа ажиллах, тэр дундаа төсөлт ажлыг гүйцэтгэх явцад шаардлагатай анги танхим, ширээ сандал, бичгийн хэрэгслийг бэлтгэх
- Төсөлт ажлыг гүйцэтгэх явцад шаардлагатай материал, хэрэгслийг бэлэн болгох (хэвлэх, олшруулах, хуулбарлах гэх мэт)
- Зайлшгүй шаардлагатай тохиолдолд санхүүгийн нөөцийн хэрэгцээг гаргаж холбогдох хүмүүст танилцуулах
- Багийн гишүүд сургалтын орчинд цэвэр нямбай, ямар нэг сөрөг нөлөөгүй ажиллахад хяналт тавих
- Бусад багийн материаллаг нөөцийн менежертэй хамтран ажиллах
- Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах
- Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах

Санаачилгатай байх

Тодорхойгүй нөхцөл байдлыг урьдчилан төлөвлөх, эргэцүүлэх

Багш нар дээрх ажил үүргийг гүйцэтгүүлэх тухай **“гэрээ”** хийж суралцагчдаар гарын үсэг зуруулж болно. Энэ нь суралцагчдад ажил хөдөлмөрийн нөхцөлтэй танилцах боломж олгоно.

Багийн менежерүүдийг ажил үүргээ тасралтгүй сайн хийхэд хүчин чармайлт гаргахад чиглүүлэх зорилгоор сургалт бүрийн эхэнд багш багуудаас тэдний менежерүүд өөр өөрийн ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаа, ямар бэрхшээл тулгарсан, хэрхэн шийдэж байгааг тогтмол асууна. Тухайлбал багийн суралцагч тухайн өдрийн сургалтад ирээгүй бол хүний нөөцийн менежерээс, анги танхим болон багт шаардлагатай хэрэглэгдэхүүн материал дутуу байвал материаллаг нөөцийн менежерээс, даалгавар гүйцэтгээгүй байвал үйл ажиллагааны менежерээс, суралцагчид багштай уулзах цагаа мэдээгүй эсвэл цагаа товлоогүй бол харилцааны менежерээс асуух, учир шалтгааныг тодруулах гэх мэт.

Сургалтын явцад багш багийн гишүүд өөр өөрийн ажил үүргийн дагуу хэрхэн ажиллаж байгааг ажиглаж харилцах, мөн шаардлагатай зөвлөмж, чиглүүлэг, дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй. Багш нар төсөлт ажлын хуваарилалт суралцагчдын “албан тушаал”-ын чиг үүрэгтэй нийцтэй байхад анхаарч, багийнхнаас хуваарилалтаа хэрхэн хийж буй талаар асуулт асуух, зөвлөгөө өгөх, суралцагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр багуудад санаа өгч болно.

### 3. Багийн түвшинд:

Багийн гишүүд бүр сургалтын үйл ажиллагаанаас гадна оноосон ажил үүрэгтэй байх тул багш уг үүргийн дагуу суралцагчидтай харилцана. Мөн ижил “албан тушаал” бүхий суралцагчдад хамтад нь зөвлөгөө өгөх, дэмжих, санал хэлэхэд анхаараарай.

Багийг илүү үр дүнтэй ажиллуулахын тулд дараах техникийг ашиглахыг санал болгож байна. Үүнд:

1.

**Багийн гишүүдийн үүрэг, ачаалал харилцан адилгүй байх нь суралцагчид бие биеэ харилцан ойлголцож ажиллахад сөргөөр нөлөөлдөг.** Иймээс багийн гэрээ, ажлын хуваарилалтаа гишүүд ярилцаж төлөвлөхөөр чиглүүлээрэй. Төлөвлөгөөндөө ажлын гүйцэтгэл, явцыг шалгах үйл ажиллагааг заавал оруулах нь яагаад хэрэгтэй болох талаар тайлбарлана. Багууд ажиллах явцад багш тэдний үйл ажиллагаанд хяналт тавьж багийн ажил үүргийн хуваарилалтыг шалгаж, ямар нэг асуудал бэрхшээл гарсан бол дор бүр нь арга хэмжээ авахыг хичээгээрэй.

2.

**Суралцагч хоорондын зөрчил багийн ажлыг гүйцэтгэхэд саад болдог.**

Багийн гишүүд бүртэй ярилцаж хамтарч ажиллахад бэрхшээлтэй зүйл эсвэл тэдэнд ямар нэг асуудал үүссэн эсэхийг мэдэх хэрэгтэй. Суралцагчдын дунд зөрчилтэй асуудал гарсан үед хэрхэн шийдэх ур чадварыг хөгжүүлэхэд багш анхаарна. Хэрэв сургалтын хугацаанд уг зөрчил шийдэгдэхгүй бол багийн гишүүдийг сольж болно.

3.

**Суралцагчид ихэвчлэн найзуудтайгаа хамтрахыг хүсдэг.** Сургалтын явцад зан

төлөвийн хувьд ялгаатай, харилцан адилгүй хүмүүстэй хамтран ажиллах нь ямар ач холбогдолтой болохыг үргэлж сануулж байгаарай.

Багууд ажлаа 14 хоногоор төлөвлөж, 14 хоногийн эцэст төлөвлөгөөнийхөө гүйцэтгэлийг дүгнэн ярилцдаг байна.



# СУРГАЛТЫН ЦАГИЙН ХУВААРЬ

**Багш та сургалтын цагийн хуваарийг дараах хүснэгтийг ашиглан хийнэ үү!**

Жишээ болгож 9 сарыг сонгосон бөгөөд Project Planning, Gantt Chart гэх мэт аппликейшныг ашиглан сургалтын цагийн хуваарийг бүтнээр нь хийнэ. Ингэхдээ сургалт 90 цаг буюу хичээлийн 2 дахь жилд 1, 2-р улирлын туршид үргэлжлэх тул багш та өөрийн онцлогт тохирсон хуваарийг хийж болно. Сургалтын хуваарьт 9 сарын 8-ны өдөр 14:00-15:20-д гэж жишээ болгон тэмдэглэсэн байгааг ажиглаж хугацаагаа бүх сургалтын өдөрт ингэж бичнэ үү.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	ДЭД СЭДЭВ	САР	9 САР					
		ӨДӨР	7	8	9	10	...	
<b>МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР</b>								
<b>1</b>	<b>Танхимын</b>	<b>1.1</b> Хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэл	<b>80 мин</b>			14:00 – 15:20		
	<b>Танхимын бус</b>	Бие даасан сорил	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>1.2</b> Хамтрагчийн хувь хүний онцлогийг таних	<b>80 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Бие даасан сорил	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>1.3</b> Цагийн менежмент	<b>80 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Багийн төлөвлөлт	<b>80 мин</b>					
<b>ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА</b>								
<b>2</b>	<b>Танхимын</b>	<b>2.1</b> Энтрепренершип гэж юу вэ?	<b>120 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Бие даасан сорил	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>2.2</b> Энтрепренершипийн арга замууд	<b>80 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Постер гаргах	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>2.3</b> Энтрепренершипийн оролцогч талууд	<b>40 мин</b>					



ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	ДЭД СЭДЭВ	САР	9 САР					
		ӨДӨР	7	8	9	10	...	
<b>3</b>	<b>ЭНТРЕПЕНЕРШИП ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД</b>							
	<b>Танхимын</b>	<b>3.1</b> Тухайн орон нутаг, бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээ тодорхойлох	<b>80 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Хэрэгцээг тандах	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>3.2</b> Ялгаатай хэрэгцээг таних	<b>80 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Кейс цуглуулах	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>3.3</b> Хэрэгцээг хангаж буй туршлагыг илрүүлэх, өөрсдийн санааг хөгжүүлэх	<b>120 мин</b>					
<b>4</b>	<b>ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ</b>							
	<b>Танхимын</b>	<b>4.1</b> Энтерпренешип санаа хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломж, саад бэрхшээл	<b>160 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Энтерпрайз төсөл	<b>80 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>4.2</b> Санхүүгийн нөөц	<b>120 мин</b>					
	<b>Танхимын</b>	<b>4.3</b> Бизнес төлөвлөлт	<b>160 мин</b>					
	<b>Танхимын бус</b>	Төслийн бизнес төлөвлөгөө	<b>80 мин</b>					
<b>Танхимын</b>	<b>4.4</b> Төслийг хэрэгжүүлэхэд тулгарах эрсдэл, түүнийг бууруулах арга зам	<b>80 мин</b>						

ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ							
5	Танхимын	5.1 Энтерпрайз төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт	80 мин				
	Танхимын бус	Төслийн хэрэгжилт, үр дүн	80 мин				
	Танхимын	5.2 Энтерпрайз төслийн явц, үр дүнгийн тандалт	80 мин				
	Танхимын	5.3 Төслийг үнэлж дүгнэх	120 мин				
ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ							
6	Танхимын	6.1 Төслийг сайжруулах	80 мин				
ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ							
7	Танхимын	7.1 Төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх	40 мин				
	Танхимын бус	7.2 Санхүүжилт авах шаардлагын дагуу төсөл боловсруулах, төслийн сонгон шалгаруулалтад оролцох	120 мин				
	Танхимын	7.3 Төслийн санааг хөгжүүлэх боломжийг тодорхойлох, тасралтгүй хөгжүүлэх	40 мин				
НИЙТ	Танхимын		1720 мин / 43 цаг				
	Танхимын бус		920 мин / 23 цаг				



СЭДЭВ 1:

# МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР

Дэд сэдэв 1.1

ХУВЬ ХҮНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛ

Дэд сэдэв 1.2

ХАМТРАГЧИЙН ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГИЙГ ТАНИХ

Дэд сэдэв 1.3

ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ



## СЭДЭВ 1: МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР

### Дэд сэдэв 1.1

## ХУВЬ ХҮНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛ

### *Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Сэтгэл хөдлөл гэж юу болох, энэ нь ямар байдлаар илэрдэг болохыг танин мэдэх
- Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таних
- Өөрийн сонирхол, давуу, сул тал, ажиллах болон сурах арга барил, сонирхол, үнэт зүйлээ тодорхойлох
- Өөрийн хүчинд итгэх итгэл үнэмшлийг бий болгох, түүнийг удирдан жолоодох чадварыг эзэмших

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Сэтгэл хөдлөлийн тухай [Видео 1 - Сэтгэл хөдлөл гэж юу вэ?](#)
- Сэтгэл хөдлөлийн тухай [Видео 2 - Сэтгэл хөдлөлийг нэрлэцгээе](#)
- Стрессийг хянаж, удирдах тухай [Видео 3 - Стресс менежмент](#)
- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут



Юуны өмнө багш суралцагчдад **энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх** сургалтын талаар танилцуулна.

Дараа нь багш суралцагчдыг **бие биетэйгээ танилцахыг хүснэ**. Ингэхдээ тэдэнд илтгэл бэлтгэхэд хугацаа өгнө. Энэ хугацаанд суралцагч өөрийн анги, нэр, энэ сургалтын юу илүү сонирхолтой байгааг болон юу сурах эрмэлзэлтэй байгаагаа танилцуулна. Бүх суралцагчдад бие биеийнх нь эсрэг харуулж нэг шугамд зогсоогоод өөрийгөө танилцуулах 30 секунд өгнө. Нэг эгнээний суралцагчдад эхлээд **30 секунд** өгч хугацаа болмогц зогсоогоод дараагийн **30 секундэд** нөгөө суралцагч танилцуулна. Дараа нь багш тэднээс хэнтэй танилцсан, хэддүгээр анги, сургалтыг сонирхсон шалтгаан болон юу сурах эрмэлзэлтэй байсныг хэлэхийг хүснэ.



Дараа нь багш суралцагчдыг гарын авлагынхаа ур чадварын **Сорил 1**-ийг гүйцэтгэж, багшид өгөхийг хүснэ.


### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### НАДАД АСУУЛТ БАЙНА

Танилцуулгын дараа багш суралцагчдаас **30 секунд**ийн танилцуулга хийхэд ямар сэтгэл хөдлөл мэдэрснийг асууж ярилцана. Үүний дараа өнөөдрийн сургалтаар хувь хүний сэтгэл хөдлөл, өөртөө итгэх итгэлийн талаар судлах тухай хэлээд сэтгэл хөдлөл гэж юу вэ? гэж асууж ярилцана.

Асууж ярилцсаны дараа багш суралцагчдад сэтгэл хөдлөлийн тухай Видеонуудыг үзүүлж харилцан ярилцана.

Дараа нь багш суралцагчдаас гарын авлагын **Дасгал 1**-ийг ажиллахыг хүснэ.



### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ӨӨРИЙН СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ

**Үйл ажиллагаа 1**-ийн дараа багш суралцагчдаас **Дасгал 1** дэх сэтгэл хөдлөлүүдээс нэгийг сонгож **Дасгал 2**-ыг гүйцэтгэхийг хүснэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### УЧИР ШАЛТГААН БА ҮР ДАГАВАР, ИТГЭЛ ҮНЭМШИЛ

**Дасгал 2**-ын үр дүнд гүйцэтгэх хүний дүр зургийг гарын авлагаас шугамын дагуу салгаж аваад суралцагчдыг солилцохыг хүснэ. Суралцагчид тухайн зурагт дүрсэлсэн хүн ямар сэтгэл хөдлөлтэй байгааг тааж, ийм дүр төрхтэй хүнтэй харилцахад ямар санагдахыг ярилцана. Үүний дараа багш суралцагчдаас үргэлжлүүлэн **Дасгал 3** болон **4**-ийг гүйцэтгэхийг хүснэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

### СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ УДИРДАХ

Харин одоо багш зарим суралцагчдаас **Дасгал 4**-д бичсэн бодлоо унших, үүнийг бусад суралцагчид юу гэж бодож байгаа, ямар үр дагавартай, түүнээс зайлсхийхийн тулд юу хийх ёстой тухай ярилцана.

Сэтгэл хөдлөл тэр дундаа бидний сөрөг гэж нэрлэсэн сэтгэл хөдлөл хүний үйл ажиллагаа, харилцаанд сөрөг нөлөөтэй байдаг бөгөөд үүнээс шалтгаалан стресс үүсдэг болохыг тайлбарлана.

Ингээд багш суралцагчдад стрессээ хэрхэн хянаж, удирдах талаар видео үзүүлнэ.

Видеоны дараа багш суралцагчдаас стрессийг **“өдөөгч”** нь юу болох түүнийг хянаж, удирдаж болох эсэхийг асууж ярилцаад **Дасгал 5**-ыг гүйцэтгэхийг хүснэ.

**Дасгал 5**-ыг ажилласны дараа багш видеонд үзүүлсэн стрессийг бууруулах амьсгалын дасгалыг хамтдаа хийцгээж дараагийн үйл ажиллагаанд шилжинэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 5

### БИ ЮУ СОНИРХДОГ БАС ЮУ ХИЙВЭЛ ТОХИРОХ ВЭ?

Багш **Хавсралт 1**-д үзүүлсэн агуулгыг тайлбарлана. Үүний дараа суралцагчдын гарын авлагын **Сорил 2**-ийн **МИНИЙ СОНИРХОЛ** –ийг ажиллахыг хүснэ. Суралцагчид **Сорил 2**-д үзүүлсэн **7 багц** чадвараас хийх дуртай, илүү их сонирхдог эсвэл хамгийн сайн гүйцэтгэдэг чадварын өмнө ✓ тэмдэглэгээ хийх ба багц тус бүрийн төгсгөлд хэдэн ✓ байгааг тоолж, **“бүгд”** нүдэнд бичнэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 6

### ЮУ ХИЙХ ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ, ЗУРАГЛАЛ БОЛОВСРУУЛАХ

Гарын авлагын **Сорил 2** дээр ажилласны дараа багш суралцагчдаас өөрийнх нь бодож байснаас өөр үр дүн гарсан суралцагч байгаа эсэхийг асууж, байгаа бол яагаад өөр гарсан гэж бодож байгаагаа тайлбарлахыг хүснэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 7

### ЭНТРЕПЕНЕРИЙН ШИНЭ САНАА

Сорилын үр дүнд тодорхойлсон сонирхлын чиглэлээр юу хийх бодолтой байгаа талаараа эргэцүүлж тухайн чиглэлээр ямар нэг энтрепренерийн шинэ санаа гаргахыг хүснэ. Тухайн санааг хэрэгжүүлэхийн тулд юу сурах хэрэгтэй талаар хоёр хоёроороо ярилцаж жагсаалт гаргахыг хүснэ. Гарын авлагын **Хүснэгт 1**-ийг бөглөхийг хүснэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 8

### ШИНЭ САНААГАА ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨӨЛӨЛ

**Хүснэгт 1**-ийг бөглөсний дараа хэд хэдэн суралцагчийг урьж энтрепренерийн ямар шинэ санааг сонирхолтойгоо нийцүүлэн хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа, ингэхийн тулд ямар ур чадвар эзэмшиж сурах хэрэгтэй байгаагаа бусдадаа танилцуулахыг хүснэ.

Эхлээд хэн хэн танилцуулах гэдгийг сонголтгүйгээр бүх суралцагчдад танилцуулга хийх гол санаа юу болох, яагаад чухал гэж үзэж байгаагаа товчхон бичиж тэмдэглэх эсвэл схемчлэхийг хүснэ.

Бусад суралцагчид танилцуулсан суралцагчдад юуг яаж сайжруулах эсвэл өөрчилбөл илүү сайн болох талаар зөвлөгөө өгнө.

Сургалтын төгсгөл хэсэгт багш суралцагчдаас гарын авлагынхаа **Дасгал 6**-г гүйцэтгээд сэтгэл хөдлөлийнхөө талаар эргэцүүлэхийг хүснэ.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа


80  
минут

Багш суралцагчдад гарын авлагынхаа **Сорил 3, 4, 5**-ыг гүйцэтгэхийг хүснэ. Суралцагчид эдгээр сорилыг гүйцэтгэх явцдаа танаас зөвлөмж, дэмжлэг авах шаардлага гарах тул та хэдийд суралцагчдад зөвлөгөө өгөх боломжтойгоо мэдэгдэхийг хүсье.

**ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:**

Та дараагийн хичээлээс эхлэн суралцагчдын ур чадварыг сургалтын явцад ажиглаж үнэлэх, түүний дагуу шинэ стратегийг хэрэглэх шаардлагатай болох тул **Ажиглалтын хуудсаа** бэлтгэхийг хүсье.

Мөн ямар стратегийг санал болгосныг энэхүү гарын авлагын **"Сургалтын нэмэлт стратеги"** хэсгээс (хуудас -20) уншиж танилцана уу.



## СЭДЭВ 1: МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР

### Дэд сэдэв 1.2

## ХАМТРАГЧИЙН ХУВЬ ХҮНИЙ ОНЦЛОГИЙГ ТАНИХ

### *Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтерпрайз багийг бүрдүүлэх
- Багийн нийлмэл чадвар, онцлог, үнэт зүйлийг тодорхойлох, сул талыг нөхөх боломжийг эрэлхийлэх
- Багийн өөр өөр гишүүдийн ялгаатай байдлыг таньж мэдэх, түүнд хүндэтгэлтэй хандах, багаар ажиллах дүрмээ тогтоох
- Хувь хүний онцлогт түшиглэн үүргээ хуваарилах

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Багийн ажиллагааны тухай **Видео 4 – Үр дүнтэй багийн ажиллагаа (Team effectiveness)** - суралцагчид танхимаас гадуур YouTube хуудасны видео сангаас нэрийн дагуу хайлт хийж, гэртээ буюу бие даан үзэх
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
МИНУТ

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт талаар асууж ярилцана. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### НАДАД АСУУЛТ БАЙНА?

Багш суралцагчдаас танхимаас гадуур гүйцэтгэсэн дасгалуудтай холбоотой асуулт байгаа эсэхийг тодруулна. Мөн огт нийцэхгүй байгаа санал, зөвлөмжийн талаар асуулт асуухыг хүснэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### МИНИЙ ЭНТРЕПРЕНЕР УР ЧАДВАР

Үүний дараа багш суралцагчдаас гарын авлагын **Сорил 6**-г бөглөхийг сануулна. Сорилоо дууссаны дараа багш суралцагчдаас **Сорил 2-5** болон **6**-гийн үр дүнг **Хүснэгт 2**-д тэмдэглэхийг хэлнэ. Ингэхдээ хүснэгтийн **“код”** хэсэгт өөрийн нэрийн оронд нэг тоо бичнэ үү. Кодоо мартаж болохгүй гэдгийг сануулаарай.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ШИНЭ БАГ ҮҮСГЭХ

Багш сургалтын цаашдын үйл ажиллагаа багаар зохион байгуулагдах учраас суралцагчдыг баг бүрдүүлэх хэрэгтэй болохыг хэлнэ. Энтерпрайз баг байх учраас багийн гишүүдийн **Сорил 2-5** болон **Сорил 6**-гийн ур чадваруудтай аль болох сайн нийцэх хэрэгтэй гэдгийг тайлбарлана. Ингээд сургалтын үйл ажиллагааг **“өртөө”** хэлбэрээр зохион байгуулна. Багш танхимд 5 **“өртөө”**-нүүд байгуулж өртөө бүрд **4** суралцагчийн **Хүснэгт 2**-ийг байршуулна.

Суралцагчид өртөө бүрд зочилж бусад суралцагчдын **Хүснэгт 2**-ын үр дүнтэй танилцаж дараах байдлаар багийн гишүүнээ сонгоно. Үүнд:

1. Өөртэйгөө аль болох ижил төстэй сонирхол, арга барил, үнэт зүйлтэй
2. Өөрийнхөө **Сорил 6**-гийн ур чадвараас дутагдалтай байгаа ур чадварыг ажиглаад, тухайн чадварт өөрөөс тань илүү суралцагчтай нэг баг болох

Дээрх шалгуурын дагуу суралцагчид багаа сонгох үед багш суралцагчдыг ажиглаж шаардлагатай бол нэмэлт дэмжлэг үзүүлнэ.


Өртөөчилсөн үйл ажиллагааг дууссаны дараа багш суралцагчдаас өөр өөрийн сонгосон кодтой суралцагчтай нэг баг болж суухыг зөвлөнө. Энэ үед зарим суралцагчийг нэгээс олон багт сонгосон байх эсвэл сонгоогүй байх тохиолдол гарах учраас багш энэ үед анхаарч зохион байгуулалт хийх шаардлагатай болно.

#### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

### ШИНЭ БАГИЙН БОЛОМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ

Багууд хуваарилагдан суусны дараа багш баг бүр гишүүдийнхээ **Сорил 6**-гийн үр дүнг харьцуулж багийнхаа энтрепренер ур чадварын жагсаалт гаргаж, тухайн багт ямар ур чадвараа хөгжүүлэх шаардлагатайг тодорхойлох даалгавар өгнө.

Ингэхдээ гарын авлагын Хүснэгт 3 дээр ажиллана. Хүснэгт 3 дээр ажиллахдаа багийн гишүүд зөвшилцөж дундын шийдвэрээр хүснэгт 3-г бөглөх тухай тайлбарлаарай.



#### ҮЙЛ АЖИЛЛАГАА 5

### ШИНЭ БАГААР АЖИЛЛАХ

Багш багуудад баяр хүргээд баг бүр **МИНИ-ЭНТЕРПРАЙЗ** компанийн зохион байгуулалтаар ажиллах бөгөөд өөрсдийн компанидаа багийн онцлогтой уялдуулан нэр, лого өгөх даалгавар өгнө. Багийн гишүүд ярилцаж өөрсдийн онцлог, давуу тал, багийн гишүүдийн сонирхол, үнэт зүйлд үндэслэн багтаа өөрийн гэсэн лого, нэр сонгох, өөрийн гэсэн уриатай болно. Лого, нэрийг флипчартны цаасан дээр бичүүлж хананд дэлгэж үзүүлнэ.



#### ҮЙЛ АЖИЛЛАГАА 6

### БАГИЙН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ, ЦААШИД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ

Одоо баг бүр өөр өөрийн гэсэн нэртэй, лого, уриатай болсон. Багш суралцагчдад нэгэнт багууд **мини-энтерпрайз** компанийн зохион байгуулалттай байх тул баг дотроо тодорхой албан тушаалтантай байх талаар танилцуулна.

АЛБАН ТУШААЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖЕР
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР
МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР
ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР

Багш суралцагчдад гарын авлагынхаа **Хүснэгт 4**-ийг уншиж танилцах даалгавар өгнө. Багийн албан тушаалтнууд дараах ажил үүргийг хариуцна. Үүнд:

АЛБАН ТУШААЛ	АЖИЛ ҮҮРЭГ
 <p><b>БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖЕР</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны менежерийн 14 хоногийн ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> <li>• Сургалтын явцад өгсөн даалгаврыг багийн гишүүдэд хуваарилах, багийн ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих</li> <li>• Багийн үйл ажиллагааг 14 хоног бүрээр багийн гишүүдтэй хамтран төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлийн хоцрогдол гарч байгаа эсэхийг хянаж байх</li> <li>• Багийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр багтайгаа хамтран тайлан бичих</li> <li>• Тайланд өгсөн багшийн үнэлгээ дүгнэлтийг багийн гишүүддээ танилцуулж дараагийн 14 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>
 <p><b>БАГИЙН ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцааны менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах</li> <li>• Багийн гишүүдтэй холбоотой бүх уулзалтын албан бичгийг төлөвлөх, холбогдох хүмүүст хүргэх</li> <li>• Багийн гишүүдийн өмнөөс багш нар, зөвлөх, менторуудтай хийх уулзалтын өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг үйл ажиллагааны менежерт мэдэгдэх</li> <li>• Бусад багуудтай хийх уулзалтын өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг харилцааны менежерт мэдэгдэх</li> <li>• Төсөлт ажлыг гүйцэтгэх явцад орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хийх уулзалтын албан бичгийг хүргэж, уулзалт хийх өдөр, цаг, байршлыг товлох, түүнийг үйл ажиллагааны менежерт мэдэгдэх</li> <li>• Бусад багийн харилцааны менежертэй хамтран ажиллах</li> <li>• Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>



 <p><b>БАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах</li> <li>• Багийн гишүүдийн ирцийг бүртгэх, сургалтад оролцуулах</li> <li>• Багийн гишүүдийн мэдээллийн сан үүсгэх, тогтмол холбоо барьдаг байх</li> <li>• Багийн гишүүд төсөлт ажлыг гүйцэтгэх явцад уулзах шаардлагатай хүмүүсийн жагсаалт гаргаж харилцааны менежерт өгөх</li> <li>• Багийн гишүүн бүрийн сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, туслах</li> <li>• Бусад багийн хүний нөөцийн менежертэй хамтран ажиллах</li> <li>• Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>
 <p><b>БАГИЙН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Материаллаг нөөцийн менежерийн 14 хоногийн үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажиллах</li> <li>• Шаардлагатай санхүүгийн болон ном, гарын авлага, цаас бусад хэрэгслийг бэлэн болгох</li> <li>• Багаараа ажиллах, тэр дундаа төсөлт ажлыг гүйцэтгэх явцад шаардлагатай анги танхим, ширээ сандал, бичгийн хэрэгслийг бэлтгэх</li> <li>• Төсөлт ажлыг гүйцэтгэх явцад шаардлагатай материал, хэрэгслийг бэлэн болгох (хэвлэх, олшруулах, хуулбарлах гэх мэт)</li> <li>• Сургалтын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг тогтмол шалгаж, бэлтгэх</li> <li>• Багийн гишүүд сургалтын орчинд цэвэр нямбай, ямар нэг сөрөг нөлөөгүй ажиллахад хяналт тавих</li> <li>• Бусад багийн материаллаг нөөцийн менежертэй хамтран ажиллах</li> <li>• Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног бүр тайлан бичиж, багтаа танилцуулах</li> <li>• Багийн үйл ажиллагааг бусдад танилцуулах</li> </ul>

Багууд ажил үүргийн хуваарьтай танилцсаны дараа дотроо ярилцаж, хэнд ямар албан тушаалыг хариуцуулснаа багшид мэдэгдэнэ.

Багш багуудад **Сорил 2-5** болон **7-ийн** үр дүнгэээргэн харж ашиглахыг санал болгоорой. Мөн дараах зүйлийг заавал сануулна. Үүнд:

- Багийн гишүүд бүгдээрээ саналаа заавал хэлнэ.
- Тодорхой албан тушаалд “томилогдож” байгаа суралцагч тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч байгаа эсэх, багаас ямар дэмжлэг хэрэгтэй болохыг заавал ярилцана.

Үүний дараа багууд менежерүүдээ томилж гарын авлагын **Багийн менежерийн томилгоо, баталгаа** хэсгийг бөглөнө.

Бөглөхдөө хамгийн эхний хэсэгт ямар менежерийн томилгоо хийж буйг нөхөж бичнэ. Харин багийн бусад менежерүүд дээрх менежерт ажил үүргээ гүйцэтгэхэд нь ямар дэмжлэг үзүүлэхээ нөхөж бичээд доод талд нь баталгаажуулж гарын үсэг зурна. Хамгийн сүүлд тухайн менежерээр томилогдож буй суралцагч дээрх томилгоог хүлээн зөвшөөрснөө нотлон гарын үсэг зурах юм.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 7

### БАГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ЭЦЭСЛЭХ

Багш багуудаас албан тушаалаа хэрхэн хуваарилсан арга замаа ярилцаж багийн бүрэлдэхүүн, амлалтыг бусад багуудад танилцуулахыг хүснэ.

Багууд танилцуулга хийхээс өмнө танилцуулах хамгийн гол санаа юу болох, түүнийг яагаад танилцуулах хэрэгтэй, бусдад ямар ойлголт өгөхийг зорьж байгаа талаар **5 минут** орчим ярилцаж бэлтгэхийг сануулна.

Үүний дараа багш багуудад өөр өөрийн гэсэн дотоод дүрмээ зохиохыг зөвлөнө. Дүрэмд дараах зүйлийг заавал тусгахыг санал болгоно.


Үүнд:

- **Багийн гишүүд бие биеийхээ гаргасан саналыг буруу гэж хэлэлгүйгээр заавал яагаад гэж асуудаг байх**
- **Багийн гишүүдийн нийгмийн байдал, гадаад төрх, хувцаслалт, эд хэрэглэлийн талаар бүдүүлэг үг хэрэглэхгүй байх**
- **Хэн нэг нь чадахгүй бол бид яаж туслах вэ? гэж үргэлж асуудаг, тусалдаг байх**
- **Гарын авлагын “багаар ажиллахад анхаарах зүйлүүд” гэсэн бичвэрийг заавал уншиж, ярилцах**



Багууд дүрмээ бэлэн болгосны дараа багш суралцагчдад дүрмээ заавал мөрдөж ажиллах бөгөөд цаашид сургалтын зохион байгуулалт, даалгавраа цаг хугацаанд гүйцэтгэх, анги танхим бэлтгэх, сургалтад гаднаас хүмүүс урьж оролцуулах зэрэг ажлыг багийн менежерүүд бүрэн хариуцаж ажиллахыг хэлнэ.

Сургалтын төгсгөлд багш суралцагчдад танхимын бус сургалтын үйл ажиллагааг танилцуулж, шаардлагатай зөвлөгөө өгнө.

Суралцагчид танхимын бус цагаар, багаар хамтран  YouTube сангаас “Хэрхэн амжилттай баг бүрдүүлэлт хийх вэ?” нэртэй видео хичээл үзнэ.

Багш энэхүү даалгаврыг гүйцэтгэхэд суралцагчдад танхимаас гадуур зөвлөгөө өгнө.



## СЭДЭВ 1: МИНИЙ ЭНТРЕПРЕНЕРШИП УР ЧАДВАР

## Дэд сэдэв 1.3

## ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ

*Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Цагийн менежментийн талаарх ойлголт
- Цагаа зөв, бодитой төлөвлөх, хуваарь гаргах, түүнд тулгарах саад бэрхшээлийг таньж мэдэх
- Ажлын төлөвлөгөө хийх, түүнд хүчин чармайлт гаргах

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана.

Үүнд:

- Багшийн хийсэн **СУРГАЛТЫН ЦАГИЙН ХУВААРЬ**-ийн хуулбар (суралцагч бүрд нэг хувь)
- Компьютер (суралцагч бүрд 1 байх)
- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой асуудлаар багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Энэхүү сургалтад багийн албан тушаалтай ижил төстэй ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас урьж оролцуулах шаардлагатай. Тухайлбал, сургалтын менежер, хүний нөөцийн ажилтан, нярав, захиргаа аж ахуй эрхэлсэн албан тушаалтан гэх мэт.

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй. Үүний дараа багш цаг төлөвлөлтийн ач холбогдлын талаар тайлбарлана. Багшийн гарын авлагын **Хавсралт 2**-ыг үзнэ үү.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### БИ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ЮУ ХИЙХ ВЭ?

Багийн суралцагчид тодорхой “албан тушаал”-тай болсон учраас тэд “Би юуг, яаж хийх вэ?” гэдэг асуулттай нүүр тулж байгаа. Энэ тодорхойгүй нөхцөл байдалд цаашдаа хэрхэн ажиллах чиглэлээ тодорхой болгохын тулд багш суралцагчдыг баг дотроо ярилцаж асуултын хариултыг эрэлхийлэх, ярилцах даалгавар өгнө.

Үүний дараа суралцагчид тухайн өдрийн сургалтад урилгаар оролцож буй ажилтан, албан тушаалтнаас өөр өөрсдийнх нь ажил үүргийн чиглэлээр асуулт асууна. Тухайлбал:

- **Та өдөр тутамдаа юу хийдэг вэ?**
- **Та ажилтнуудаа өдөр тутмын ажилд нь хэрхэн, яаж идэвхтэй оролцуулж болох вэ?**
- **Танд өдөр тутамдаа ямар бэрхшээл тулгардаг вэ?**
- **Хүмүүстэй харилцах харилцаанд ямар үл ойлголцол түгээмэл байдаг вэ?**
- **Танд тулгарсан асуудлыг бүтээлчээр яаж шийдэж байсан бэ?**
- **Та ажлаа яаж төлөвлөдөг вэ?** ГЭХ МЭТ



Асуулт ярилцлагын явцад суралцагчид тэмдэглэл хөтлөх шаардлагатай.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ПРАКТИКТ ТУЛГАРАХ БЭРХШЭЭЛ, ЗӨРЧЛИЙГ БҮТЭЭЛЧЭЭР ШИЙДЭХ

Үүний дараа багш багуудын ижил албан тушаалтай суралцагчдыг нэг баг болгож зохион байгуулаад сургалтын хуваарийг баг бүрд тарааж өгнө. Ижил албан тушаал бүхий суралцагчидтай багууд тухайн өдрөөс хойших **14 хоногт** хийх ажлын жагсаалт гаргахыг хүснэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН САНААГ БОЛОВСРУУЛАХ

Жагсаалт дахь ажлуудыг яаж гүйцэтгэх арга замаа багаараа ярилцаж боловсруулна. Ингэхдээ суралцагчийн гарын авлагын **Хүснэгт 5**-ыг ашиглахыг санал болгоорой.

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД	ХЭРХЭН ГҮЙЦЭТГЭХ
1.	
2.	
3.	
4.	
5.	
6.	

Дээрх хүснэгтийг багийн гишүүн бүр гарын авлага дээрээ хийж дуусаад өөрийн үндсэн багтаа буцаж нэгдэнэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

#### ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН САНААГАА ТӨЛӨВЛӨГӨӨНД БУУЛГАХ

Одоо багууд **14 хоногийн** хугацаанд хийж гүйцэтгэх багийн ажлаа төлөвлөх хэрэгтэй болно. Багийн албан тушаалтан бүр юуг, яаж хийх санаатай болсон мөн сургалт хэзээ, хэдэн цагт хаана зохион байгуулагдах тухай хуваарь, мэдээлэлтэй болсон учраас ажлаа төлөвлөх суурь нөхцөл хангагдсан гэж ойлгож болно.

Багш багуудад суралцагчийн гарын авлага дахь **Хүснэгт 6**-н загварыг ашиглан төлөвлөлт хийхийг хүснэ. Багш төлөвлөлтөд багийн албан тушаалтан бүрийн хийж гүйцэтгэх ажил тусгагдсан байх ёстой гэдгийг сайн анхааруулах хэрэгтэй. Суралцагчид илүү боловсронгуй хүснэгтийг ашиглаж болно. Баг бүрийн төлөвлөгөөг флипчарт цаасан дээр буулгаж бусад багуудад танилцуулахаар бэлтгэнэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 5

## ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ САЙЖРУУЛАХ

Багууд боловсруулсан төлөвлөгөөгөө сайжруулах зорилгоор бусад багуудтай солилцож харилцан санал, зөвлөмжөө төлөвлөгөөн дээр нь бичнэ. Багууд бусад багуудын бичсэн санал, зөвлөмжийн талаар багаараа ярилцаж шаардлагатай гэж үзвэл төлөвлөлтөө сайжруулна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 6

## ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ

Багуудын сайжруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд багийн гишүүн бүрийн бэлтгэл, ойлголт чухал. Иймээс багш багуудаас төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ямар бэлтгэл хангах, юу сурах хэрэгтэй талаар ярилцаж, дүгнэлт гаргахыг хүснэ.

Үүний дараа **1-2** төлөвлөлтийг бусдад танилцуулж энэ төлөвлөлт хийхэд ямар бэрхшээл тулгарсныг хэлэлцэнэ.

Багш багийн гишүүдийг танилцуулгын хамгийн гол санаа юу болох, түүнийг яагаад танилцуулах хэрэгтэй, бусдад ямар ойлголт өгөхийг зорьж байгаа талаар **5 минут** орчим ярилцаж, бэлтгэхийг анхааруулна.

Сургалтын төгсгөлд багш суралцагчдаас гарын авлагын **Сэдэв 1**-ийн үнэлгээг бие даан гүйцэтгэж, дууссаны дараа багшид хураалгахыг сануулна.

Багш суралцагчдад танхимын бус үйл ажиллагааны талаар танилцуулж шаардлагатай зөвлөгөө өгнө.



Багууд эцэслэн боловсруулсан төлөвлөгөөгөө **MS Excel** программ эсвэл **Gantt Chart** ашиглан бэлэн болгох даалгавар гүйцэтгэнэ.

Танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой багийн менежер бүр өөр өөрийн ажил үүргийн дагуу ажиллах хэрэгтэй болно.

**Үйл ажиллагааны менежер** гишүүдийн ажлыг хуваарилах, **хүний нөөцийн менежер** суралцагчдын оролцоог хангах, **материаллаг нөөцийн менежер** анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, **харилцааны менежер** хүмүүстэй холбогдох болон багштай уулзах уулзалтыг товлох хэрэгтэй болно.



Танхимын бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

**80**  
МИНУТ

## СЭДЭВ 1-ИЙН ҮНЭЛГЭЭ

Сэдэв 1-ийн үйл ажиллагаагаар эзэмшсэн суралцагчдын мэдлэг, чадвар, сэтгэлгээг дараах шалгуурын дагуу өөрсдөөр нь үнэлүүлээд үнэлгээний хуудсыг хурааж аваарай.

ШАЛГУУР	ТҮВШИН					
	1-Эзэмшээгүй	2	3	4	5	6-Маш сайн
1. Өөрийн ур чадвар, сонирхол, үнэт зүйлээ тодорхойлох						
2. Сул талаа таньж мэдэх						
3. Давуу талаа таньж мэдэх						
4. Бусдын ур чадварт дүгнэлт хийх						
5. Бусдад өөрийгөө ойлгомжтой илэрхийлэх						
6. Бусадтай санал нийлэхгүй үед өөрийгөө тайван илэрхийлэх						
7. Ажлыг цаг хугацаанд нь дуусгах						
8. Үйл ажиллагаагаа төлөвлөх						
9. Төлөвлөсөн зүйл яагаад хугацаандаа хэрэгжиж чадаагүйн шалтгааныг илрүүлэх						
10. Бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх						
11. Бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах						
12. Асуултыг анхааралтай сонсож оновчтой хариулт өгөх						

Суралцагчийн өөрийн болон үе тэнгийнхний үнэлгээний хуудсыг суралцагч тус бүрээр сан үүсгэж хадгална.  (Авсан нийт оноо) \* 1.4 =  %





СЭДЭВ 2:

# ЭНТРЕПРЕНЕР- ШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Дэд сэдэв 2.1

ЭНТРЕПРЕНЕРШИП ГЭЖ ЮУ ВЭ?

Дэд сэдэв 2.2

ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН АРГА ЗАМУУД

Дэд сэдэв 2.3

ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

## СЭДЭВ 2: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

## Дэд сэдэв 2.1

## ЭНТРЕПРЕНЕРШИП ГЭЖ ЮУ ВЭ?

*Зориго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтрепренершипийн суурь мэдлэг
- Бизнесийн болон нийгмийн энтрепренершипийн талаарх ойлголт
- Энтрепренершипийн үйл ажиллагааг таних, бүрэлдэхүүнийг тодорхойлох
- Бизнесийн болон нийгмийн энтрепренерийн ур чадвар, онцлог ялгааг тодорхойлох

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана.

Үүнд:

- Энтрепренершип ба энтрепренерийн тухай [Илтгэл 1 - Энтрепренершип ба энтрепренер](#)
- Энтрепренерийн тухай [Видео 5 – Чагнаадоржийн амжилтын түүх](#)
- Нийгмийн энтрепренерийн тухай [Видео 6 – Нийгмийн энтрепренершип гэж юу вэ?](#)
- Нийгмийн энтрепренершипийн тухай [Видео 7 – Ид шидийн орон](#)
- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын рубрик үнэлгээний хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Мөн сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямархуу өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуултыг асууж ярилцахыг хүснэ. Бие биеэ анхааралтай сонсохыг санал болгоорой.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### БИ ХАРИУЛЪЯ

Багш суралцагчдад бизнесийн болон нийгмийн энтрепренершипийн 2 видеог үзүүлнэ. Үүний дараа суралцагчдаас дараах асуултыг асууж хариулт авна. Үүнд:

1. Энэ 2 видеонд үзүүлсэн жишээнүүд хоёулаа энтрепренершип мөн үү? Яагаад?
2. Энэ 2 жишээний ижил төстэй тал нь юу вэ?
3. Энэ 2 жишээний ялгаатай талууд нь юу вэ?
4. Энэ 2 жишээнд үзүүлсэн энтрепренерүүд хэн байв?

Үүний дараа багш суралцагчдын гарын авлагын **Хүснэгт 7**-г багаараа хамтран гүйцэтгэхийг зөвлөнө. Энэ нь суралцагчдад бизнесийн болон нийгмийн энтрепренерийн ялгааг олж харахад тусална. Та илүү дэлгэрүүлж мэдэхийг хүсвэл багшийн гарын авлагын **Хавсралт 3**-ыг судална уу?

Багш 1 багийг сонгож хүснэгтээ бусдад танилцуулахыг хүснэ. Ингэхдээ багууд танилцуулга хийхээс өмнө ярилцаж танилцуулах хамгийн гол санаа юу болох, түүнийг яагаад танилцуулах хэрэгтэй, бусдад ямар ойлголт өгөхийг зорьж байгаа талаар 5 минут орчим бэлтгэхийг зөвлөнө. Үүний дараа танилцуулна.



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

### ЭНТРЕПРЕНЕРҮҮД ХЭН БАЙВ?

Танилцуулгын дараа багш суралцагчдад гарын авлагынхаа **Бүх энтрепренерүүд адилхан уу** сэдвийг унших даалгавар өгнө.



Сэдвийг уншсаны дараа багш суралцагчдаас Видеоонд үзүүлсэн 2 энтрепренерүүд нь хэн болох, тэдэнд ямар ур чадвар байж болох талаар баг дотроо ярилцаж гарын авлагын дараах **Хүснэгт 8**-ыг багаараа хамтран бөглөхийг хүснэ.

Багууд дээрх хүснэгтийг бусад багуудад танилцуулах ба танилцуулгын дараа багуудад **“нийтлэг байгаа ур чадвар”, “ялгаатай ур чадвар”**-ууд юу болохыг ярилцаж **ЭНТРЕПРЕНЕРИЙН УР ЧАДВАР** –ын нэгдсэн жагсаалт гаргана.

Сургалтыг дараагийн хичээлд үргэлжлүүлнэ.



### Сэтгэл хөдлөлөө эргэцүүлэх, удирдах дасгал

1. Өнөөдрийн сургалтын явцад та ямар сэтгэл хөдлөлүүдтэй байсан бэ?
2. Тухайн сэтгэл хөдлөлийн шалтгаан юу байсан бэ?
3. Та тухайн сэтгэл хөдлөлөө яаж илэрхийлж байсан бэ?
4. Чиний сэтгэл хөдлөлөө илэрхийлж буй байдал бусад хүмүүст ямар нөлөө үзүүлэв?
5. Чи сэтгэл хөдлөлөө яаж хянав? Өөрөөр хэлбэл өөрийгөө яаж тайвшруулав?
6. Тухайн сэтгэл хөдлөлийг цаашид яаж хянах боломжтой гэж бодож байна вэ?
7. Өнөөдрийн сургалтаас чамд хамгийн их таалагдсан хэсэг юу байсан бэ?
8. Илүү их сурч мэдэхийг хүсэж байгаа хэсэг чинь аль байсан бэ?

Хичээлийн төгсгөлд багш суралцагчдаас дараах дасгалыг гүйцэтгэхийг хүснэ. Мөн танхимын бус сургалтын үйл ажиллагааг тайлбарлаж, шаардлагатай зөвлөгөө өгнө.

Танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой багийн менежер бүр өөр өөрийн ажил үүргийн дагуу ажиллах хэрэгтэй болно.

Үйл ажиллагааны менежер гишүүдийн ажлыг хуваарилах, хүний нөөцийн менежер суралцагчдын оролцоог хангах, материаллаг нөөцийн менежер анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, харилцааны менежер хүмүүстэй холбоо тогтоох болон багштай багштай уулзах уулзалтыг товлох хэрэгтэй болно. Багш багуудад төлөвлөлт хийхэд нь тусална.



Багш багуудад гарын авлагын **Энтрепренешип гэж юу вэ?** сэдвийг уншиж зурагт ном бэлтгэх даалгавар өгнө. Зурагт ном дараах шаардлагыг хангасан байх хэрэгтэй.

Үүнд:

1.

14-25 насны  
хүүхэд,  
залуучуудад  
ойлгомжтой

2.

Хүн бүрийн  
анхаарал татахуйц  
дизайнтай байх

3.

Компьютер дээр  
хийгдсэн байх

Багууд ангид хийсэн төлөвлөлтийн дагуу ажиллана.



ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:

Танхимын бус үйл ажиллагаагаар бэлэн болгосон зурагт номыг дараагийн хичээлд танилцуулах тул бэлэн болгосон байх хэрэгтэй. Үүнийг багийн **материаллаг нөөцийн болон үйл ажиллагааны менежерүүд** хариуцна.

Дараагийн хичээлд орон нутгийн аж ахуй эрхлэгч, иргэдийн төлөөллийг оролцуулах шаардлагатай. Ийм учраас багийн **харилцааны менежерүүдэд** хүмүүстэй холбоо тогтоож дараагийн хичээлд урьж оролцуулах даалгавар өгнө.

## СЭДЭВ 2: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

## Дэд сэдэв 2.2

ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН  
АРГА ЗАМУУД*Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтрепренершипийг хэрэгжүүлэх арга замууд
- Энтрепренершипийн шинэ санаа боловсруулах, боломжийг тодорхойлох
- Орон нутаг дахь бизнесийн болон нийгмийн энтрепренершипийн жишээг тодорхойлох

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын рубрик үнэлгээний хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Сургалтад орон нутгийн аж ахуй эрхлэгч, иргэдийн төлөөлөл, зөвлөх болон менторуудыг оролцуулах ба тэднийг **Үйл ажиллагаа 4**-ийг эхлүүлэхээс өмнө ангид урьж авчирсан байна.

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт талаар асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

Багш багуудыг бэлэн болгосон зурагт номоо анги танхимд байршуулахыг сануулна. Сургалтын дараа суралцагчид тухайн зурагт номтой танилцаж хамгийн сайн номыг шалгаруулна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### ЭНТРЕПЕНЕРШИПИЙН ШИНЭ САНАА

Багш суралцагчдаас тухайн орон нутагт бизнесийн болон нийгмийн энтрепренершипийн 2 видео дахь жишээтэй төстэй ямар энтрепренершип байж болох талаар багаараа ярилцаж тус бүр нэг нэг жишээ гаргахыг хүснэ. Ингэхдээ гарын авлагынхаа **Хүснэгт 9**-ийг ашиглахыг хүснэ. Шаардлагатай бол багш видеонуудыг дахин үзүүлж болно.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

### ШИНЭ САНААНУУД МАНАЙ ОРОН НУТАГТ ЯАЖ ХЭРЭГЖИХ ВЭ?

Үүний дараа багш багуудаас нийгмийн болон бизнесийн энтрепренершипийн нэг, нэг шинэ санаа гаргаж түүнийг **Оюуны зураглал** ашиглан дэлгэрэнгүй дүрслэхийг хүснэ. Оюуны зураглалын схемийг гарын авлагаасаа харахыг хүснэ. Оюуны зураглалыг дараах алхмуудаар гүйцэтгэнэ.

Үүнд:



1. Энтерпренершипийн санаагаа бичих -Үүнийг “1” дугаартай дүрсэд бичих Жишээ нь “Дотуур байрны бага ангийн сурагчдын хичээлд туслах”, эсвэл “Сургуулийнхаа суралцагчдад зориулсан хувилах, хэвлэх үйлчилгээ эрхлэх” гэх мэт

2. Танай сургуульд ямар ач холбогдолтойг бичих -“2” дугаартай дүрсэд бичих

3. Хэнд зориулсан үйл ажиллагаа болохыг бичих -“3” дугаартай дүрсэд бичих

4. Орон нутаг болон иргэдийн ямар асуудлыг шийдэх -“4” дугаартай дүрсэд бичих

5. Ямар нөөц ашиглах -“5” дугаартай дүрсэд бичих

гэх мэт үргэлжлүүлэн бичнэ. Энд суралцагчид буруу зөв гэлтгүй орж ирсэн бүх санаагаа бичнэ.

Зураглалаа бусад багуудад танилцуулж, тэдний санал, зөвлөмжийг сонсож, асуултад хариулна. Ингэхдээ багуудыг танилцуулга хийхээс өмнө түүний хамгийн гол санаа юу болох, яагаад танилцуулах хэрэгтэй, бусдад ямар ойлголт өгөхийг зорьж байгаа талаар **5 минут** орчим ярилцахыг хүснэ. Үүний дараа танилцуулна. Урилгаар оролцож буй хүмүүс суралцагчдын саналд өөр өөрийн санал, зөвлөмжөө заавал өгнө.

Суралцагчдаас танилцуулсан санаануудаас хамгийн шилдэг 2 санаа юу байсныг асууж шалгаруулна. Шалгаруулахдаа ямар шалгуур ашигласныг ярилцаарай.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН САЙЖРУУЛАХ

Багш суралцагчдыг багууд болон аж ахуй эрхлэгч, иргэдийн төлөөлөл, зөвлөх, менторуудын санал, зөвлөмжид үндэслэн энтерпренершипийн 2 санаагаа сайжруулах даалгавар өгнө. Энэ даалгаврыг анги хамт олноороо гүйцэтгэнэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

#### ШИНЭ САНААНЫ ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ

Багш, суралцагчдаас сайжруулсан санааныхаа талаар эргэцүүлж гарын авлагынхаа **Дасгал 8**-ын асуултыг бие биеэсээ асууж, хариулт авна.

Дараа нь асуултаас 3 жишээг сонгож ёс зүйтэй шийдвэр гаргасантай холбоотой богино хугацааны алдагдал буюу сул тал, урт хугацааны ашиг буюу давуу талыг хүснэгтэд бичиж бусдад танилцуулна.

Багууд танилцуулга хийхээс өмнө танилцуулга хийх хамгийн гол санаа юу болох, түүнийг яагаад танилцуулах хэрэгтэй, бусдад ямар ойлголт өгөхийг зорьж байгаа талаар **5 минут** орчим ярилцаж бэлтгэхийг хүснэ. Үүний дараа танилцуулна.



Танилцуулгын дараа багш суралцагчдаас **Дасгал 9-ийг** бие даан гүйцэтгэхийг хүснэ.

Хичээлийн төгсгөлд багш суралцагчдад танхимын бус үйл ажиллагааны талаар танилцуулж шаардлагатай бол зөвлөгөө өгнө. Танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой багийн менежер бүр өөр өөрийн ажил үүргийн дагуу ажиллах хэрэгтэй болно. Үйл ажиллагааны менежер

гишүүдийн ажлыг хуваарилах, хүний нөөцийн менежер суралцагчдын оролцоог хангах, материаллаг нөөцийн менежер анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, харилцааны менежер бусад хүмүүстэй холбогдох болон багштай уулзах уулзалтыг товлох хэрэгтэй болно. Багш багуудад төлөвлөлт хийхэд нь тусална.


Багууд хүүхэд, залуучуудад зориулан энтрепренершип гэж юу болох, ямар хүнийг энтрепренер гэдэг, энтрепренерийн жишээнүүд юу болох, хүмүүсийн сэтгэл хөдлөл энтрепренерийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлдэг талаар постер бэлтгэнэ.

Багууд ангид хийсэн төлөвлөлтийн дагуу ажиллана.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

**80**  
минут



## СЭДЭВ 2: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

## Дэд сэдэв 2.3

ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН  
ОРОЛЦОГЧ ТАЛУУД*Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтрепренершипд оролцогч талууд
- Тэдний оролцоо, түүний уялдаа холбоо, хамтын ажиллагааны чиглэлийн талаарх ойлголттой болж
- Тодорхой чиглэлийн энтерпрайзын оролцогч талууд
- Тэдний хоорондын харилцааг оновчтой тодорхойлох

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- "Монголд үйлдвэрлэв" хэвлэмэл материалууд
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Багш сургалт эхлэхээс өмнө аж ахуй эрхлэгчийн төлөөлөл эсвэл аж ахуй эрхэлдэг зөвлөх, менторуудыг урьж сургалтад оролцуулна. Эдгээр хүмүүс сургалтын эхэнд суралцагчдын асуултад хариулж зөвлөгөө өгөх болно.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### НАДАД АСУУЛТ БАЙНА?

Багш өнөөдрийн сургалт энтрепренершипийн оролцогч талууд хэн байх тухай сурч мэднэ гэдгийг хэлээд суралцагчдыг сургалтад урилгаар оролцож буй төлөөлөл, зөвлөх менторуудаас тэдний бизнесийн үйл ажиллагааны оролцогч талууд хэн болох, ямар чиглэлээр хамтран ажилладаг, ямар бэрхшээл байдаг гэх мэт асуулт асуухыг хүснэ. Тэдний өгсөн хариулт суралцагчдад эргэлзээтэй санагдвал илүү тодруулах асуулт асууж болно мөн санал нийлэхгүй зүйл байвал түүнийгээ илэрхийлж болно гэдгийг сануулна.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ЯАГААД ОРОЛЦОГЧ ТАЛУУД ЧУХАЛ ВЭ?

Суралцагч багаараа ярилцаж энтрепренершипд яагаад оролцогч талууд чухал болохыг ярилцаад нэг энтрепренершипийн тодорхой үйл ажиллагааг сонгон гарын авлагын **Дасгал 10**-ыг ажиллана.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Суралцагчид бизнесийн болон нийгмийн энтрепренершипийн видеонд үзүүлсэн жишээний оролцогч талууд хэн байхыг багаараа ярилцахыг зөвлөнө.

Багш суралцагчдаас **Дэд сэдэв 2.2**-д боловсруулсан энтрепренершипийн оролцогч талууд хэн байх, тэдний хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж болохыг багаараа ярилцаж нэг нэг томоохон арга хэмжээний төсөл боловсруулахыг хүснэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

#### ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ЧИГЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ

Багууд **Үйл ажиллагаа 3**-ын үр дүнг бусад багуудад танилцуулна. Энэ үедээ дүрд тоглох аргыг ашиглана. Багийн илтгэгч нь өөрийгөө энтерпрайз багийн менежер гэж бодоод бусад багийн суралцагчдад бизнесийн төслөө танилцуулж байна гэж төсөөлнө.

Багууд танилцуулсны дараа багш дараах асуултыг асууна. Үүнд:

1. Аль багийн илтгэгч хамгийн сайн менежер байсан бэ? Яагаад, ямар шалгуураар хамгийн сайн гэж үнэлсэн бэ?

2. Бусад илтгэгч-менежерүүд ямар ур чадвараа сайжруулах шаардлагатай вэ?

Багш сургалтын төгсгөлд **Сэдэв 2**-ын үнэлгээг ашиглан өөрсдийгөө үнэлэхийг хүснэ.



## СЭДЭВ 2-ЫН ҮНЭЛГЭЭ

Энэ үнэлгээг багийнхаа аль нэг гишүүнээр үнэлүүлэх зааварчилгаа өгч, хуудсаа хурааж аваарай.

ШАЛГУУР	ТҮВШИН					
	1 Эзэмшээгүй	2	3	4	5	6 Маш сайн
1. Энтрепренершипийн санаа гаргах						
2. Энтрепренершипыг хөгжүүлэх өөрчлөх санааг гаргах						
3. Энтрепренершипийн оролцогчийг тодорхойлох						
4. Эдгээр оролцогчийн үйл ажиллагааны чиглэлийн талаар мэдлэг, ойлголт						
5. Энтрепренершипийн үйл ажиллагаанд оролцогч талууд ямар дэмжлэг үзүүлэх боломжтойг тодорхойлох.						

(Авсан нийт оноо) \* 3.34 =  %



СЭДЭВ 3:

# ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД

Дэд сэдэв 3.1

ТУХАЙН ОРОН НУТАГ, БҮЛЭГ НӨХӨРЛӨЛ, ИРГЭДИЙН  
ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ

Дэд сэдэв 3.2

ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭГ ТАНИХ

Дэд сэдэв 3.3

ХЭРЭГЦЭЭГ ХАНГАЖ БУЙ ТУРШЛАГЫГ ИЛРҮҮЛЭХ,  
ӨӨРСДИЙН САНААГ ХӨГЖҮҮЛЭХ

## СЭДЭВ 3: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД

### Дэд сэдэв 3.1

## ТУХАЙН ОРОН НУТАГ, БҮЛЭГ НӨХӨРЛӨЛ, ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ

### *Зөвшил*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Орон нутгийн бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тодорхойлох
- Хүсэл, хэрэгцээ ялгаатай болохыг танин мэдэх
- Дижитал мэдлэг, багаар ажиллах, харилцах, тунгаан бодох чадвар, сониуч, санаачилгатай байх, хэрэгцээг илрүүлэхийн тулд хүчин чармайлт гаргах

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!



Танхимын сургалтын үйл ажиллагаа

80 минут

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт талаар асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### ХҮНИЙ ХҮСЭЛ БА ХЭРЭГЦЭЭ ЯЛГААТАЙ ЮУ?

Багш суралцагчдыг гарын авлагынхаа **Дасгал 11**-ийг гүйцэтгэхийг хүснэ. Багш суралцагчдаас хүсэл, хэрэгцээ хоёрын хамгийн чухал ялгаа юу байгааг асууж ярилцана.

**Хэрэгцээ /need/** гэдэг нь хүнд аливаа зүйл хэрэгтэй болох нь мэдрэгдэж санаанд буухыг,

харин **Хүсэл /want/** гэдэг нь хэрэгцээгээ хангах тэмүүллийг хэлнэ.

Хэрэгцээ     Хүсэл

Чихэр	Мэргэжил	Спортын хэрэгсэл	Хоол хүнс	Цахилгааны төлбөр
Түрээсийн төлбөр	Шинэ технологи	Аялал	DVD тоглуулагч	Багаж хэрэгсэл
Сурах	Ус	Түргэн хоолны газар хоол идэх	Интернэт	Шинэ хувцас
Кино үзэх	Кофе уух	Бусдад бэлэг өгөх	Үсээ засуулах	Ундаа уух
Ажлын хувцас	Машины даатгал	Кабель тавиулах	Хандив өгөх	Гар утас
Хадгаламжид мөнгө хийх	Туршлагажих	Дулааны төлбөр	Шүдний эмнэлэгт үзүүлэх	Тоглоом авах



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

## БИДЭНД ЯМАР ХЭРЭГЦЭЭ, БАС ХҮСЭЛ БАЙНА ВЭ?

Багш баг тус бүрт тухайн орон нутаг, бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тандах, тодорхойлох даалгавар өгч үүнийг танхимын бус үйл ажиллагаагаар хийж гүйцэтгэх бөгөөд хэрэгцээг судлах ажлын бэлтгэлийг одоо хийх хэрэгтэйг сануулна. Суралцагчид иргэдээс судалгаа авахдаа тэднээс зөвшөөрөл авах нь зүйтэй гэдгийг сануулаарай.

Юуны өмнө багш суралцагчдаас гарын авлагынхаа **Удирдамж 1**-тэй танилцаж тодруулах зүйл байвал багшаас асуухыг хүснэ.

Багш багуудын **Удирдамж 1**-ийн дагуу удирдан чиглүүлнэ. Судалгааны жишиг асуулгатай ижил төстэй асуулгыг багаараа ярилцаж бэлтгэхэд анхаараарай.

Багууд **удирдамжийн** дагуу хэн аль ажлыг хийх, хэзээ гүйцэтгэх гэх мэт ажил үүргээ хуваарилж, багийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө (гарын авлагын **Хүснэгт 10**-ыг үзнэ үү) боловсруулна.

**Үйл ажиллагааны менежер** гишүүдийн ажлыг хуваарилах, **хүний нөөцийн менежер** суралцагчдын оролцоог хангах, **материаллаг нөөцийн менежер** анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, **харилцааны менежер** холбогдох хүмүүстэй холбогдож, хэдийд судалгаа авч болохыг тогтоож багийн гишүүдэд мэдэгдэнэ. Мөн багшаас зөвлөгөө авах цагийг товлох хэрэгтэй болно.



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

ИРГЭД БОЛОН БҮЛЭГ НӨХӨРЛӨЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТАНДАЖ,  
УЧИР ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ

Мэдээллийг суралцагчийн гарын авлага дахь **Удирдамж 1**-ийн дагуу цуглуулна. **Удирдамж 1**-тэй танилцсаны дагуу багууд хэн, юу хийх, хэзээ хийхээ ярилцаад **Хүснэгт 10**-ыг бөглөж багийн ажлын төлөвлөгөөгөө бэлэн болгоно. Багш багуудад асуулгаа хувилж олшруулахад тусална.

Танхимын сургалтын дараа суралцагчид төлөвлөгөөний дагуу, боловсруулсан асуулгаа ашиглан мэдээлэл цуглуулна.


Суралцагчид багаар хамтран орон нутгийн иргэдийн хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулна.

Багш танхимаас гадуур багуудад зөвлөн туслах хэрэгтэй. Ялангуяа асуулгын дагуу цуглуулсан мэдээллийг **Хүснэгт 11**-д компьютер ашиглан нэгтгэх, шинжилгээ хийхдээ суралцагчдад багшийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут



Дараагийн хичээлд **Хүснэгт 11**-ийг ашиглах тул бэлэн болгосон байх шаардлагатай. Ийм учраас багш та багуудын материаллаг нөөцийн менежерүүдэд дараагийн хичээлд бэлтгэл хангаж ирэхийг сануулаарай. Түүнчлэн дараагийн хичээлд бизнесийн байгууллага, төрийн байгууллагын төлөөлөл зайлшгүй оролцох шаардлагатай тул багийн харилцааны менежерүүдэд холбогдох хүмүүсийг хичээлд урьж оролцуулах хэрэгтэйг сануулна.

Дараагийн танхимын хичээл компьютерын лабораторид явагдах тул, **материаллаг нөөцийн менежерүүд** танхимын бэлэн байдлыг хангана.

## СЭДЭВ 3: ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД

### Дэд сэдэв 3.2

## ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭГ ТАНИХ

### *Зориго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Орон нутгийн бүлэг нөхөрлөл, иргэдийн хэрэгцээг тодорхойлох
- Хүсэл, хэрэгцээ ялгаатай болохыг танин мэдэх
- Хүмүүсийн хэрэгцээ тэдний нас, хүйс, боловсролын түвшин, ажил хөдөлмөр эрхэлдэг эсэхээс шалтгаалан ялгаатай байгаа эсэхийг илрүүлэх
- Судалгаа, шинжилгээ хийх, үр дүнг танилцуулах
- Дижитал мэдлэг, багаар ажиллах, харилцах, тунгаан бодох чадвар, сониуч, санаачилгатай байх, хэрэгцээг илрүүлэхийн тулд хүчин чармайлт гаргах

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Компьютер (хүүхэд тус бүрд байх)
- Флипчартны цаас
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалтад орон нутгийн бизнесийн байгууллага, төрийн байгууллагын төлөөлөл оролцохыг санаарай.

Багш суралцагчдаас мэдээлэл цуглуулах ажилтай холбоотой дараах асуултуудыг асууж хариулт авна. Үүнд:

- ①. Мэдээлэл цуглуулах ажлаас чиний сурсан хамгийн чухал зүйл юу вэ?
- ②. Арай өөрөөр хийсэн бол илүү сайн хийх байсан гэж бодож байгаа зүйл байна уу?
- ③. Мэдээлэл цуглуулахад чи ямар ажлыг хамгийн сайн хийж чадсан бэ?
- ④. Мэдээлэл цуглуулах даалгаврын хамгийн хөгжилтэй хэсэг юу байсан бэ?
- ⑤. Хамгийн хэцүү байсан зүйл юу вэ?
- ⑥. Дараагийн удаа дахин хийх бол юуг сайжруулах хэрэгтэй гэж бодож байна вэ?



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

СУРГУУЛЬ, ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН НИЙТЛЭГ БОЛОН  
ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛЖ, ШИНЭЭР ТОМЬЁОЛОХ

Асуулт хариултын дараа багш баг бүрийг **Хүснэгт 11**-ийг ашиглан дараах асуултын чиглэлээр танилцуулга бэлтгэх даалгавар өгнө. Танилцуулгыг гарын авлагын Удирдамж 2-ийн дагуу бэлтгэнэ.

1. Судалгаанд хэдэн хүн хамрагдсан бэ? Хамрагдсан хүний тооноос илүүтэй тэдний төлөөлөх чадвар (тухайн бүлгийн хүмүүсийн онцлогийг илэрхийлсэн байдал)- ыг чухалчилна
2. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэдэн хувь нь эрэгтэй, хэдэн хувь нь эмэгтэй байсан бэ? Дугуй диаграммаар үзүүлнэ үү?
3. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэдэн хувь нь 8-аас доош насны, **9-13, 14-18, 19-25, 26-35, 36-43, 44-50, 51-60, 61**-ээс дээш насны хүмүүс байсан бэ?
4. Судалгаанд оролцсон хүмүүсийн хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг, малчин, тэтгэвэрт гарсан, сурдаг, ажилгүй хүмүүс байна вэ?
5. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хамгийн нийтлэг хэрэгцээ юу байна вэ?
6. Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ ялгаатай байна уу?
7. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэрэгцээ насны бүлгээр ялгаатай байна уу?
8. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэрэгцээ хөдөлмөр эрхэлдэг байдлаар ялгаатай байна уу?
9. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэрэгцээ боловсролын түвшнээр ялгаатай байна уу?

Сургалтад урилгаар оролцож буй төлөөллүүд багийн танилцуулгад санал, зөвлөмж өгнө. Танилцуулгын дараа багш багуудаас нэг нийтлэг хэрэгцээг сонгуулна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

НИЙТЛЭГ ХЭРЭГЦЭЭНД ҮНДЭСЛЭН ОРОН НУТАГТ ЮУ ХИЙЖ БОЛОХ ТАЛААР  
ХЭЛЭЛЦЭХ

Багш суралцагчидтай хамтран, сонгосон хэрэгцээг хангах энтрепренершипийн ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж болох санаанууд болон тухайн үйл ажиллагаа ямар үр дүнд хүрэх, ямар ач холбогдолтой талаар ярилцаарай. Аль болох олон энтрепренершипийн санааг гаргах чиглэл өгөөрэй.

Сургалтын төгсгөлд багш суралцагчдаас гарын авлагын **Дасгал 12**-ыг гүйцэтгэх даалгавар өгнө.

Багш танхимын бус үйл ажиллагааны зааварчилгаа өгч шаардлагатай бол нэмэлт зөвлөгөө өгнө.

Багууд өмнөх хичээл дээр тодорхойлсон нэн чухал хэрэгцээг хангах чиглэлээр ямар аж ахуйн нэгж, бизнесийн байгууллага, нөхөрлөл ажилладаг талаар мэдээлэл цуглуулж нэг нэг кейс бэлтгэнэ.

Кейсдээ суралцагчийн гарын авлагын **Удирдамж 3**-ын дагуу дүн шинжилгээ хийхийг анхааруулна.

Танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой багийн менежер бүр өөр өөрийн ажил үүргийн дагуу ажиллах хэрэгтэй болно.

**Үйл ажиллагааны менежер** гишүүддээ ажлаа хуваарилах, **хүний нөөцийн менежер** суралцагчдын оролцоог хангах, **материаллаг нөөцийн менежер** анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, **харилцааны менежер** шаардлагатай хүмүүстэй холбогдох болон багштай уулзах уулзалтыг товлох хэрэгтэй болно.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

**80**  
минут

## ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:

Дараагийн өдрийн хичээлд баг тус бүр орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангаж буй кейсүүдийг танилцуулах шаардлагатай болно.

Ийм учраас багш та багуудад танхимын бус сургалтаар гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг бэлэн болгож ирэх ёстойг сануулаарай.

## СЭДЭВ 3: ЭНТРЕПРЕНЕРШИГИЙН ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖУУД

### Дэд сэдэв 3.3

## ХЭРЭГЦЭЭГ ХАНГАЖ БУЙ ТУРШЛАГЫГ ИЛРҮҮЛЭХ, ӨӨРСДИЙН САНААГ ХӨГЖҮҮЛЭХ

### Зорилго

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Орон нутгийн иргэдийн нийтлэг хэрэгцээг хангах чиглэлийн энтрепренершипийн үйл ажиллагааны жишээ, тэдгээрийн давуу болон сул талыг тодорхойлох
- Хэрэгцээг хангах илүү шинэлэг энтрепренершипийн санаа гаргах, боломжийг тодорхойлох
- Бусадтай хамтран ажиллах, эргэцүүлэх
- Сониуч, санаачилгатай, бүтээлч байх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Бизнес санааны тухай **Видео 8 – Бизнес санаа хэрхэн олох вэ?**
- **Бонус Видео** – Багаараа хамтран инновацлаг санаа хөгжүүлэх нь
- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Зургийн хэрэглэл (өнгийн харандаа, хар харандаа, шугам, өнгийн фломастер, А4 цаас, цавуу)
- Маркер, харандаа, баллуур гэх мэт багийн ажлыг тэмдэглэх хэрэгсэл



Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Мөн сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямархуу өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг хүснэ. Бие биенээ анхааралтай сонсохыг хүсээрэй.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### СУРГУУЛЬ, ОРОН НУТГИЙН АСУУДАЛ, ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАЖ БУЙ ТУРШЛАГУУД ЮУ БАЙНА ВЭ?



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

120  
минут

Багш баг тус бүрд орон нутгийн иргэдийн нийтлэг хэрэгцээг хангаж буй кейсүүдийг танилцуулах даалгавар өгнө. Танилцуулгыг багийн бүх гишүүд ээлж ээлжээрээ хийнэ гэдгийг анхааруулна.

Танилцуулгыг дараах асуултуудын дагуу бэлтгэж хийнэ. Танилцуулгаа флипчартны цаасан дээр схем, зураг дүрслэл ашиглан хийж болно. Үүнд:



- Тухайн аж ахуйн нэгжийг ХЭН, ЯМАР ЗОРИЛГООР байгуулсан бэ?
- Тухайн аж ахуйн нэгж ямар үйлчилгээ үзүүлдэг эсвэл бүтээгдэхүүнтэй вэ? Өөрөөр хэлбэл ЯМАР ҮЙЛ АЖИЛЛАГАА эрхэлдэг вэ?
- Энэ үйл ажиллагаа ямар онцлогтой эсвэл давуу талтай вэ?
- Тэдний үндсэн ХЭРЭГЛЭГЧИД хэн бэ? Тэдэнтэй хэрхэн харилцдаг вэ?
- Тухайн аж ахуйн нэгжийг бүтээгдэхүүн, үйлчилгээгээ яаж хэрэглэгчдэд ХҮРГЭДЭГ вэ?
- Тухайн аж ахуйн нэгж ямар түүхий эд МАТЕРИАЛ, НӨӨЦИЙГ ашигладаг вэ?
- Тухайн аж ахуйн нэгж ямар байгууллага, хувь хүмүүстэй ХАМТРАН АЖИЛЛАДАГ вэ?
- Тухайн аж ахуйн нэгж яаж ОРЛОГО ОЛДОГ вэ?
- Хамгийн их ЗАРДАЛ ШААРДДАГ ямар үйл ажиллагаа байдаг вэ?
- Тухайн аж ахуй, бизнесийн байгууллага, нөхөрлөл, хоршоодод ямар ур чадвартай хүмүүс ажилладаг вэ?



- Тухайн аж ахуй, бизнесийн байгууллага, нөхөрлөл, хоршоодод ямар бэрхшээл тулгарч байсан бэ?
- Танай багийн дүгнэснээр тухайн аж ахуй, бизнесийн байгууллага, нөхөрлөл, хоршооны давуу болон сул тал нь юу вэ?

Асуултын өөр жишээг суралцагчийн гарын авлагын **Хавсралт 5**-аас мөн үзэж болохыг хэлээрэй. Ингээд бүх багуудад флипчартны цаас болон зургийн хэрэглэл тарааж өгнө.

Багууд бусад багуудад танилцуулга хийх ба багш суралцагчдад **“буруу”** гэж хэлэх, инээх гэх мэт хүндэтгэлгүй зан үйлдэл гаргахыг хориглоно. Харин үүний оронд **“яагаад”** гэж асуухыг зөвлөнө.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ЭНТЕРПРАЙЗ САНААНЫ ЖАГСААЛТ ГАРГАХ

Танилцуулгын дараа багш багуудад “хэрэв танай баг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийг ажиллуулж байсан бол иргэдийн нийтлэг хэрэгцээг хангах чиглэлээр ямар шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх байсан бэ?” гэсэн асуулт асууж багуудыг энтрепренершипийн ямар нэг санааны жагсаалт боловсруулах даалгавар өгнө. Ингэхдээ суралцагчдад санаа өгөх үүднээс энэхүү гарын авлага дахь жагсаалтыг танилцуулж болно (Хавсралт 4).

Багууд энэ асуултын дагуу баг дотроо ярилцаж нийтлэг хэрэгцээг хангах шинэ санааны жагсаалт гаргана.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ЭНТЕРПРАЙЗ САНАА ТУС БҮРИЙН ДАВУУ, СУЛ ТАЛЫГ ХЭЛЭЛЦЭХ

Багууд бусад багуудад гаргасан энтрепренершип санаануудаа танилцуулж танилцуулгыг сонсож буй багууд гарын авлагын **Хүснэгт 12**-ыг бөглөнө. Багуудын танилцуулга хоорондоо 5 минутын зайтай байх ба энэ хооронд багууд хамтаараа **Хүснэгт 12**-ыг бөглөнө. Санал, зөвлөмжөө бичсэн хүснэгтийг танилцуулга хийсэн багт өгнө.

Танилцуулга, хэлэлцүүлгийн дараа багууд бусад багуудаас ирсэн **Хүснэгт 12**-ыг ажиглаж хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн нэг санаагаа сонгоно.



Үүний дараа сонгосон энтрепренершип санааг цаашид хөгжүүлэх шаардлагатай болохыг хэлээд ингэхийн тулд яах тухай танилцъя гээд видеог үзүүлнэ.

Багш суралцагчдаас видео 8-н хамгийн гол санаа юу байв, энтрепренершипийн санааг хөгжүүлэхэд юуг анхаарах хэрэгтэй, шинэ санаагаа ганцаараа хэрэгжүүлэх үү? эсвэл бусадтай хамтрах уу? Хэрэв хэн нэгэнтэй хамтарч хийхээр бол танай баг ямар ур чадвартай байх хэрэгтэй вэ? Танай багийн гишүүд ямар сонирхол, арга барил, ур чадвартай, юуг эрхэмлэдэг байх ёстой талаар асууж хариулт авна.

Мөн суралцагчдаас сургалтын явцад юу сурсан бэ? Хамгийн сонирхолтой хэсэг юу байсан бэ? Мөн бэрхшээлтэй, бас хэцүү байсан зүйл юу байсныг асууж нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна.

Сургалтын төгсгөлд багш суралцагчдаас гарын авлагынхаа **Сэдэв 3**-ын үнэлгээг хийж, багшид хураалгахыг анхааруулна.

### ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:

Дараагийн хичээлд шинэ санааг хөгжүүлэх бизнес загварын тухай орох тул бизнес эрхлэгчийн төлөөллийг оролцуулах тул багийн **харилцааны менежерүүд** тэдэнтэй холбоо тогтоох ажлыг хариуцахыг хэлнэ.


## СЭДЭВ 3-ЫН ҮНЭЛГЭЭ

Сэдэв 3-ын үйл ажиллагаагаар эзэмшсэн суралцагчдын мэдлэг, чадвар, сэтгэлгээг дараах шалгуурын дагуу өөрсдөөр нь үнэлүүлээд үнэлгээний хуудсыг хурааж аваарай

### Үнэлгээний шалгуур

ШАЛГУУР	ТҮВШИН					
	1 Эзэмшээгүй	2	3	4	5	6 Маш сайн
1. Иргэд болон байгууллагын хэрэгцээг бодитойгоор илрүүлэх						
2. Хэрэгцээнд дүн шинжилгээ хийх						
3. Хэрэгцээнд тулгуурлан энтрепренершипийн боломжийг тодорхойлоход багийн гишүүдийн гаргасан өөр өөр саналын нийтлэг болон ялгаатай талыг таньж мэдэх						
4. Тодорхойгүй нөхцөл байдалд энтрепренершипийн санаа гаргах						
5. Хамгийн оновчтой санааг илрүүлэх, дүгнэлтээ бусадтай хуваалцах, өөрийгөө ойлгомжтой илэрхийлэх						
6. Энтрепренершипийн санаагаа хэрэгжүүлэхэд өөрийн болон багийн чадавхыг зөв тодорхойлох						
7. Энтрепренершипийн санаагаа хэрэгжүүлэхэд холбогдох ёс зүй, хэм хэмжээний талаарх ойлголт						

(Авсан нийт оноо) \* 2.4 =  %



СЭДЭВ 4:

# ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Дэд сэдэв 4.1

ЭНТРЕПРЕНЕРШИП САНАА ХӨГЖҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ЗАМ, БОЛОМЖ СААД БЭРХШЭЭЛ

Дэд сэдэв 4.2

САНХҮҮГИЙН НӨӨЦ

Дэд сэдэв 4.3

БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд сэдэв 4.4

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРАХ ЭРСДЭЛ,  
ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

## СЭДЭВ 4: ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

### Дэд сэдэв 4.1

# ЭНТРЕПРЕНЕРШИП САНАА ХӨГЖҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, БОЛОМЖ СААД БЭРХШЭЭЛ

## Зөвшил

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтрепренершипийн суурь мэдлэг
- Хэрэгцээтэй холбоотой боломжийг эрэлхийлэх
- Бизнес загвар боловсруулах
- Эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах арга замыг эрэлхийлэх
- Асуудлын учир шалтгаан, уялдаа холбоог эрэлхийлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Бизнес загварын тухай  
[Видео 9 - Бизнес санаагаа бизнес загвар болгон хөгжүүлэх тухай](#)
- Бизнес загварын тухай  
[Видео 10 - Бизнес загвар боловсруулах](#)
- Бизнес загварын тухай  
[Видео 11 – Бизнес санааг хэрэгжүүлэх орчны үнэлгээ хийх тухай](#)
- Бизнес загварын тухай  
[Илтгэл 2 – Бизнес загвар](#)
- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас
- Цавуутай өнгийн цаас, маркер

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Түүнчлэн сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэж суралцагчдыг ажиглаж үнэлнэ.

Сургалтад орон нутгийн бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулна.

**Энэхүү сургалт өмнөх сургалтын үргэлжлэл гэдгийг анхаараарай.**

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.



Танхимын сургалтын үйл ажиллагаа

**ҮЙЛ АЖИЛЛАГАА 1**

**ЭНТРЕПРЕНЕРШИП САНААГАА ХЭРЭГЖҮҮЛЭХ БИЗНЕС ЗАГВАРАА ЗУРАГЛАХ**


**160 МИНУТ**

Багш багуудад өмнөх сургалтаар сонгосон энтрепренершип санаагаа эргэн санаж, ярилцахыг хүснэ.

Энэ санааг цаашид энтрепренершип төсөл болгон хэрэгжүүлэхэд бизнес загвар чухал гэдгийг хэлээд суралцагчдад видеог үзүүлнэ.







Видеог үзүүлсний дараа бизнес загвар гэж юу болох, түүний бүрэлдэхүүн юу байдгийг “OPEN MIC” төслийн жишээн дээр ярилцана.

Багш тухайн видеонд үзүүлсэн бизнес загвар ямар бүрэлдэхүүнтэй байсныг асууж, дараах зургийг самбарт үзүүлж тайлбарлана.



### Хүснэгт 13. БИЗНЕС ЗАГВАРЫН ХАВТГАЙ

OPEN MIC төсөл нь нээлттэй микрофоныг Түдэвтэй сумын сургуулийн орчинд ажиллуулж, өсвөр үеийнхний авьяас, ур чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэхээс гадна харилцан суралцах, мэдлэг, туршлагаа хуваалцах боломжуудыг бий болгоно. Тиймээс энэхүү төсөл сурагчдын хэрэгцээг оролцоогоор нь хангах бизнес загвартай.

<b>ЖИШЭ</b>	<p><b>ГОЛ ТҮНШҮҮД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эх, багш нар</li> <li>• Сургууль төгсөгчид</li> <li>• Орон нутгийн удирдлага</li> <li>• Бизнес көүчүүд, менторууд</li> <li>• Бусад дэмжигч байгууллагууд</li> </ul> 	<p><b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн болон бусад мэдээ, мэдээлэл</li> <li>• Ярилцлага зөвлөгөө</li> <li>• Хэрэгцээ тодорхойлох судалгаа</li> </ul>	<p><b>ХЭРЭГЛЭГЧДИЙН ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сурагчдад зориулсан хэрэгцээт болон сонирхолтой мэдээллүүд</li> </ul> 	<p><b>ХЭРЭГЛЭГЧДЭД САНАЛ БОЛГОХ ОНЦЛОГ ҮЙЛЧИЛГЭЭ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Даваа гарагийн илтгэл</li> <li>• Мягмар гарагийн дуу</li> <li>• Лхагва гарагийн шүлэг</li> <li>• Пүрэв гарагийн түүх</li> <li>• Баасан гарагийн бүжиг</li> </ul> 	<p><b>ЗОРИЛТОТ ХЭРЭГЛЭГЧ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн сурагчид</li> <li>• Сургуулийн багш, ажилтнууд</li> </ul> 
	<p><b>ҮНДСЭН НӨӨЦ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Студи</li> <li>• Сайн дурын хөтөлөгч, сурвалжлагчид</li> <li>• Тоног төхөөрөмж</li> </ul>	<p><b>ҮЙЛЧИЛГЭЭ, БҮТЭЭГДЭХҮҮН ХҮРГЭХ АРГА ЗАМУУД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн олон нийтийн сүлжээ, чат</li> <li>• Сумын олон нийтийн сүлжээ</li> <li>• Сургуулийн мэдээллийн самбар</li> </ul>			
<p><b>ЗАРДАЛ ШААРДАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тоног төхөөрөмж худалдан авалт</li> <li>• Материал, хангамж худалдан авалт</li> <li>• Интернет, утасны нэгж ашиглалт</li> <li>• Бусад</li> </ul> 		<p><b>ОРЛОГО ОЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ, БҮТЭЭГДЭХҮҮН</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Лекцийн тасалбар</li> <li>• Кофе үйлчилгээ</li> <li>• Дуу, бүжиг заах сургалт</li> <li>• Захиалгат нэвтрүүлэг хийх үйлчилгээ</li> </ul> 			

Багш дахин тайлбарлаж үзүүлсний дараа баг бүрд өөрсдийн сонгосон санааныхаа бизнес загварыг боловсруулах даалгавар өгнө.

Багууд өөр өөрсдийн сонгосон санааныхаа бизнес загварыг видеонд үзүүлсний

адилаар хамтран боловсруулах ба загвараа флипчартны цаасан дээр хийнэ.

Багш бизнес загвар боловсруулах явцад суралцагчдад дэмжлэг үзүүлж, зөвлөн тусална. Мөн бизнес эрхлэгчдийнхээ

төлөөллийг багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг хүснэ.

Загвараа боловсруулсны дараа бусад багууд болон бизнес эрхлэгчдийн төлөөлөлд загвараа танилцуулж санал, зөвлөмжийг сонсоно. Багш багийн гишүүд загвараа танилцуулах явцад идэвхтэй оролцоотой

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### БИЗНЕС ЗАГВАРАА ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЭХ

Бизнес загвараа сайжруулсны дараа багш суралцагчдаас тэдний загварыг орон нутагт хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар асууж, ярилцана.

Үүний дараа багш суралцагчид дараагийн видеог үзүүлж суралцагчид юу ойлгосон, юу ойлгоогүй, ямар хэсэг нь хэцүү санагдсан талаар ярилцана.

Дараа нь багш багуудыг гарын авлагынхаа **Удирдамж 4**-тэй танилцаж түүний дагуу бизнес загварыг хэрэгжүүлэх боломжийг судлах даалгавар өгнө. Багуудад 4 өнгийн (**шар, ягаан, ногоон, цэнхэр**) наадаг цаас тарааж өгнө.

Багш эхлээд багуудыг удирдамжтай танилцахыг хүсэж ойлгомжгүй зүйл байгаа эсэхийг тодруулж нэмэлт тайлбар өгнө.

Даалгаврыг гүйцэтгэхдээ өмнөх сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээгээ ашиглахыг сануулаарай.

байгаа, бусад багуудын санал, зөвлөгөөг тэмдэглэж байгаа эсэхэд анхаарч шаардлагатай бол чиглүүлнэ.

Танилцуулга, санал, зөвлөмжийн хэсэг дууссаны дараа багууд өөр өөрсдийн загвараа сайжруулна.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### БИЗНЕС ЗАГВАРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ТАНИЛЦУУЛАХ


Багууд зураглалаа хийж дууссаны дараа багш тэднээс энэ бизнес загварыг хэрэгжүүлэхэд тэдэнд ямар ур чадвар хэрэгтэй талаар асууж ярилцана. Энэ үеэр орон нутгийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар ур чадвар хамгийн чухал байдаг талаар санал, зөвлөгөө өгч өнөөдрийн сургалтын үйл ажиллагаа өндөрлөнө.

Сургалтын төгсгөлд багш багуудад танхимын бус үйл ажиллагаагаар гарын авлагынхаа **Дасгал 13**-ыг гүйцэтгэхийг сануулж, шаардлагатай бол нэмэлт зөвлөгөө өгнө.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

**80**  
МИНУТ





Дэд сэдэв 4.2

САНХҮҮГИЙН НӨӨЦ







*Зориго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Мөнгө, орлого, зарлага, зээл, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн байгууллагын тухай мэдлэг
- Санхүүгийн нөөцийг тооцоолох, хуваарилах
- Санхүүгийн дүрэм, журмыг баримтлах
- Бусдын хэлж байгаад анхаарал хандуулж, санал зөвлөмжийг авах, тэднээс асуулт асуух, хариултыг ойлгох,
- Санаагаа тайлбарлах, үзэл бодлоо илэрхийлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана.

Үүнд:

- Санхүүгийн суурь ойлголтын тухай  
[Видео 12 - Санхүүгийн мэдлэг, бараа ба үйлчилгээ](#)  
- Санхүүгийн суурь ойлголтын тухай  
[Видео 13 - Төсөв](#)  
- Санхүүгийн суурь ойлголтын тухай  
[Видео 14 - Банк болон санхүүгийн байгууллага](#)  
- Сум хөгжүүлэх сангийн тухай  
[Видео 15 - Сум хөгжүүлэх сангийн зээл](#)
- Жижиг Дунд Үйлдвэрлэлийг (ЖДҮ) дэмжих сангийн тухай  
[Видео 16 - ЖДҮ сангийн зээл](#)
- Мөнгө, санхүүгийн тухай суурь ойлголт  
[Илтгэл 3 - Мөнгө ба орлого](#)
- Мөнгө, санхүүгийн тухай суурь ойлголт  
[Илтгэл 4 – Зардал ба хуримтлал](#)
- Мөнгө, санхүүгийн тухай суурь ойлголт  
[Илтгэл 5 - Зээл](#)
- Флипчартны цаас, маркер гм



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямархуу өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг хүснэ. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### САНХҮҮГИЙН НӨӨЦ ГЭЖ ЮУ ВЭ?

Багш суралцагчдаас ямар нэг үйл ажиллагааны санхүү, мөнгөний талаар ямар ойлголттой байгааг тандаж дараах асуултыг асууж ярилцана. Үүнд:

1. Мөнгө, орлого, зарлага гэж юу вэ?
2. Төсөл хэрэгжүүлэх мөнгөө хаанаас олж авах вэ?
3. Зээл, түрээсийн төлбөр, санхүүгийн байгууллагууд

Асуулт, хариултын дараа багш суралцагчдад санхүүгийн видеонуудыг үзүүлж суралцагчидтай юу ойлгосон, аль хэсгийг сайн ойлгоогүй, тодруулах асуулт байгаа эсэхийг ярилцана.



### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖУУД

Ингээд багуудаас боловсруулсан төслөө хэрэгжүүлэхийн тулд хаанаас санхүүжилт авах, мөнгө хэрхэн босгох асуудлыг хөндөж хэлэлцүүлэг өрнүүлнэ. Үүнд:

- Өөрийн хуримтлуулсан хадгаламжаар
- Банкны зээлээр
- Лизингээр
- Эцэг, эх, ах дүү, найз нөхдөөс цуглуулсан хандиваар
- Тусгай сангуудын зээл
- Үнэт цаас, хувьцааны ноогдол ашгаар гэх мэт

Багш суралцагчдад санхүүгийн байгууллагуудын талаар танилцуулга хийнэ. Энтрепренершип төсөлд санхүүжилт олгодог байгууллагууд, сангийн талаар мэдээлэл өгөхдөө ЖДҮ болон Сум хөгжүүлэх сангийн тухай видеог үзүүлнэ. Мөн орон нутгийн банкны зээлийн мэдээллийн танилцуулга эсвэл хэвлэмэл материал ашиглаж болно.



Танхимын сургалтын үйл ажиллагаа

120 минут

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖИЙГ  
ТОДОРХОЙЛОХ

Багшийн танилцуулгын дараа суралцагчид өөрийн төсөлд хамгийн тохиромжтой санхүүжилт авах боломжтой байгууллагыг багаараа ярилцаж сонгох ба ингэхдээ багшийн танилцуулсан байгууллага, санд тавигдах шаардлагад хэр зэрэг нийцэж байгааг үнэлж, боломжит санхүүжилтийг тодорхойлно.

Мөн баг тус бүрийн сонгосон санхүүгийн эх үүсвэр тус бүрийн давуу, сул талыг хэлэлцүүлнэ. Үүнд:

- Санхүүгийн байгууллагууд хэдийгээр ижил үйлчилгээ үзүүлдэг боловч тэдгээрийн үйлчилгээний нөхцөл, хураамж, үнэ өөр өөр байдаг тул харьцуулан судалж санхүүгийн үйлчилгээг сонгох шийдвэр гаргах
- Орчин үеийн шинжлэх ухаан технологийн хөгжилтэй холбоотой цахим банкны үйлчилгээг хөндөх  
**Тухайлбал:** АТМ үйлчилгээ, цахим банкны үйлчилгээ, мобайл банкны үйлчилгээ, мессеж банкны үйлчилгээ гэх мэт
- Түүнчлэн дижитал мөнгөний тухай ярилцана. Тухайлбал Мобиком компанийн CANDY –ийг төлбөр, худалдаанд хэрхэн хэрэглэх талаар ярилцах хэрэгтэй.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗАРДЛЫГ ТООЦООЛОХ, ТӨСЛИЙН  
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙГ ТООЦОХ

Багш багуудыг боловсруулсан төслийн зардлыг хэрхэн тооцох аргачлалд суралцахын тулд гарын авлагынхаа нэмэлт мэдээллийг уншиж танилцахыг хүснэ.

Үүний дараа багш дараах зардлуудыг бичиж ямар зардлууд болохыг ярилцана.

**Ажилчдын цалин, түүхий эд материал, бичиг хэргийн зардал, зээлийн хүүгийн зардал, худалдагчийн цалин, байрны түрээсийн зардал, тог, цахилгааны төлбөр, усны төлбөр, тоног төхөөрөмжийн зардал, утасны төлбөр, газрын түрээс, тээвэр, гэх мэт**

Дараа нь багуудад кейс өгч, зардлыг тооцох даалгавар өгнө.

**КЕЙС:**

**Орон нутагт өдөрт 10 талх хийдэг талхны жижиг цех байгуулах төслийн зардлыг тооцох**

Дээрх кейсийн хүрээнд гарах зардлыг гарын авлагын **Хүснэгт 14**-ийг ашиглан хийхийг хүснэ.




### ҮЙЛ АЖИЛЛАГАА 5

#### ТӨСЛИЙН ЗАРДЛЫГ ХЭМНЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Багуудыг хийсэн тооцоогоо бусад багуудад танилцуулахыг хүснэ. Танилцуулгын дараа багуудын тооцоо зөрөөтэй эсэх, хэрэв зөрөөтэй бол юунаас болж зөрөө гарсан, гэх мэт ярилцаж зардлыг хэмнэх ямар боломжтой байгааг ярилцана. Үүний дараа багуудаас хамгийн бодитой тооцоо хийсэн багийг сонгохыг хүснэ. Тухайн багийн тооцоог самбарт байршуулна.

Дараа нь багш бүх багуудыг хамтаараа зардлын тооцоогоо сайжруулахыг сануулна.



### ҮЙЛ АЖИЛЛАГАА 6

#### САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР МИНИЙ СУРСАН ЗҮЙЛ

Багш суралцагчдаас өнөөдрийн үйл ажиллагааны явцад сурч мэдсэн зүйлээ гарын авлагын **Дасгал 14**-ийг ажиллах явцдаа эргэцүүлэхийг хүснэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 7

#### БАГИЙН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ

Багууд санхүүгийн төлөвлөгөөгөө хэрхэн боловсруулсан болон энэ боловсруулалтыг хийхэд танай багт нийтлэг хамгийн сайн чадаж байсан, бэрхшээлтэй байсан, ур чадвар дутагдалтай байсан зүйлийн талаар бусад багуудад танилцуулж, цаашдаа багаараа юуг сайн хийж сурах талаар өөр өөрсдийн багаа дүгнэнэ.



## СЭДЭВ 4: ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

### Дэд сэдэв 4.3

## БИЗНЕС ТӨЛӨВЛӨЛТ

### *Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Бизнес төлөвлөгөөний талаарх ойлголт
- Бизнесийн зорилго, зорилт, нөөц, үйл ажиллагааг тодорхойлох, бизнес төлөвлөгөө бичих
- Бизнес төлөвлөгөө бичихэд мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглах
- Төлөвлөх, зохион байгуулах, нөөц боломжоо хадгалах, санал зөвлөмж хүлээн авах, зөрчлийг үр дүнтэйгээр шийдэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана.

Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Бизнес төлөвлөгөөний тухай [Илтгэл 6 – Бизнес төлөвлөгөө](#)
- Бизнес төлөвлөгөө ба бизнес төлөвлөлтийн тухай [Видео 17 - Бизнес төлөвлөгөө ба бизнес төлөвлөлт](#)
- Флипчартны цаас, өнгийн маркер

Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

160  
минут

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### БИЗНЕС ТӨЛӨВЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ?


Багш суралцагчдаас бизнес төлөвлөгөө гэж юу болохыг асууж ярилцана.

Үүний дараа багш суралцагчдад бизнес төлөвлөгөөний талаарх илтгэлийг танилцуулж тэднээс ойлгомжгүй зүйл байгаа эсэхийг асууж тодруулна.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАРТАЙ ТАНИЛЦАХ, БҮТЦИЙГ ОЙЛГОХ

Багш суралцагчдаас гарын авлагынхаа **Хүснэгт 15** дахь бизнес төлөвлөгөөний загвар болон жишээтэй танилцаж ойлгомжгүй зүйл байгаа эсэхийг тодруулна.



## Хүснэгт 15. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	ТАЙЛБАР
<p><b>1.</b> ТӨСЛИЙН ХУРААНГУЙ</p>	<ul style="list-style-type: none"> <li>Төслөөр ямар бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой асуудлыг шийдэх, өнөөгийн нөхцөл байдал, багийн санал болгож буй шийдэл, зах зээлийн товч мэдээлэл, өөрөөр хэлбэл ямар хэрэгцээ байгаа, хэрэглэгч нь хэн байх тухай, ямар өсөлтийг хүлээж байгаа, энэ төслийг өөр сум, орон нутагт хэрэгжүүлж болох эсэх гэх мэт</li> </ul>
<p><b>2.</b> ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ</p>	<ul style="list-style-type: none"> <li>Багийн зорилго, зорилт (хамгийн ихдээ 3 зорилт) юу болох, энэ нь сум орон нутгийн хөгжлийн зорилго болон эдийн засгийн тэргүүлэх салбартай хэр зэрэг нийцэж байгаа тухай)</li> </ul>
<p><b>3.</b> САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ</p>	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ нарийвчлан тайлбарлах, одоо байгаа ижил төстэй бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээнээс юугаараа ялгаатай болох тухай</li> </ul>
<p><b>4.</b> ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ НӨӨЦ, ТҮҮХИЙ ЭД</p>	<ul style="list-style-type: none"> <li>Шаардлагатай нөөцийн жагсаалт, түүнийг хаанаас авах эх үүсвэр, орон нутгийн зах зээлд байдаг эсэх</li> </ul>
<p><b>5.</b> ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгч хэн байх, зорилтот хэрэглэгчид хэн байх, тэдний нас, тэдний хэрэгцээ юу болох, тухайн орон нутагт ижил төстэй бизнес байгаа эсэх, өрсөлдөгчид хэн болох, зах зээлийн судалгаа хийсэн эсэх, зорилтот хэрэглэгчид төслийн талаар ямар бодолтой байгаа эсэх, зах зээлийн судалгаа хийхдээ ямар арга хэрэглэсэн, гэх мэт</li> </ul>
<p><b>6.</b> МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ хэд байх, бусад ижил төстэй бизнесээс үнэтэй байх уу? Хямд байх уу? Яаж хэрэглэгчдэд хүргэх, хэрэглэгчдэд тусгай урамшуулалтай эсэх, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ яаж сурталчлах, гэх мэт</li> </ul>

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

## БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Багууд бизнес төлөвлөгөөний загвар болон жишээтэй танилцсаны дараа багш суралцагчдад өөр өөрсдийн боловсруулсан төслийн бизнес төлөвлөгөөг гарын авлагынхаа **Удирдамж 5**-ын дагуу боловсруулах даалгавар өгөх ба юуны өмнө багууд багаараа хийх ажлаа хуваарилна.



Өгсөн даалгаврыг гүйцэтгэхтэй холбоотой багийн гишүүд хэн юу хийхээ **Хүснэгт 16**-г ашиглан төлөвлөнө.


Сургалтын төгсгөлд багш суралцагчдад танхимын бусаар гүйцэтгэх үйл ажиллагааг танилцуулж шаардлагатай бол зөвлөгөө өгнө.

Багууд бизнес төлөвлөгөөг дуусгаж бизнес эрхлэгчид болон мэргэжлийн хүмүүст төлөвлөгөөгөө үзүүлж зөвлөгөө авч, сайжруулсан байна. Энэ үйл ажиллагааг гүйцэтгэхэд багш зөвлөн тусална.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут





## СЭДЭВ 4: ЭНТЕРПРАЙЗ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

### Дэд сэдэв 4.4

# ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРАХ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

## *Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Төслийг бодит орчинд хэрэгжүүлэхэд тулгарч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох
- Төслийн эрсдэлийг бууруулах, даван туулах арга замыг тодорхойлох
- Багаар ажиллах, тунгаан бодох, бүтээлчээр сэтгэх
- Сониуч, санаачилгатай байх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд

- Санхүү ба эрсдэлийн тухай [Илтгэл 7 – Эрсдэл ба даатгал](#)
- Суралцагчийн гарын авлага
- Эрсдэлийн тухай [Видео 18 – Эрсдэл гэж юу вэ?](#)



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Түүнчлэн өнөөдрийн сургалтад орон нутгийн аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл оролцох болно.



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### НАДАД АСУУЛТ БАЙНА?

Багш суралцагчдаас тэдний амьдралын болон сургуулийн орчинд ямар эрсдэл байж болох, түүнийг хэрхэн бууруулж болох талаар асууж ярилцана.

Асуулт хариултын дараа багш суралцагчдад эрсдэлийн талаарх видеог үзүүлж ярилцана.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ЭРСДЭЛТЭЙ ТУЛГАРЧ БАЙСАН ТУРШЛАГУУД

Дараа нь багш багуудаас энтрепренер төслийг хэрэгжүүлэхэд ямар эрсдэлүүд байж болох талаар сургалтад уригдсан аж ахуй эрхлэгчийн төлөөллүүдээс асууж, тулгарсан эрсдэлээ яаж зохицуулж байсан, энэ нь тэдний аж ахуйн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн талаар асууж ярилцана.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### ЭРСДЭЛИЙГ УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ

Багш суралцагчдаас тэдний багийн энтрепренер төслийг хэрэгжүүлэхэд ямар эрсдэл тулгарч болохыг жагсааж бичихийг хүснэ.


Үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах эрсдэлүүд тулгарч болно. Жишээ нь сүүн бүтээгдэхүүний төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах эрсдэлийг авч үзэж болно. Үүнд:

- Цаг агаартай холбоотой
- Түүхий эд материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй холбоотой. Өөрөөр хэлбэл зах зээлд байхгүй байх эсвэл хангалт нь тасрахтай холбоотой
- КОВИД-оос шалтгаалан хөл хорио тогтоосон үед тулгарах эрсдэл

Эрсдэлийн үнэлгээ хийх загвар, жишиг санааг гарын авлагын **Хүснэгт 17**-гоос харахыг хүсээрэй.

Эрсдэлд дүн шинжилгээ хийсний дараа зураг, схем, хүснэгт ашиглан эрсдэлийг даван туулах арга замын талаар хэлэлцүүлэг хийнэ. Багш хэлэлцүүлгийг удирдана.

Үүний дараа багш багуудад эрсдэлийн төлөвлөгөөг танхимаас гадуур боловсруулах даалгавар өгөх ба үүнийг хийхийн тулд багууд танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэх бэлтгэлээ хангана.



Танхимын бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой багийн менежер бүр өөрийн ажил үүргийн дагуу ажиллах хэрэгтэй болно.

**Үйл ажиллагааны менежер** гишүүдийн ажлыг хуваарилах, **хүний нөөцийн менежер** суралцагчдын оролцоог хангах, **материаллаг нөөцийн менежер** анги танхим, хэрэглэгдэхүүн бэлтгэх, **харилцааны менежер** шаардлагатай хүмүүстэй холбогдох болон багштай уулзах уулзалтыг товлох хэрэгтэй болно.

Хичээлийн төгсгөлд багш суралцагчдаас гарын авлагынхаа **Дасгал 15**-ыг гүйцэтгэх даалгавар өгнө.

## ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:

Дараагийн хичээлд аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын төлөөлөл оролцох шаардлагатай тул багийн **харилцааны менежерүүд** холбогдох хүмүүстэй уулзаж бэлтгэл хангана.

Танхимын хичээл компьютерын танхимд орох тул, **материаллаг нөөцийн менежерүүд** танхимын бэлэн байдлыг хангах хэрэгтэй.

## СЭДЭВ 4-ИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ үнэлгээг багийн гишүүний аль нэгээр үнэлүүлэхээр зааварчилгаа өгч хуудсаа хурааж аваарай.

ШАЛГУУР	ТҮВШИН					
	1 Эзэмшээгүй	2	3	4	5	6 Маш сайн
1. Төслийн зорилго, зорилтоо олон хувилбараар тодорхойлох						
2. Дээрх хувилбар бүрийн давуу болон сул талыг орон нутгийн нөөцтэй харьцуулан бодитой шийдвэр гаргах						
3. Багийн гишүүдийн санал зөрөлдсөн үед бүтээлчээр хэлэлцүүлэгт оролцох						
4. Төслийг хугацаанд нь гүйцэтгэхэд хүчин чармайлт гаргах						
5. Гаргасан шийдвэрийн талаар бусдын санал бодлыг сонсох, багийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцох						
6. Төслийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн төлөвлөлт хийхэд тодорхой үүрэгтэй оролцох						
7. Төслийг боловсруулахад өөрийн ур чадварт түшиглэн тодорхой даалгавар гүйцэтгэх санал гаргах						
8. Төслийн үйл ажиллагааны төлөвлөлт хийх, мэдээллийн технологи ашиглах						
9. Төслийг боловсруулахад гаргасан алдаагаа давтахгүй байх						

(Авсан нийт оноо) \* 1.85 =  %



СЭДЭВ 5:

# ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ

Дэд сэдэв 5.1

ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дэд сэдэв 5.2

ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ЯВЦ, ҮР ДҮНГИЙН ТАНДАЛТ

Дэд сэдэв 5.3

ТӨСЛИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ

## СЭДЭВ 5: ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ

## Дэд сэдэв 5.1

ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ*Зөвшил*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг оновчтой хуваарилах
- Орон нутгийн энтрепренершипийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх
- Энтрепренершипийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох
- Багаар ажиллах, харилцах, тунгаан бодох
- Орон нутгийн нийгэм соёлын онцлогийг танин мэдэх
- Бүтээлч, санаачилгатай байх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Компьютер (хүүхэд бүрд 1 байх)
- Яриа бичиж авах, зураг авах боломжтой гар утас (хамгийн багадаа баг бүрд 1 байх)
- Флипчартны цаас (багаар ажиллахдаа ашиглах)
- Бал, харандаа



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Энэ өдрийн сургалтад орон нутгийн аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын төлөөлөл оролцохыг санаарай!

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

Танхимын сургалтын зорилго нь энтрепренершипийн үйл ажиллагаа, хэрэглэгчдийн хэрэгцээнд зохистой байгаа эсэх талаар дүн шинжилгээ хийлгэн, энтерпрайзын ойлголт, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх сэдлийг бататгаж, суралцагчдын ойлголтыг нэгтгэн, танхимын бус цагаар бие даан гүйцэтгэх үйл ажиллагааны нэгдсэн чиглэл гаргах юм.



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### ЭНТРЕПРЕНЕРШИП ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ ЮУ ВЭ?

Багш суралцагчдаас багуудын боловсруулсан төслийг хэрэгжүүлэхэд хууль, дүрэм журмын ямар нөхцөл байдаг талаар асууна.

Суралцагчид баг дотроо ярилцаад төслөө хэрэгжүүлэхэд ямар хууль, дүрэм, журмыг мөрдөх ёстойг тодорхойлно. Багш зочин бизнес эрхлэгчээс ямар хууль, дүрэм журмыг мөрдөх шаардлагатай, тэр дундаа хүрээлэн буй орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой журмын талаар танилцуулахыг хүснэ.

Багууд зөвлөхийн танилцуулгад үндэслэн боловсруулсан энтрепренершип төсөлд хүрээлэн буй орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ямар дүрмийг баримтлах тухай зураглал хийхийг зөвлөнө. Багууд зураглалаа **“зурагт ном”**-ын хэлбэрээр боловсруулахыг анхааруулна.



Боловсруулсан зураглалаа бусад суралцагчид болон аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагын төлөөлөлд танилцуулж санал авна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

### НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ, ТЭДЭНД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛ

Суралцагчид зураглалаа танилцуулж, санал авсны дараа өөрсдийн төсөлтэй ижил төстэй орон нутгийн аж ахуйн нэгж бодит амьдралд ямар бэрхшээлтэй тулгарч болох талаар мэдэх хэрэгтэй болно.

Ийм учраас багш суралцагчдад танхимаас гадуур багаараа гүйцэтгэх даалгавар өгнө. Энэ даалгавар нь **“Аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагуудтай уулзаж тэдэнд тулгардаг бэрхшээлийн талаар дараах чиглэлээр мэдээлэл цуглуулах”** юм. Үүнд:

1. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ
2. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ
3. ХЭРЭГЛЭГЧИДТЭЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ
4. ЭНТРЕПРЕНЕР БОЛОН ХҮНИЙ НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ


Багууд дээрх 4 чиглэлийн бэрхшээлийг тодорхойлсны дараа **“Яагаад”** ийм бэрхшээл, сул тал байгааг илрүүлнэ. Ингэхдээ дараах 3 чиглэлээр тандалт хийж үнэлгээ, дүгнэлт хийнэ. Үүнд:

- I. Хэзээнээс эхэлж, өнөөдрийг хүртэл яаж хөгжиж ирсэн байгууллагын түүх
- II. Байгууллагын дотоод үйл ажиллагаа, төлөвлөлт, хуваарь, ажилтнуудын ур чадвар, харилцаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой ямар сул тал байгааг тандах
- III. Тухайн байгууллагын үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тандан судлаарай.

Багууд суралцагчийн гарын авлага дахь загваруудыг ашиглаж аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагаас мэдээлэл цуглуулах асуулт, сэтгэл ханамжийн асуулга бэлтгэнэ.

АСУУЛТУУД

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН АСУУЛГА





Орон нутгийн аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагуудтай уулзаж тэдэнд тулгардаг бэрхшээлийн талаарх мэдээлэл танхимаас гадуур гүйцэтгэхтэй холбоотой бэлтгэл хангах ба багш багуудыг дараах байдлаар удирдаж чиглүүлнэ. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах



- 1) Аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагууд дээр очиж бизнес эрхлэгчдээс асуух АСУУЛТЫН ХУУДАС
- 2) Хэрэглэгчийн СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ АСУУЛГА бэлтгэнэ.

- Багийн гишүүд дотроо гүйцэтгэх ажил үүргээ хуваарилах

- Багийн менежерүүд өөр өөрсдийн чиглэлээр бэлтгэлээ хангах

Багш багуудад үйл ажиллагааны нарийвчилсан бэлтгэл хийхэд тусална.




Багууд ангид хийсэн төлөвлөгөө, бэлтгэлийн дагуу мэдээлэл цуглуулах даалгавраа танхимаас гадуур гүйцэтгэж бэлтгэнэ. **АСУУЛТЫН ХУУДАС, СЭТГЭЛ ХАНАМЖИЙН АСУУЛГА** ашиглан мэдээлэл цуглуулах ба цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж гарын авлагын **Хүснэгт 18**-ыг бөглөнө. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ **MS Excel** заавал ашиглана. Үүний зааврыг суралцагчийн гарын авлагын **Хуудас 128**-аас үзээрэй.




Танхимын бус сургалтын үйл ажиллагаа

**80**  
минут

## ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:



Дараагийн сургалтад багууд өөр өөрсдийн цуглуулсан мэдээллийн үр дүнг танилцуулах тул үр дүнгээ бэлэн болгосон байх шаардлагатай.



Түүнчлэн хичээлд орон нутгийн аж ахуй эрхлэгч, бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцох шаардлагатай тул багийн **харилцааны менежерүүд** дараагийн хичээлд оролцуулах бэлтгэл хангана.



## СЭДЭВ 5: ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ

## Дэд сэдэв 5.2

ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ЯВЦ,  
ҮР ДҮНГИЙН ТАНДАЛТ*Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Энтрепренершип санааг хөгжүүлэх боломжийг тодорхойлох
- Орон нутгийн холбогдох иргэдтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх
- Багаар ажиллах чадвар, бүтээлч байх чадвар
- Тунгаах бодох чадвар
- Инновацын болон харилцааны чадвараа хөгжүүлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас (багаар ажиллахдаа ашиглах)
- Маркер
- Бал, харандаа гэх мэт
- Асуулгын хуудас



Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

Мөн өнөөдрийн сургалтад орон нутгийн аж ахуй эрхлэгч, бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцож багуудын хийсэн дүгнэлтэд санал, зөвлөмж өгөх болно.

Танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө багш суралцагчдаас зэргэлдээ сууж байгаа суралцагчаасаа өнөөдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаа, шалтгаан юу болох, өчигдөр ямар өдөр байсан, ямар нэг асуудал тулгарсан эсэх, яаж шийдсэн гэх мэт асуулт асууж ярилцахыг зөвлөнө. Бие биеэ анхааралтай сонсохыг хүсээрэй.

Багууд танхимаас гадуур цуглуулсан мэдээллээ бусад суралцагчдад танилцуулж тэдний асуултад хариулж, санал, зөвлөмжийг сонсоно.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### ОРОН НУТАГ ДАХЬ ЭНТЕРПРАЙЗЫН ШИНЭ САНААГ БОЛОВСРУУЛАХ

Танилцуулгын дараа багууд орон нутгийн аж ахуй эрхлэгч, бизнесийн байгууллагуудын бэрхшээл, сул талд үндэслэн илүү сайжруулах санаа боловсруулна. Тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн юуг сайжруулах хэрэгтэй байгаа талаар багийн санаагаа боловсруулж бэлэн болгоно.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

### ШИНЭ САНААГАА СОРИХ, БОЛОМЖ, ХЯЗГААРЫГ ТОДОРХОЙЛОХ

Багууд шинэ санаагаа бусад багуудад танилцуулах ба ингэхдээ дүрд тоглох аргыг ашиглана. Өөрөөр хэлбэл багууд тухайн энтерпрайзын үйл ажиллагааг эрхэлдэг хүмүүсийн дүрд тоглоно. Танилцуулга хийхдээ өөрсдийн шинэ санаагаа хамгаалах, хүмүүст ятган үнэмшүүлэхэд анхаарал хандуулна.

Үүний дараа бусад багууд болон орон нутгийн аж ахуй эрхлэгч, бизнес эрхлэгчдийн төлөөллөөс өгсөн санал, зөвлөмжийн дагуу шинэ санаагаа сайжруулна.



## ҮЙЛ АЖИЛЛАГАА 3,4

## ШИНЭ САНААНЫ ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД СУРАХ

Багууд шинэ санаагаа хэрэгжүүлнэ гэж төсөөлөөд тухайн аж ахуй эрхлэгч эсвэл бизнесийн байгууллагын ажилтны оронд өөрсдийгөө тавьж бодно. Тэгээд энэ шинэ санааг хэрэгжүүлэхэд өөрөө юу чаддаг, мэддэг байх ёстой талаар баг дотроо ярилцаж эргэцүүлнэ. Дараа нь багууд цаашид сурах хэрэгтэй мэдлэг, ур чадвар, сэтгэлгээ, хандлагын жагсаалт гаргана.

Төслийг болон энтерпрайз үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллагчдын энтерпренер чадвар, хамтрагч бусад талуудтай харилцах чадвар нэн чухал байна. Суралцагчид өөрийн сонирхсон энтерпрайзын үйл ажиллагаа эрхэлдэг хүний оронд байсан бол ямар чадвараа хөгжүүлэх хэрэгтэй талаар байр сууриа илэрхийлэхэд нь багш чиглүүлсэн асуулт тавьж дэмжинэ.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 5

## ТӨЛӨВЛӨЛТИЙН ДАГУУ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭ БУСАДТАЙГАА ХУВААЛЦАХ

Энтерпрайзын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж түүндээ дүн шинжилгээ хийж суралцагчид юуг ойлгож мэдэж авсан, тулгарч буй бэрхшээлийг даван туулах талаар тэд ямар санаа олж авсан талаараа бусдадаа хуваалцахад нь багш чиглүүлнэ.

Үүнээс гадна мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх ажлыг төлөвлөлтийн дагуу гүйцэтгэхийн давуу болон сул талыг ярилцаж, цаашдаа аливаа ажлыг гүйцэтгэхэд төлөвлөгөөг хэрхэн хийж, ашиглах талаар багууд саналаа гаргана.

## ДАРААГИЙН СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ:

Дараагийн хичээлд багууд өөр өөрсдийн боловсруулж сайжруулсан төслөө үнэлэх учраас бэлэн болгосон байх шаардлагатай.

Ийм учраас багуудын **материаллаг нөөцийн менежерүүд** төслийг дараагийн хичээлд бэлтгэх шаардлагатай.



## СЭДЭВ 5: ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТАНДАЛТ

### Дэд сэдэв 5.3

## ТӨСЛИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ

### *Зориго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Төслийн шалгуурыг хэрхэн ашиглах талаарх мэдлэг
- Төсөл боловсруулах
- Багаар ажиллах, тунгаан бодох, харилцааны чадвар, өсөн дэвших сэтгэлгээ, энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Флипчартны цаас (багаар ажиллахдаа ашиглах)
- Маркер, бал, харандаа гэх мэт



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

120  
минут

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### НАДАД АСУУЛТ БАЙНА?

Багш суралцагчдад төсөл боловсруулж, жижиг дунд бизнесийг дэмжих тэтгэлгүүдэд оролцох боломжтой гэдгийг сануулна.

Суралцагчид төсөл бичих шаардлагатай ба түүнийг тодорхой шалгуурын дагуу үнэлж сонгон шалгаруулна гэдгийг тайлбарлана.

Дараагийн хуудсанд байгаа үнэлгээний шалгуурыг хэмжих үзүүлэлтүүд хэсгийг ашиглаарай.

Шалгуур бүр дээр суралцагчдын анхаарлыг хандуулан тодорхой хугацаанд уншуулсны дараа асуулт, хариултын хэсгийг эхэлнэ. Энэ удаад суралцагчдын хариултад багш, бусад шаардлагатай хүмүүс хариулна.

- Шалгуур нь гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга, хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллын дагуу хийгдсэн төсөв, цаг хугацаа, тоо хэмжээг тодорхойлоход ашиглагдана.
- Шалгуур нь үр дүнд чиглэсэн байх ба гүйцэтгэлийг чанартай хэрэгжүүлэх чиглэл болно.
- Шалгуур нь тодорхой, хэмжигдэхүйц, биелэх боломжтой, ач холбогдолтой, цаг хугацаатай байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2, 3

### ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Суралцагчид шалгууруудтай сайтар танилцсаны дараа багш багуудад шалгуур тус бүрийг илүү тодорхой болгон сайжруулах даалгавар өгнө.

### ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ШАЛГУУР БА ТЭДГЭЭРИЙГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШАЛГУУР	Хэмжих үзүүлэлт, баталгаажуулах арга хэрэгслүүдийн санаа
1. Төслийн санал нь өгөгдсөн загварын дагуу бүрэн боловсруулагдсан байх	<ul style="list-style-type: none"> <li>• SMART зарчим (Зорилго тодорхой, үр дүн хэмжигдэхүйц, үр дүнд хүрэхүйц, үйл ажиллагаанууд уялдаа холбоотой, цаг хугацаатай)</li> <li>• Төслийн загвар</li> <li>• Баримт бичгийн бүрдэл</li> </ul>
2. Төслийн санаа нь зорилтот орон нутгийн байгаль орчин, нийгэм, хүүхэд хамгаалалд ямар нэг сөрөг нөлөөгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>• Оролцогч байгууллагуудын ашигладаг зохицуулах журам, гарын авлага, стандартын төсөл дэх хэрэгжилтийн явцын дүгнэлт, тайлбар</li> <li>• Байгаль орчин, нийгэм, хүүхэд хамгааллын чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан</li> </ul>
3. Төслийн санааг хэрэгжүүлэх салбар нь тухайн орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцтэй байх	<ul style="list-style-type: none"> <li>• Тэргүүлэх чиглэлийн хүрээнд бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тоо</li> <li>• Ажлын байрны тоо</li> <li>• Орон нутгийн захиргаа, иргэд, олон нийтэд олгох татвар, хандив, дэмжлэг</li> </ul>
4. Тодорхой хэмжээний ашигтай ажиллах боломжтой байх	<ul style="list-style-type: none"> <li>• Ашигт үйл ажиллагааны төлөвлөгөө</li> <li>• Мөнгөн урсгалын төлөвлөгөө</li> </ul>
5. Бүтээлч, шинэлэг санаатай байх	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөл дэх уламжлалт бус, шинэ санааны тоо</li> <li>• Патент, зохиогчийн эрхийн тоо</li> <li>• Шинэ загвар, технологи, хамрах хүрээ</li> <li>• Бар код</li> <li>• Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа</li> </ul>
6. Хүний нөөцтэй байх (3-6 гишүүнтэй баг) Багийн гишүүдийн ажил үүрэг, хариуцлага тодорхой, жендэрийн тэгш хуваарилалт болон оролцоотой байх	<ul style="list-style-type: none"> <li>• Багийн гишүүдийн хүйсийн тэнцвэртэй байдал</li> <li>• Ажил үүргийн хуваариуд</li> <li>• Төслийн багийн бүтцийн зураглал</li> </ul>

<p>7. Багийн гишүүн бүр ESEL хичээлийн хөтөлбөрийг судалж, дүүргэсэн байх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчийн бүртгэл</li> <li>• Суралцагчийн хичээлийн төсөлт тайлан</li> </ul>
<p>8. Төслөө танилцуулах ур чадвар сайтай байх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийн үзүүлэн танилцуулгын бэлэн байдал</li> <li>• Цаг баримтлал</li> <li>• Санаагаа илэрхийлэх логик дараалал</li> <li>• Багийн гишүүдийн тэнцвэртэй бүрэн оролцоо, хоорондын мэдрэмжтэй харилцаа</li> <li>• Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварууд</li> </ul>
<p>9. Төсөл 6 сар тогтвортой хэрэгжих боломжтой байх, шаардлагатай нөөц тухайн орон нутагт байдаг, энэ нөөцийг сумын засаг захиргаа болон сургуулиар дамжуулан ашиглах боломжтой</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Нөөц бүрдүүлэх, ашиглах төлөвлөгөө</li> <li>• Эрсдэлийн төлөвлөгөө</li> <li>• Харилцааны төлөвлөгөө</li> <li>• Үйл ажиллагааны төлөвлөгөө</li> </ul>

Баг бүр шалгуурыг илүү тодорхой болгож сайжруулаад бусад багуудад танилцуулна.

Багш танилцуулсан дэлгэрэнгүй шалгуур тус бүрээс хамгийн сайн шалгуурыг сонгон самбарт бичиж тэмдэглэнэ. Самбарт бичсэн шалгуур тус бүрийг дүгнэх шалгуурыг дараах байдлаар бүгдээрээ нийлж боловсруулна.

ШАЛГУУР	ҮНЭЛГЭЭ		
	1 сул	2 дундаж	3 сайн

#### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4


### ТӨСЛИЙН ДАВУУ, СУЛ ТАЛЫГ ОЙЛГОЖ МЭДЭХ

Багууд боловсруулсан төслөө солилцож самбарт байгаа шалгуурын дагуу үнэлж дүгнэнэ. Үнэлж дүгнэсний дараа багууд өөр өөрсдийн төслийн үнэлгээ, дүнтэй танилцана.

Санал нийлэхгүй байгаа үнэлгээ, дүгнэлтийн талаар бие биеэсээ асууж хэлэлцүүлэг хийнэ.

Сургалтын төгсгөлд гарын авлагынхаа

**Сорил 8-г** ажиллахыг хүснэ.






## СЭДЭВ 5-ЫН ҮНЭЛГЭЭ

Сэдэв 5-ын үйл ажиллагаагаар эзэмшсэн суралцагчдын мэдлэг, чадвар, сэтгэлгээг дараах шалгуурын дагуу өөрсдөөр нь үнэлүүлээд үнэлгээний хуудсыг хурааж аваарай.

ШАЛГУУР	ТҮВШИН					
	1 Эзэмшээгүй	2	3	4	5	6 Маш сайн
1. Төслийг хэрэгжүүлэхэд оролцох талуудыг багаараа тодорхойлох						
2. Оролцогч талуудын оролцоо, төслөөс хүртэх үр ашгийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах						
3. Оролцогч талуудын байр сууринд өөрийгөө тавьж, юу хүсэхийг төсөөлөх						
4. Төслийг хэрэгжүүлэхэд тулгарч болох бэрхшээлийг бодит жишээнд тулгуурлан бусдадаа ойлгуулах						
5. Бэрхшээлийг даван гарах арга замыг олох, эрэл хайгуул хийх, бусдаас асуух, туршлага судлах						
6. Төслийг бусдад тайлбарлах, ятган үнэмшүүлэх						
7. Төслийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаарх мэдээллийг өөр өөр хүрээлэл, бүлгийн хүмүүстэй харилцах замаар, цуглуулах						
8. Цуглуулсан мэдээлэлд мэдээллийн технологи ашиглан дүн шинжилгээ хийх, үр дүнгийн шалтгааныг тайлбарлах						
9. Төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах олон хувилбарт санал гаргах						
10. Дээрх саналуудынхаа давуу болон сул талыг тайлбарлах						
11. Өгсөн шалгуурын дагуу төслийг үнэлэх						

(Авсан нийт оноо) \* 1.52 =  %



СЭДЭВ 6:

# ЭНТЕРПРАЙЗ ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ

Дэд сэдэв 6.1

ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ

## СЭДЭВ 6: ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ

### Дэд сэдэв 6.1

## ТӨСЛИЙГ САЙЖРУУЛАХ

### *Зөвшил*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Өгөгдсөн шалгуурын дагуу хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн төслөө сайжруулах
- Нөөцийн зохистой хуваарилалт, ашиглалт болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Бизнес төлөвлөлт, санхүүгийн мэдлэг, дижитал мэдлэг
- Бүтээлч байдал, инновац, тунгаан бодох, багаар ажиллах, харилцах чадвар болон санаачилгатай байх
- Тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэл, алдаанаас суралцах, хүчин чармайлт, шаргуу байх сэтгэлгээгээ хөгжүүлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Өөрийн боловсруулсан төсөл
- Сурагчдын ур чадвар эзэмшилтийн үнэлгээний хуудас



Сургалтын явцад багш суралцагчдыг ажиглан, тэдний ур чадвар, сэтгэл хөдлөлийн илэрхийллийг тэмдэглэн, нэмэлт стратегийг хэрэгжүүлнэ. Ажиглалтын хуудсыг энэхүү гарын авлагын үнэлгээ хэсгээс хуулбарлаж бэлтгэсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө сургалтын бэлтгэл бүрэн хангагдсан эсэхтэй холбоотой багийн менежерүүдтэй харилцахаа битгий мартаарай!

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### ТӨСЛӨӨ САЙЖРУУЛАХ

Багш суралцагчдад төслөө бусад багуудын үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн сайжруулах даалгавар өгнө. Энэ үйл ажиллагаанд суралцагчид сургалтын явцад эзэмшсэн мэдлэг, чадвар сэтгэлгээгээ хэрэглэхэд багш анхаарах шаардлагатай.



Танхимын  
сургалтын  
үйл  
ажиллагаа

80  
минут

Төслийг сайжруулахдаа шалгуурын үнэлгээний тайлбартай хүснэгтэд үндэслэн ажиллах ёстойг багш тайлбарлана.

Шалгуурт суурилсан үнэлгээний дагуу нэг бүрчлэн ажиллахдаа багийн гишүүд үүргийнхээ дагуу ажиллахдаа **Сэдэв 3** ба **4**-ийн агуулгыг эргэж санах ёстой тул багш төслийг хэрхэн боловсруулсан, төслийг боловсруулах үндэслэл юу болсон, төслийн бүтэц бүрд ямар агуулга туссан талаар дахин сэргээн ярилцана.

Суралцагчид багаараа төслийн аль хэсгийг яаж сайжруулах талаар санал нэгдэнэ.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ЭРГЭЦҮҮЛЭЛ: БИ ЦААШДАА ИЛҮҮ САЙН ХӨГЖИХИЙН ТУЛД ЮУ СУРАХ ВЭ?

Суралцагчид гарын авлагынхаа хувь хүний ур чадварын **Сорил 8**-ыг гүйцэтгэж шугамын дагуу тасалж багшид өгөхийг хүснэ.



Багш суралцагчдыг багаар ажиллуулахгүй бөгөөд энэ үед суралцагч бүр бие даан бодож тунгаах, эргэцүүлэх шаардлагатай.



СЭДЭВ 7:

# ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Дэд сэдэв 7.1

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЭХ

Дэд сэдэв 7.2

САНХҮҮЖИЛТ АВАХ ШААРДЛАГЫН ДАГУУ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ

Дэд сэдэв 7.3

ТӨСЛИЙН САНААГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ  
ТОДОРХОЙЛОХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ

## СЭДЭВ 7: ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

## Дэд сэдэв 7.1

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЭХ

*Зориго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Цахим мэдээлэл авах, сүлжээний талаарх ойлголт
- Учир шалтгаанд дүн шинжилгээ хийх
- Боломжийг илрүүлэх
- Илрүүлсэн боломжоо үнэлж дүгнэх, төсөөлөх
- Алдаанаасаа суралцах, өөрийн чадварыг сайжруулах, хөгжүүлэх
- Сэтгэл хөдлөлөө удирдах
- Өөрийгөө бодитой үнэлж дүгнэх
- Саад бэрхшээл тулгарсан ч санаачилга гаргаж, сэдэл тэмүүлэлтэй байх
- Эргэлзээтэй, тодорхойгүй нөхцөл байдлыг зохицуулах, эрсдэлийг удирдах

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Сургалтын төгсгөлийн тест
- Багаараа боловсруулж сайжруулсан төсөл
- Энтрепренер Seeds гарын авлага [https://savethechildren.mn/uploads/publications/Grant\\_Manual\\_for\\_Applicants.pdf](https://savethechildren.mn/uploads/publications/Grant_Manual_for_Applicants.pdf) тус линкээр татаж авах боломжтой
- Флипчартны цаас
- Маркер



### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### БИДНИЙ БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

Суралцагчдын баг болж сургалтын туршид боловсруулсан төслийн бичиг баримтыг файлаар эсвэл хэвлэсэн байдлаар хураан аваарай. Багшийн гарын авлагын суралцагчийн үнэлгээ бүлгийн “D.Төслийн үнэлгээ” хэсэгт өгсөн 10 шалгуур үзүүлэлтийн дагуу багуудын боловсруулсан төслийг 10 хүртэлх оноогоор үнэлээрэй. Багийн гишүүн бүрд адилхан оноо өгөх ёстойг анхаарна уу. Мөн энэ үнэлгээ нь төслийн бичиг баримтад өгч байгаа үнэлгээ гэхээс илүү тус сэдвийн хүрээнд тухайн багийн хийж бүтээсэн бүтээл, бүтээгдэхүүн талаас нь харж, бүхэлд нь өгч байгаа багшийн үнэлгээ юм. Багуудад өгсөн багшийн үнэлгээг дараагийн танхимын хичээлд суралцагчдад тараан өгч, хамтран ярилцах боломжийг олгоорой.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### БИДНИЙ СУРГАЛТЫН ҮР ДҮН

Суралцагчдаар суралцагчийн гарын авлагын хавсралт 6 дахь сургалтын төгсгөлийн тестийг бөглүүлж, хураан аваарай. Энэ тестийг суралцагч нэг бүр ганцаараа, харилцан ярилцалгүйгээр бөглөх ёстойг анхаарна уу. Тестийг бөглөх хугацаа 15 минут байна. Тестийн зөв хариултыг багшийн гарын авлагын суралцагчийн үнэлгээ бүлгийн C.Тест хэсгээс харж болно. Зөв хариултыг улаан өнгөөр тэмдэглэсэн болно.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

#### БИДНИЙ ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Тестийн үнэлгээний дараа сургалтын үр дүнгийн талаар ярилцаж, юу сурсан, гишүүдийн оролцоо ямар байсан, цаашид юун дээрээ илүү анхаарах, боловсруулсан төсөл нь амьдралд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэхийн тулд юу, юу хийх шаардлагатай болох талаар ярилцаж, нэгдсэн дүгнэлтэд хүрэхийг зөвлөөрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

#### ТӨСӨЛД ТАВИГДАХ ТУХАЙЛСАН ШААРДЛАГА

Энэ хичээлд ирэхээсээ өмнө Энтрепренер Seeds гарын авлагыг [https://savethechildren.mn/uploads/publications/Grant\\_Manual\\_for\\_Applicants.pdf](https://savethechildren.mn/uploads/publications/Grant_Manual_for_Applicants.pdf) тус линкээр татан авч танилцсан байна. Төслийг санхүүжүүлж байгаа байгууллагын тавих шаардлага харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлсэн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төслийн хүрээнд тэтгэлэг олгож байсан төслүүдэд ямар шаардлага тавьдаг байсан бэ? сэдэвт эргэцүүлэл, хэлэлцүүлэг баг дотроо хийнэ. (Багшийн гарын авлагын 5-р хавсралт)

Багийн ажлын үеэр суралцагчдыг гарын авлагын 3-р хавсралтад байгаа Хүүхдийг ивээх сангаас (ХИС) төслийн зарим шалгуур үзүүлэлтийн жишээтэй танилцахыг анхааруулна.

**ҮЙЛ АЖИЛЛАГАА 5****ШИНЭ НӨХЦӨЛД ТӨСЛӨӨ ЭРГЭН ДҮГНЭХ**

Багш төсөлд өгсөн үнэлгээгээ багуудад тарааж өгнө. Багшийн үнэлгээ болон өмнөх “Үйл ажиллагаа 4” дээр хийсэн эргэцүүлэл дээрээ үндэслэн баг тус бүр төслөө хэрэгжих боломжтой эсэх дээр ярилцаж, дүгнэлт гаргана. Үүний дараа бусад багуудад танилцуулж, харилцан ярилцаж, дараагийн алхмаа тодорхойлно. Энэ нь төслөө улам сайжруулах, эсвэл шинээр төсөл бичихийн аль нэг байна.





## СЭДЭВ 7: ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

## Дэд сэдэв 7.2

САНХҮҮЖИЛТ АВАХ ШААРДЛАГЫН ДАГУУ  
ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТӨСЛИЙН  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ*Зөвшилцө*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл
- Хязгаарлагдмал нөөцийг оновчтой, үр ашигтайгаар ашиглах
- Бусад оролцогчдыг татан оролцуулах арга, туршлага
- Шинэ санаа олох, эрэлхийлэх
- Аливаа зүйлийг олон талын өнцгөөс харах
- Зөрчлийг бүтээлчээр зөвшилцөх
- Шинэ санаа олж турших
- Бэрхшээлийг боломж болгон хөгжүүлэх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Сургалтын төгсгөлийн сорил
- Төслийн санхүүжилт, тэтгэлэг, зээл олгодог байгууллагуудын болон тэтгэлэг, зээлийн танилцуулга хуудас
- Бичил төслүүдийн амжилтын түүх -26 төрлийн видео <https://www.youtube.com/watch?v=kdfd4bwXK-8&list=PLF-fUz8-4CDUOhw0DrxQWBtf-WhSrgp85Xe> тус линкээр орж “Бичил төслийн амжилтын түүх” гэсэн 26 төрлийн видеонаас өөрийн сонирхсон аймаг, сумын бичил төслийн видеог сонгон үзэж болно.

Багш төсөл санхүүжүүлэх янз бүрийн боломжууд байдаг талаар суралцагчдад тайлбарлаж өгнө. Төслийг тэтгэлгээр болон зээлээр санхүүжүүлж болдог. Хэрэв таны боловсруулсан бизнесийн санаа санхүүгийн тэтгэлэг олгодог байгууллагуудын шаардлагад нийцэж байвал, нийцүүлэх боломжтой бол санхүүгийн тэтгэлэг буюу буцаан тушаах шаардлагагүй санхүүгийн бүтээгдэхүүн судалж олох нь эрсдэл багатай. Харин үр өгөөж, ашиг өндөртэй ажиллах боломжтой төсөл гэж үзэж байвал зээл авч болно. Ингэхдээ зээл нь үндсэн болон хүүгийн төлбөрийг тодорхой хуваарийн дагуу буцаан төлөх ёстойг тооцож, төслийн бичиг баримтдаа нэг үндсэн бүрэлдэхүүн болгон тусгах шаардлагатай. Мөн тэр хуваарийнхаа дагуу буцаан төлөх тул санхүүгийн хувьд эрсдэл өндөртэй гэдгийг суралцагчдад тайлбарлаж ойлгуулна.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

#### ТӨСӨЛД САНХҮҮЖИЛТ ОЛГОДОГ ЯМАР БАЙГУУЛЛАГУУД МЭДЭХ ВЭ?

Тус асуултыг ангийн нийт суралцагчдаас асууж, оюуны зураглалын арга ашиглан аль болох олон төрлийн байгууллагын жагсаалт гаргаж, бүлэглэж ангилна. Магадгүй төрийн, төрийн бус, банк санхүүгийн болон төсөл хөтөлбөрийн байгууллага, төрийн болон орон нутгийн сан гэх мэтчилэн олон ангилал гарч болно. Дараа нь ангилал тус бүрийн нийтлэг шаардлага ямар байж болох талаар санал солилцож, хэлэлцээрэй.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

#### ТӨСӨЛД ТАВИХ ТУХАЙН БАЙГУУЛЛАГЫН ШАЛГУУР, ШААРДЛАГА

Суралцагчид төслийг санхүүжүүлэх боломжтой байгууллага, хөтөлбөрийн талаар мэдээлэл цуглуулна. Ингэхдээ төсөлд ямар шалгуур тавьж, шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулдаг талаарх мэдээллийг бүрэн дүүрэн олж авахад анхаарах хэрэгтэй. Цуглуулсан мэдээлэлд тулгуурлан баг тус бүр 1-2 байгууллага, хөтөлбөрийн шалгуурт нийцсэн төсөл хэрхэн боловсруулах, сайжруулах талаар хэлэлцэж, дүгнэлтээ бусад багийнханд танилцуулна. Энэ үйл ажиллагааны төгсгөлд суралцагчид ямар байгууллага, хөтөлбөрөөс санхүүжилт авахаар хандах боломжтой талаар ойлголт, дүгнэлттэй болсон байна.



Танхимын  
бус  
сургалтын  
үйл  
ажиллагаа

120  
минут

**ҮЙЛ АЖИЛЛАГАА 3****ШАЛГУУРЫН ДАГУУ ШИНЭ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ**

Суралцагчид санхүүжилт авахаар хандахыг хүсэж байгаа байгууллага, хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн шийдвэр гаргаж, шинэ төсөл боловсруулах ажлаа эхэлнэ. Ингэхдээ дараах шийдлийг гаргана. Үүнд:

- Багаа шинэчлэн байгуулах уу? Хэрэв тийм бол ХИС-ийн төслийн хүрээнд Энтерпрайз баг бүрдүүлэхэд анхаарах асуудлуудыг эргэн харахыг сануулаарай.
- Багш, ментороос зөвлөгөө авах хэрэгтэй юу? Хэрэв тийм бол суралцагчийн гарын авлагын 20-р хүснэгтийн дагуу зөвлөгөө авах багш, менторийг хуваарийг гаргахыг зөвлөөрэй.
- Шинэ төсөл боловсруулж бэлтгэх ажлын төлөвлөгөөг Суралцагчийн гарын авлагын 21-р хүснэгтийн дагуу хийхийг суралцагчдад сануулна.
- Суралцагчид санхүүжилт авах шаардлагын дагуу төслөө боловсруулна.

**ҮЙЛ АЖИЛЛАГАА 4****ТӨСЛИЙН УРАЛДААНД ОРОЛЦОХ**

Төслийн уралдаанд хэрхэн оролцох талаар багаараа ярилцаж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахыг суралцагчдад зөвлөнө. Хэрэв питч зохион байгуулж шалгаруулдаг бол питчэд хэрхэн бэлтгэх, оролцох талаар мэдээлэл өгнө. Питч зохион байгуулж, шалгаруулалт явуулдаг олон хөтөлбөр, уралдаан тэмцээн байдгын нэг нь ХИС-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдаан” юм. 2024 оны уралдааны зарлалыг доорх линкээс үзэж болно. <https://savethechildren.mn/?p=16976&lang=mn>

**ҮЙЛ АЖИЛАГАА 5****НЭГТГЭН ДҮГНЭХ**

Багш суралцагчдыг гарын авлагын хувь хүний ур чадварын Сорил 9-ыг гүйцэтгэж, багшид өгөхийг хүснэ.

Багш суралцагчдыг багаар ажиллуулахгүй бөгөөд энэ үед суралцагч бүр бие даан бодож тунгаах, эргэцүүлэх шаардлагатай.



## СЭДЭВ 7: ШИНЭ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

## Дэд сэдэв 7.3

ТӨСЛИЙН САНААГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ  
ТОДОРХОЙЛОХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ*Зорилго*

Энэ сургалтаар суралцагчдын дараах мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой. Үүнд:

- Санхүүгийн ухаалаг шийдвэр гаргах
- Бизнес эхлэх, хөгжүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай мэдлэг
- Ёс зүйтэй шийдвэр гаргах
- Үр дагаврыг тооцоолон ёс зүйтэй шийдвэр гаргах
- Учир шалтгаанд дүгнэлт хийх
- Бусдын санаа зөвлөмжийг хүлээн авах, бусдад санал зөвлөгөө өгөх
- Алсын хараагаа тодорхойлох
- Тууштай байдал
- Санаачилгатай байх

Сургалтад дараах хэрэглэгдэхүүн, материал ашиглана. Үүнд:

- Суралцагчийн гарын авлага
- Төслийн санхүүжилт, тэтгэлэг, зээл олгодог байгууллагуудын болон тэтгэлэг, зээлийн танилцуулга хуудас

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

### **ЭРГЭЦҮҮЛЭЛ: БИ ЦААШДАА ИЛҮҮ САЙН ХӨГЖИХИЙН ТУЛД ЮУ СУРАХ ВЭ?**

Багш Сорил 1 болон Сорил 9-ийн харьцуулсан дүнг суралцагч нэг бүрд нууцлалтайгаар танилцуулна. Суралцагчид дор бүрнээ хувь хүний ур чадвараа илүү сайн хөгжүүлэхийн тулд цаашдаа юу сурах хэрэгтэйгээ сургалтын үйл явцтайгаа уялдуулан эргэцүүлэн бодож, өөрөө өөртөө төлөвлөлт хийнэ. Суралцагч хүсвэл, бусад хүүхдүүдийн өмнө өөрийнхөө эргэцүүллийн талаар питч хийж болно.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

### **БИ ИРЭЭДҮЙДЭЭ ИТГЭЛТЭЙ**

Суралцагчдад өөрийн бизнесийн санаа, төсөл, хувь хүний ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийн ач холбогдлыг сануулна. Мөн бизнесийн төслөө хэрэгжүүлэх боломж байгаа талаар тайлбарлаж, цаашид тасралтгүй хөгжих, өөрийн удирдлагатай суралцах талаар хэлэлцэж, ирээдүйн ажил, амьдралын замналаа тодорхойлох талаар ярилцаарай.





# XABC PART

## ХАВСРАЛТ 1.

### ӨӨРИЙГӨӨ ТАНЬЖ МЭДЭХ ТУХАЙ

**"ХИЙЖ БАЙГАА ЗҮЙЛДЭЭ ДУРТАЙ, СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙХ НЬ  
АМЖИЛТ ГАРГАХ, СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙХЫН ҮНДЭС. ЭНЭ НЬ ӨӨРИЙГӨӨ ТАНИН  
МЭДЭХЭЭС ЭХЭЛНЭ"**

Хэрэв та хаашаа явахыг хүсэж байгаагаа мэдэхгүй бол аль зүгт явах вэ гэдэг нь тийм ч чухал биш. Үүнтэй адил тодорхой чиглэл байхгүй бол та нэг ажлаас нөгөө ажилд бөмбөг шиг л ойж буусаар байх болно. Зарим хүмүүс хийж байгаа зүйлдээ дургүй байдаг нь тэд юу сонирхдог, ямар төрөлхийн ур чадвартай бас юуг эрхэмлэдэг гэдэгтээ ач холбогдол өгч байгаагүйг илтгэдэг. Тэд хийх зүйлээ сонгохдоо зүгээр л биед амар, мөнгө их олох боломжтой болохоор эсвэл найзыгаа, ахыгаа, эгчийгээ, ээж аавыгаа дуурайгаад, эсвэл хэн нэг нь тухайн ажлыг өөрт тохирно гэж хэлсэн учраас л сонгосон байдаг. Үр дүнд нь тэд хийж буй зүйлдээ дур хүсэлгүй, сэтгэл ханамжгүй, амжилт гаргаж чаддаггүй нэгэн болдог. Ийм хүмүүсийн ихэнх нь өөртөө цаг гаргаад юу хүсдэг, сонирхдог болохоо эргэцүүлээгүй байдаг. Магадгүй тэдэнд ийм боломж ч байгаагүй байх.

Хийх дуртай зүйлээ таньж мэднэ гэдэг нь өөрийгөө таньж мэдэхийн эхлэл юм. Зарим хүмүүс амьдралын нугачаанд юу хүсдэг, сонирхдог болохоо санахгүй эсвэл огт мэдэхгүй болсон байж болно. Гэхдээ хүн бүрд хүсдэг, сонирхдог, хийх дуртай зүйл гэж байдаг. Ямар ч ажил хийдэг байлаа хүн хийж байгаа зүйлдээ дуртай л бол хүсэл тэмүүлэлтэй, шаргуу, сэтгэл хангалуун байж амжилтад хүрч чаддаг. Ажил, амьдралын АМЖИЛТ тухайн хүний ДАВУУ ТАЛААС шалтгаалдаг. Сонирхлоо тодорхойлох, чадвараа нээж илрүүлэх гэдэг нь давуу талаа таньж мэдэж байгаа хэрэг. Таны сонирхол, чадвар хоёр нийцтэй байвал энэ таны жинхэнэ ДАВУУ ТАЛ болно.

## ХАВСРАЛТ 2.

## ЦАГ ТӨЛӨВЛӨЛТ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Цаг төлөвлөлт хүн бүхэнд чухал. Тэр дундаа энтрепренершип үйл ажиллагаа хэрэгжүүлж буй хүмүүст амин чухал ур чадвар. Та цагаа хэр зөв, оновчтой төлөвлөснөөс үйл ажиллагааны хурд шалтгаалдаг. Ихэнх энтрепренерийн нийтлэг алдаа нь тэд өөрийн чадавх, хүч, цагаас давсан ажил үүрэгтэй байх гэж оролддог явдал. Тэд хэт их ажил аваад түүнийгээ шахуу хугацаанд гүйцэтгэх гэж оролддог. Сүүлдээ аль ч ажлаа чанартай, сайн хийж чадалгүй цаашдын боломжоо алддаг. Энтрепренершип ертөнцийн хүмүүсийн алтан дүрэм нь **ЦАГ БОЛ АЛТ**. Цагаа хэр зэрэг оновчтой, зөв төлөвлөх нь хэр зэрэг орлого олохтой хамааралтай гэж тэд үздэг.

Цагийн төлөвлөлт гэдэг нь зорилгодоо хүрэхийн тулд зөв үйл ажиллагаанд зөв цаг зарцуулна гэсэн үг. Цаг оновчтой төлөвлөх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Энэ нь бүтээмжийг нэмэгдүүлдэг. Цаг зөв төлөвлөж, удирдах нь өдөр тутмын үйл ажиллагаа илүү бүтээмжтэй байх боломжийг олгодог. Ингэснээр та дэвшүүлсэн зорилгодоо өдөр өдрөөр алхам, алхмаар хүрэх боломжтой болно.
2. Энэ нь танд үйл ажиллагаануудаа эрэмбэлж, хамгийн чухлыг эхэлж гүйцэтгэх боломж олгодог. Та ажлаа илүү системтэй зохион байгуулж, хамгийн эхлээд аль ажлыг гүйцэтгэх вэ? гэдгийг хэлж өгнө.
3. Энэ нь ажлын ёс зүйд их чухал. Багийн гишүүд зөв ёс суртахуунтай байхад хэрэгтэй ба үр дүнд нь байгууллагын бизнес төлөвлөлтөд эерэг үр дүнг авчирдаг.
4. Энэ нь стрессийг бууруулдаг. Нэг ажил дээр дахин дахин ажиллах, алдаа гаргахаас сэргийлэх боломжтой ба ажлаа цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд хэрэгтэй.
5. Ажил үүргээ оновчтой хуваарилах боломжийг олгоно. Багийн гишүүдийн ажил үүргийг зөв хуваарилахад тустай учраас багийн дотор итгэл үнэмшил, эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд тустай.
6. Зорилгодоо чиглэсэн байхад тустай. Цагаа зөв төлөвлөснөөр анхаарал, хүчин чармайлтаа зорилготой холбоотой үйл ажиллагаанд хандуулах, ажлын тогтсон стандарттай байхад тусална. Ингэснээр та өөрийн эрхгүй зорилгодоо хүрч чадна.




# ЭНТРЕПРЕНЕРШИП ОЙЛГОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энтрепренершип нь аж үйлдвэрийн эринээс мэдээллийн эринд шилжих үед дэлгэрсэн шинэ санааг хөдөлмөрийн үнэ цэнд хувиргах үйл явц байдлаар илэрхийлдэг, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн нэг юм. Энгийнээр, энтрепренершип гэдэг нь ашиг олох замаар бизнес эрхлэх эсвэл нийгмийн сайн сайхны төлөө тодорхой зохион байгуулалтайгаар ашгийн бус үйл ажиллагаа эрхлэх үйл явц юм. Өргөн хүрээнд, энтрепренершип нь хөрөнгө оруулалтаараа зах зээлийн нөхцөлд хамгийн өндөр орлого авчрах бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг бий болгох, явуулахад оролцох үйл явц юм. Энтрепренер гэдэг нь латин гаралтай франц үг юм. Entre (дунд, хооронд) ба Prendre (авах) гэсэн хоёр үгнээс бүрддэг.<sup>4</sup> Утгачлан орчуулбал, дундын зуучлал гэсэн утгыг илэрхийлдэг. Тиймээс ч түүхэнд Ази, Европ тив хоорондын торгоны замын худалдаа эрхлэгчид тухайн он цагийн энтрепренерүүд байсныг зарим түүхч судлаачид тэмдэглэсэн байдаг. 1723 онд Жак дэ Бруслонс гэх хүн өөрийн зохиосон Dictionnaire Universel de Commerce худалдааны толь бичигт анх энэ үгийг оруулсан нь түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. XIX зууны үед франц хэлнээс англи хэл рүү нэвтэрч орсон. Тухайн үед Англид адал явдал хайгчдыг энтрепренер гэж нэрлэдэг байжээ. Харин Германд XX зууны дунд хүртэл гар урлаач, ур дархчуудад энтрепренерийн тусгай зөвшөөрөл олгодог байжээ. Мөн санскрит хэлэнд өөрийгөө сэдэлжүүлэх гэсэн утга бүхий anthaṛgna гэх ойролцоо дуудлагатай үг байдаг байна. Өнөө цагт гарааны бизнес, санаачилга зэрэг ойлголттой хамт хоршил байдлаар хэрэглэгдэж байна. Энтрепренершипийн хүрээнд хамгийн өргөн ашиглагдаг дараах **түгээмэл үг хэллэгүүд** байдаг.

## ТҮГЭЭМЭЛ ҮГ ХЭЛЛЭГҮҮД

- Гарааны бизнес
- Бүтээлч сэтгэлгээ
- Шинэ бизнес
- Шинэ зах зээл
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Шинэлэг
- Боломжуудыг эрэлхийлэх
- Эрсдэлийг үүрэх, даван туулах
- Тодорхойгүй нөхцөл байдал
- Ашиг олох
- Нийгэмд оруулах хувь нэмэр
- Үйлдвэрлэл, нөөц боломж
- Удирдлага, зохион байгуулалт
- Үнэ цэнийг бүтээх
- Өсөх, хөгжих зорилго
- Овсгоо, самбаа
- Шийдвэр гаргалт
- Өөрчлөлтийг бий болгох
- Эзэмшил
- Хувь эзэмшигч
- Хариуцлага, эрх бүхий
- Стратеги



Хүн бүр өөрсдийн мөрөөдлийн ажилтай болохыг хүсдэг боловч энтрепренер сэтгэлгээ дутмаг тохиолдолд хэзээ ч зорилгодоо бүрэн хүрдэггүй. Энтрепренер мөн чанар ихэнхдээ хөрөнгө оруулагч, ажил олгогч, үйлдвэрийн эзэн, хувь эзэмшигч, манлайлагч, удирдагч, захирал, менежерүүдэд байдаг гэсэн буруу ойлголт бий. Энэ бол төрөлхийн авьяас биш бөгөөд хөгжүүлэх боломжтой чадамж юм.

Энтрепренерүүдийн суурь онцлогууд нийгмийн эрэлт, хэрэгцээ болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний санааг гаргах, бүтээх, үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэхэд гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, шаардлагатай байгалийн баялаг (түүхий эд), хөрөнгө, ажиллах хүчийг нэгтгэн нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өндөр ашигтай бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах юм. Үүнтэй холбоотойгоор, дараах нийтлэг онцлогуудыг олж харж болно.

Үүнд:

- ✓ Зохион байгуулах ур чадвартай байх
- ✓ Бэлэн нөөц, боломжуудыг үнэлэх
- ✓ Эрсдэл үүрэх
- ✓ Боломжуудыг харах, үнэлэх
- ✓ Цаг, зардалтай судалгаанаас илүүтэй хүмүүстэй шууд уулзах, ажиглах
- ✓ Үнэ цэнийг бүтээх
- ✓ Тоглоомын дүрмийг эхнээс нь зохиох, хэрэгжүүлэх

## Энтрепренерүүдийн үндсэн үүргүүд:<sup>5</sup>

- ✓ Үйлдвэрлэлийг зохион байгуулах, хэрэгжүүлэх
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх
- ✓ Ажлын байр бий болгох
- ✓ Шинэ зах зээлийг хөгжүүлэх
- ✓ Борлуулалт, маркетингийн шинэлэг хандлагыг нэвтрүүлэх
- ✓ Хөрөнгө босгох



Энтерпренершипийн талаарх түүхэн ойлголт, тодорхойлолтууд <sup>6</sup>

ЦАГ ҮЕ	ЭРДЭМТЭД	ТОДОРХОЙЛОЛТ
МЭ эхэн үе	Тодорхойгүй	Амьдралын гол суурь нөөц, боломжуудыг эрэн хайгч нэгэн
Дундад зуун	Тодорхойгүй	Томоохон үйлдвэрийн эзэн
17-р зуун	Тодорхойгүй	Төр, засагтай тодорхой тогтмол үнээр гэрээ байгуулагч, ашиг, алдагдлыг өөрөө хариуцна.
1725	<b>Richard Cantillon</b>	Хөрөнгөтөн эзнээс илүүтэй эрсдэлийг үүрэгч
1876	<b>Jean Baptiste Say</b>	Зөвхөн хөрөнгөтөн бус, үйл ажиллагаанаас ашиг ологч
1903	<b>Francis Walker</b>	Хөрөнгө оруулагч, төслийн удирдагч
1934	<b>Joseph Schumpeter</b>	Шинэлэг, инновац, шинэ технологи хөгжүүлэгч
1961	<b>David McClelland</b>	Аливаа эрсдэлийг үүрэгч
1964	<b>Peter Drucker</b>	Боломжуудыг хамгийн өндөр түвшинд ашиглагч
1975	<b>Albert Shapiro</b>	Нийгэм, эдийн засгийн өнцгөөс санаачлагч, амжилтгүй байх эрсдэлийг туулагч
1980	<b>Karl Vesper</b>	Эдийн засаг, улс төр, сэтгэл зүй, бизнесийн салбарын энтерпренерүүд
1983	<b>Gifford Pinchot</b>	Интрапренер буюу байгууллага доторх энтерпренерүүд
1985	<b>Robert Hisrich</b>	Цаг, эрч хүч, ур чадвараа ашиглан үнэ цэнийг бүтээгч, хариуд нь биет болон биет бус үр өгөөжийг хүртэгч
1995	<b>Peter Drucker</b>	Гарт байгаа бэлэн нөөцийг ашиглан хамгийн бага бүтээмжтэй үйлдвэрлэлийг өндөр бүтээмж уруу хөрвүүлэгч, үүнийг тогтвортойгоор хөгжүүлэгч
1999	<b>Jeffrey Timmons</b>	Орчин үеийн сэтгэлгээ, зан авиртай, үнэнч, шударга байдлыг цогцлоогч
2001	<b>Phillip A.Wickham</b>	Тодорхой төслийг өөрийн нөөц, боломж, мэдлэг, туршлагаар хөгжүүлэгч
2002	<b>G. Brenkert</b>	Зах зээлийн эдийн засгийн гол тоглогч
2003	<b>L.W. Busenitze</b>	Эдийн засгийг сайжруулахад гол үүрэг гүйцэтгэгч
2007	<b>Paul N. Bloom &amp; Gregory Dees</b>	Энтерпренершипийн эко тогтолцоог тодорхойлогч
2007	<b>Global Entrepreneurship Monitor</b>	Энтерпренерүүд бол төрөлхийн биш

<sup>6</sup> Social Entrepreneurship-False Premises and Dangerous Forebodings, Beth Cook, Chris Dodds, and William Mitchell, Australian Journal of Social Issues, Vol. 38, No. 1, Feb 2003, p. 58-72

### ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН ТӨРЛҮҮД

Энтрепренершип нь үүсгэн байгуулах, хэлбэрт оруулах, зохион байгуулах, хөгжүүлэх, татан буулгах зэрэг үе шатнаасаа хамааран олон төрөлтэй. Түүнчлэн нөхцөл байдал, хандлага, чиглэл, загвар болон зохион байгуулалтын талаас нь төрөлжүүлж болно. Энтрепренершипийн нэлээд төрлүүд байдаг бөгөөд тэдгээрээс түгээмэл төрлүүдийг дор тайлбарлая.

#### • Хараат бус энтрепренершип

Хамгийн түгээмэл бөгөөд хэн нэгний нөлөөлөлгүй хэрэгжих үйл явц<sup>7</sup>. Өөрсдийн авьяас, ур чадвар болон мэргэжлийн давуу талыг ашиглан мөрөөдлөө бодит болгохын төлөө бусдаас хамааралгүйгээр, бие даан ажиллаж буй энтрепренерүүдийг дурдаж болно.

#### • Солопренершип

Бусдын дэмжлэг, хамтын оролцоогүйгээр зөвхөн өөрөө гэх үзэл дор ганцаараа үйл хэргийг явуулж буй энтрепренершипийн төрөл. Зөвхөн богино хугацаанд амжилт олж болох ч, урт хугацаандаа явцгүй гэдэг нь олон бодит жишээгээр нотлогддог.

#### • Эмэгтэй энтрепренершип

Эмэгтэй энтрепренерүүд ихэвчлэн боловсрол, зөвлөх үйлчилгээ, олон нийтийн харилцаа зэрэг нийгмийн үйлчилгээний салбарт ажилладаг.<sup>8</sup> Түүнчлэн өрхийн түвшинд, хүүхдүүдээ өсгөх явцдаа бизнестэй болох нь түгээмэл.

#### • Академик энтрепренершип

Их, дээд сургуулиуд болон коллежууд өөрсдийн хөрөнгийн эх үүсвэрийг төрөлжүүлэх үүднээс энтрепренершип төслүүдийг хэрэгжүүлэх нь элбэг болсон. АНУ-д гэхэд академик байгууллагууд улсын татаасыг хангалтгүй гэж үзэн 1990-ээд оноос эхлэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд гүйцэтгэх, лабораторийн туршилтууд хийх, инновацын төв нээх, зах зээлийн эрэлттэй ангиуд нээх замаар нэмэлт орлогын эх үүсвэрүүдийг бүрдүүлдэг болсон.<sup>7</sup> Энэ нь оюутнуудыг ирээдүйн энтрепренер болоход чухал үүрэг гүйцэтгэж буйг Facebook, Google, Youtube зэрэг төслүүдийн өнөөгийн хөгжлөөс ойлгож болно.

• **Интрапренершип**

Интрапренерүүд аль нэг байгууллагын ажилтнууд бөгөөд тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү өндөр ашигтай, зардал багатай болгоход шинэлэг санаагаараа багийн хамт олноо удирдан, бүхий л эрсдэл, аюул эсвэл ашиг, алдагдлын хариуцлагыг бүрэн үүрдэг. Анх энэ ойлголтын суурь санаа нь 1978 онд Жиффорд Пинчотын бичсэн "Байгууллагын доторх Энтрепренершип" нэртэй бүтээлд дурдагдсан байдаг бөгөөд энэхүү нэр томъёо нь 1985 онд "Intrapreneuring" номд тодорхойлогдсон байна.<sup>8</sup> Интрапренерүүд дараах 4 онцлогийг агуулдаг.

**1.** Интрапренер гэдэг нь бизнес эрхлэгч шинээр эхлүүлэхийн тулд хийдэг зүйлсийг мөн адил хийж буй компанийн инновацлаг ажилчид юм. Интрапренерүүд бол талхыг өсгөдөг хөрөнгө юм. Хэрэв та илүү их инновацыг хүсэж байвал үүнийг хийх цорын ганц арга зам бол дотоод ажилчдаа таних, хөгжүүлэх, итгэх, тэдэнд хүч өгөх явдал юм. Байгууллага нь ажилчдаа цэцэглэн хөгжихөд нь зориулж санаачлах, сонгох, бүтээх, удирдах, орчныг бүрдүүлэх талаар мэддэг байх ёстой.

**2.** Интрапренерүүд бол мөрөөддөг хүмүүс. Тэд зөвхөн санаа дэвшүүлдэггүй бөгөөд тэдний гол үүрэг бол санаа бодлыг бодит байдал болгох явдал юм. Үнэн хэрэгтээ бүх ажилчид зохион бүтээгч биш боловч тэд үргэлж шинэ санааг хэрэгжүүлэгч байдаг. Энэ тохиолдолд тэдний мөрөөдөл нь санаагаа дэвшүүлэх биш харин ашигтай бодит санаачилгыг хэрэгжүүлэхийг мөрөөдөх явдал юм.

1983 онд ЗМ-ийн дарга Лью Лер хэлэхдээ: Олон жилийн турш ЗМ корпорацийн гол дүрэм нь удирдлагын зүгээс залуу ажилчдын шинэлэг санаан дээр хамтран ажиллахыг уриалах зорилготой байсан. Хэрэв тэд амжилтад хүрвэл ЗМ-ийн шүхэр дор өөрсдийн шинэ бизнесийг эхлүүлж, эрхэлж чадна. Бизнес эрхлэх хандлага нь ЗМ-ийн хувьд хажуу тал биш юм. Энэ бол өсөлтийг бий болгох зүрх сэтгэл юм. Тэд шинэ санаагаа бизнес төлөвлөгөө болгохын тулд санаа бодлын уралдаан, тэр ч байтугай хурдасгуур ажиллуулдаг, дараа нь хэрэгжүүлэх санааг өөр багийнханд шилжүүлдэг. Учир нь сайн санаа, тэр ч байтугай сайн төлөвлөгөөг амжилттай бодит ажил хэрэг болгохын тулд чадварлаг, мэргэжлийн, туршлагатай мэргэжилтнүүд хэрэгтэй.



<sup>8</sup> Starting and Managing the Small Business, Arthur H. Kuriloff, John M. Hemphil, John Hemphil Jr., and Douglas Cloud, International Edition, McGraw-Hill Education, 1993, p. 36

<sup>9</sup> Exploring the Dimensions of Entrepreneurial Community Colleges, Diane Carol Rothman, University of Minnesota, 2007, p. 142

<sup>10</sup> Four Definitions for the Intrapreneurship, Gifford Pinchot, <https://www.pinchot.com/2017/10/four-definitions-for-the-intrapreneur.html>, 2020 оны 9 сарын байдлаар

**3.** Интрапренерүүд нь сайн дураараа томилогдсон шинэ санааны ерөнхий менежер юм. Хэрэв та ямар нэгэн санаанд дуртай бол интрапренершип эхлүүлэх нь түүнийг урагшлуулахын тулд ямар нэгэн зүйл хийхийг хэлнэ. Өөр хэн нэгэн тэдний өмнөөс хариуцлага хүлээхгүй. Тэд сайн дурынхны багийг бүрдүүлдэг. Энэ санааг зах зээл дээр туршиж үзэх хямд аргуудыг хайж олох, бүтээгдэхүүн, үйлчилгээний анхны хувилбарыг бүтээх, макет эсвэл статик дэлгэцийн зураг авалтаас эхлээд тэд хурдан бөгөөд хялбар зүйлийг бий болгодог. Ерөнхий менежерийн хувьд тэд загварыг хэрэглэгчдэдээ үзүүлж, туршиж, сайжруулж шуурхай ажилладаг. Удирдлагын дэмжлэгийг авахын тулд тэд боломжит ивээн тэтгэгчид болон туршилтын үйлчлүүлэгчдээ ч аль хэдийн олсон байдаг.

**4.** Интрапренерүүд бол бизнесийн үйл ажиллагааг сайн сайхан болгох хүчийг өөрчлөх өөрчлөлтийн хөдөлгөгч хүч юм. Дэлхийг сайжруулж буй инновацад анхаарлаа хандуулдаг тэд ихэвчлэн тасалдсан инновац өндөр ашигтай шинэ бизнес эрхлэхэд хүргэдэг. Гэхдээ шинэ санаачилгынхаа үр нөлөөг дэлхийн хүн төрөлхтөн, байгаль эх дэлхийд илүү эерэг байдлаар нэмэгдүүлэхэд чиглүүлдэг.

## Уламжлалт удирдагч, энтрепренер болон интрапренер хоорондын харьцуулалт<sup>9</sup>

	УЛАМЖЛАЛТ УДИРДАГЧИД	ЭНТРЕПРЕНЕРҮҮД	ИНТРАПРЕНЕРҮҮД
<b>Үндсэн сэдэл</b>	Албан тушаал ахих, одон шагнал авах	Хараат бус, боломж бүтээх, мөнгө олох	Хараат бус, байгууллагын шагнал авах
<b>Хугацаа</b>	Богино хугацааны	Дунд болон урт хугацааных, есөх, хөгжих, тогтворжих хүртэл 5-10 жилийн хугацаатай	Байгууллагын ажлын төлөвлөгөөт хугацаатай уялдаатай
<b>Үүрэгт ажил</b>	Шууд оролцоо гэхээс илүүтэй байгууллагыг төлөөлөх, хянах үүрэгтэй	Аливаа ажлуудад шууд оролцоотой	Байгууллагыг төлөөлөхөөс илүүтэй төслүүдэд шууд оролцоотой
<b>Эрсдэл</b>	Маш хянуур	Эрсдэлийг тооцоологч, даван туулагч	Эрсдэлийг тооцоологч, даван туулагч
<b>Зэрэг, дэв</b>	Чухал	Чухал биш	Бие даан ажиллах сонирхол
<b>Алдаа, уналт</b>	Алдаанаас зугтагч	Алдааг хүлээн зөвшөөрөгч	Бэлэн болох хүртлээ эрсдэлтэй алхмаас хол
<b>Шийдвэр гаргалт</b>	Шийдвэрийг бие даан гаргадаггүй	Мөрөөдлийн шийдвэрүүд гаргах хандлагатай	Бусдаар хүлээн зөвшөөрүүлэх сонирхолтой
<b>Хэнд зориулагдсан</b>	Бусдыг сэтгэл хангалуун байлгах	Өөрийгөө болон хамтрагчид, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдээ сэтгэл хангалуун байлгах	Өөрийгөө болон байгууллагын захирлууд, санхүүжүүлэгчид, хэрэглэгчдээ сэтгэл хангалуун байлгах
<b>Гэр бүлийн нөлөө</b>	Гэр бүлийн зүгээс баталгаатай, тогтмол, өсөн нэмэгдэх орлогыг шаарддаг	Гэр бүлийн гишүүдийн нөлөө бараг үгүй	Гэр бүлийн гишүүдийн нөлөө бараг үгүй
<b>Харилцаа</b>	Удирдах-Удирдагдахуйн ёсон	Харилцан ойлголцол, хүндлэл, харилцан ашигтай	Удирдах-Удирдагдахуйн ёсны хүрээнд харилцан ойлголцол, хүндлэл

### • Нийгмийн энтрепренершип

Нийгэм, эдийн засгийн үнэ цэнийг хамтад нь бий болгох хүрээнд инновацлаг нийгмийн үйл хэрэг, арилжааны шинжтэй үйл ажиллагаа явуулах замаар нийгмийн асуудал, дутагдлуудыг засах,



шийдэх, үүгээрээ орлого олох загвартай. Нийгмийн болж бүтэхгүй бүхий л асуудал уруу орохдоо эерэг, бүтээлч сэтгэлгээгээр үр дүн гаргахын төлөө зүтгэдэг. Тиймээс нийгмийн зарим нэг сөрөг бүлгүүдийн дарамт, шахалт, шүүмжлэл зэрэг эрсдэлүүдийг инновацлаг санаачилгаараа даван туулах шинэчлэл, өөрчлөлтийг тэргүүлэх үйл явц юм. Нийгмийн энтрепренершипыг олон талаас тодорхойлон тайлбарладаг.

- Ашгийн бус нийгмийн үнэ цэн бүтээхийн тулд хөрөнгө оруулалтын стратегийн шинэ хувилбар эсвэл менежментийн төлөвлөгөө хайх үйл явц

- Салбар хоорондын харилцаагаар арилжааны компаниудын нийгмийн хариуцлагын ажиллагаа

- Нийгмийн асуудлыг бууруулах, нийгмийн хувьслыг хялбаршуулах хэрэгсэл

- Хоёр төрлийн ялгаатай байдлаар ангилагддаг: **1)** Хувийн хэвшлийн салбарт нийгмийн чиг баримжаа бүхий үйл ажиллагаа, **2)** Байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэх, урт хугацаандаа тогтвортой байдлыг хангах үүднээс сайн дурын энтрепренерүүдийн үйл ажиллагаа.

### Энтрепренерүүдийн ДАВУУ талууд <sup>10</sup>:



- ХАРААТ БУС

- АМЖИЛТЫН МЭДРЭМЖ

- ХҮНДЛЭЛ ОЛОХ

- АШИГ ОЛОХ

- ХУВЬ ХҮНИЙ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ

- НИЙГЭМД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

### Энтрепренерүүдийн СУЛ талууд <sup>8</sup>:

- ХАРААТ БУС МЭТ ХАРАГДАЖ БАЙГАА БОЛОВЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, САНХҮҮЖҮҮЛЭГЧ БОЛОН ХЭРЭГЛЭГЧ, ХАРИЛЦАГЧДЫН БАЙНГЫН ДАРАМТАД БАЙДАГ.

- БҮХ САЛБАР, МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР, МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ, ТУРШЛАГЫГ ЯМАГТ СУРАЛЦАХ ШААРДЛАГАТАЙ.

- ТОМХОН ЦАР ХҮРЭЭТЭЙ ТӨСЛҮҮДИЙГ ЭХЛҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ БОЛОВЧ ИХЭНХДЭЭ БЭЛЭН НӨӨЦ, ЭХ ҮҮСВЭР БОЛОН ӨӨРИЙН ГАНЦААРДМАЛ БАЙДАЛ ХЯЗГААРЛАДАГ.

- ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР АШИГТАЙ, ТОГТВОРТОЙ БОЛТОЛ БҮХ ЭРСДЭЛИЙГ ӨӨРӨӨ ҮҮРДЭГ.

- ИХЭНХДЭЭ ТУРШИЛТЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД ДЭЭР АЖИЛЛАДАГ ТУЛ ТЭР БОЛГОН АШИГ ОЛЖ ЧАДДАГҮЙ.

- АЖЛЫН ЦАГ ГЭЖ БАЙХГҮЙ. НЭГ ӨДРИЙН 24 ЦАГ, АМРАЛТ, БАЯРЫН ӨДРҮҮДЭЭР ӨМНӨӨ ТАВЬСАН ЗОРИЛГЫН ТӨЛӨӨ АЖИЛЛАДАГ.

- АМЖИЛТЫН ӨМНӨ МАШ ОЛОН АЛДДАГ.

- ЭРҮҮЛ МЭНДДЭЭ БАГА АНХААРДГААС БИЕИЙН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ЭМГЭГҮҮДТЭЙ БАЙХ НЬ ЭЛБЭГ.



## ХАВСРАЛТ 5.

### ЭНТЕРПРАЙЗ САНААНУУДЫН ЖАГСААЛТ



ОРОН НУТАГ ДАХЬ ХЭРЭГЦЭЭ

НӨАТ-ИЙН БАРИМТ БҮРТГЭХ

ДОТУУР БАЙРНЫ БАГА НАСНЫ ХҮҮХДЭД  
ТУСЛАХ

ХИЧЭЭЛИЙН ХОЦРОГДОЛ НӨХӨХ

ДОТУУР БАЙРНЫ УС ХАЛААХ

ХҮҮХЭД ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИАС ГЭРТ  
ХҮРГЭХ

УНДНЫ УС ЗӨӨХ

ГЭР ЦЭВЭРЛЭХ

АХМАД НАСТАНД ТУСЛАХ

ГАР УТАСНЫ АППЛИКЕЙШН СУУЛГАХ,  
ТОХИРУУЛАХ

ХАШАА ЦЭВЭРЛЭХ, БУДАХ

ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ

ГЭР АХУЙН ТАВИЛГА ХЭРЭГСЭЛ ЗАСАХ

ЦАХИЛГААН ХЭРЭГСЭЛ ЗАСАХ

DDISH ТОХИРУУЛГА ХИЙХ

ДЭЛГҮҮРЭЭС БАРАА ХУДАЛДАН  
АВАХАД ТУСЛАХ

КОМПЬЮТЕР ДЭЭР БИЧИГ БАРИМТ ШИВЭХ,  
ХЭВЛЭХ

МАЛ ХАРИУЛАХ

ХАДЛАН ХАДАХ

НООС, НООЛУУР САМНАХ

ТҮЛЭЭ ТҮҮХ, БЭЛТГЭХ

МАЛЫН ХАШАА ХОРОО БАРИХ, ЗАСВАРЛАХ,  
ХӨР БУУЦ ГАРГАХ

ГОО САЙХНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАЛУУН УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЦАС ЗАСВАРЛАХ, ОЁХ

БАРИЛГЫН ЗАСВАР

СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
ҮЙЛЧИЛГЭЭ

АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ЗУРАГ АВАХ ҮЙЛЧИЛГЭЭ

ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

КЛУБ АЖИЛЛУУЛАХ (ШАТРЫН, НААМАЛ  
УРЛАЛЫН ГЭХ МЭТ

МОРЬ УНАХАД СУРГАХ СУРГАЛТ

МАЛЫН АРЧИЛГААНЫ СУРГАЛТ

АСАРГАА, СУВИЛГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

РАДИО СТАНЦ

ХОГ АНГИЛАЛ

ХОГ ЦЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ


## ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН “ЭНТРЕПРЕНЕРШИПД СУУРИЛСАН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР” ТӨСЛИЙН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖИШЭЭ

### Эхний үе шат

- Зорилтот сумын 14-25 насны иргэн байх
- Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалтад хамрагдсан байх
- Төслийн баг нь 3-6 хүний бүрэлдэхүүнтэй, тэдгээрийн тал нь эмэгтэй байх
- Баг нь удирдагчтай байх
- Төслийн хугацаа 3-6 сар байх
- Төслийн санал нь өгөгдсөн загварын дагуу бүрэн боловсруулагдсан байх
- Төслийн санаа нь зорилтот сумын байгаль орчин, нийгэм, хүүхэд хамгаалалд ямар нэг сөрөг нөлөөгүй байх

### Хоёр дахь үе шат

- Төслийн санааг хэрэгжүүлэх салбар нь тухайн сум, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцтэй байх
- Тодорхой хэмжээний ашигтай ажиллах боломжтой байх
- Бүтээлч, шинэлэг санаатай байх
- Хүний нөөцтэй байх (Багийн гишүүдийн ажил үүрэг, хариуцлага тодорхой, тэгш хуваарилалттай байх)
- Төслөө танилцуулах ур чадвар сайтай байх
- Төсөл 6 сар тогтвортой хэрэгжих боломжтой байх, шаардлагатай нөөц тухайн орон нутагт байдаг, энэ нөөцийг сумын засаг захиргаа болон сургуулиар дамжуулан ашиглах боломжтой (ялангуяа сургуулиас гадуур байгаа хүүхэд залуучуудад энэ их чухал шалгуур)



*Танд*  
АМЖИЛТ  
ХҮСЬЕ.



Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)

